



**ТӨГС ГЭГЭЭСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН СУРГААЛИЙН ТОВЧ ТОЛЬ**

## **АГУУЛГА**

### **АВШИГ**

**АВШИГ ХҮРТЭХ БОЛЗОЛ**

**АВШИГТАН**

**АВШИГИЙН ҮНЭ ЦЭН**

**АДИСЛАЛ**

**АМЬДРАЛ**

**АНАГААХГҮЙГЭЭР АНАГААХ**

**АРИУН НЭР**

**АРЪАБАЛЫН БУЮУ ГЭРЭЛ, АЯЛГУУНЫ БЯСАЛГАЛ**

**АРЪАБАЛЫН НОМЫН ЦОГЦ**

**АУРА**

**АХУЙ ОЙЛГОЛТ**

**АЯЛГУУ**

**БАГШ**

**БАРИЛДЛАГА**

**БИ ҮЗЭЛ**

**БИЕ МАХБОД**

**БИЛИГ НЭЭГДЭХ**

**БОДИСАД / БОДИСАДВА**

**БОДОЛ**

**БУДДА**

**БУРСАН ХУВРАГ**

**БУРХАН**

**БУРХАН ЧАНАР**

**БУРХАНЫГ БУЮУ ИХ БАГШИЙГ ДУРСАХ (САНАХ)**

**БУРХАНЫ ОРОН**

**БЯСАЛГАЛ**

**ВЕГАН ХООЛ ХҮНС**

**ГЭГЭЭЛИГ, САЙН, МУУ ЧАНАР**

**ГЭГЭЭРЭЛ**

**ГЭРЭЛ, АЯЛГУУ**

**ГЭТЛЭГДЭХ**

**ГЭТЭЛГЭХ**

**ДААТГАЛ**

**ДАО**

**ДАЙН**

**ДИЯАН**

**ДОТООДЫН БАГШ / ДОТООДЫН БУРХАН**

**ДЭЛХИЙН ДУЛААРАЛ**

**ДЭЛХИЙ**

**ДЭЛХИЙН НАС**

**ДЭС**

**ЁС СУРТАХУУН**

**ЖИНХЭНЭ БАГШ**

**ЗАЛБИРАЛ**

**ЗОВЛОН**

**ЗОЛИОС**

**ЗЭН**

**ИНЭЭД**

**ИТГЭЛ**

**ИХ БАГШ**

**МАХАН ХООЛ**

**МОНГОЛ / МОНГОЛЧУУД**

**МӨН ЧАНАР**

**МӨР**

**НИНЖИН СЭТГЭЛ**

**НИРВААН**

**НЭГ ҮЗҮҮРТ СЭТГЭЛ**

ОГООРОЛ  
ОРШИХУЙ  
САЙН БА МУУ  
САМАДИ  
САХИЛ  
САХИУЛСАН ТЭНГЭР  
СУРГААЛЬ / НОМЛОЛ  
СУУТ ХҮМҮҮС  
СҮНС  
СҮСЭГ БАРИЛДЛАГА  
СЭТГЭЛ  
ТАЛАРХАЛ  
ТӨВ ҮЗЭЛ  
ТӨГС ГЭГЭЭРЭЛ  
ТӨЛБӨР  
ТӨРӨЛ АВАХ  
ТУУЛАН ТОНИЛОХ  
ТҮҮНЧИЛЭН ИРСЭН  
ТЭВЧЭЭР  
УДИРДАГЧ  
УХАМСАР  
УХАМСРЫН ТӨВШИН  
ҮЙЛДЭХГҮЙГЭЭР ҮЙЛДЭХ  
ҮЙЛИЙН ҮР  
ҮНЭН  
ҮНЭНЧ СЭТГЭЛ  
ҮХЭЛ  
ХАЙР  
ХАЙРЛИГ ЧАНАР  
ХИЙХГҮЙГЭЭР ХИЙХ  
ХООСОН ЧАНАР  
ХҮН  
ХҮЛЦЭНГҮЙ БАЙХ  
ХҮСЭЛ  
ХҮСЛЭНГҮЙ БАЙХ  
ЦЭВЭР АРИУН БАЙДАЛ  
ЧӨЛӨӨЛӨГДӨХ  
ЧИНАГУУХ ЕРТӨНЦ  
ЦАГААН ХООЛ  
ШАВЬ  
ШАШИН  
ШИД  
ЭЗЭН БУРХАН  
ЭНХ ТАЙВАН  
ЭРХЭМ АРИУН ЧАНАР  
Ашигласан бүтээл, эх сурвалж

## ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН СУРГААЛИЙН ТОВЧ ТОЛЬ

### **АВШИГ**

Үзэх: Гэтлэгдэх

Хүний амьдралын зорилго нь Бурханыг танихад оршино. Бурханыг таних гэдэг нь бид аугаа их гэдгээ, бүхэл орчлонгийн хүчний хэсэг нь юм гэдгээ мэдэхийг хэлнэ. Хэдийгээр хэсэг нь гэж хэлж байгаа ч үнэндээ бол бүхэлд нь гэж хэлж байгаа хэрэг юм. Завсрын салангид жижиг холбоосууд Авшиг авах үед эргээд холбогдчихдог юм. Бид дотогшоогоо хандаж, дотоод уруугаа нэгдэж байвал нь залгагдан холбогдож, залгагдсан л бол бүх л орчлонтой нэгдмэл болно. Ингэж бид бүрэн бүтэн болно. Энэ нөхцөлд бид ойртсон хэн бүхнийг гараа хүргэлгүй, түүнд зориулж тусгайлан юу ч хийлгүйгээр адислах болно. Бид хэн нэгнийг сонирхох юмуу цусан холбоотой бол тэд аврагдах буюу бусад хэлбэрээр адислагдана (56).

Авшиг бол билгийн мэлмий нээх ажиллагаа юм. Таны анхдагч эерэг хүч гэсэн үг. Та өөрийнхээ эзэн нь болно (15).

Сэтгэлийн Авшиг хүртэх нь хамаг амьтныг гэтэлгэж байгаа хэрэг юм. Аяндаа хамаг амьтныг гэтэлгэнэ. Та нар хаа очно, тэр газар цэвэрших болно. Учир нь Авшигтан бээр Багшийнхаа хүчийг тархааж энэхүү ертөнцийг цэвэршүүлж байдаг (6, х 185).

Сэтгэлийн Авшиг хүртмэгц Бурхан болно. Авшигтнууд бүгд Бурхан. Гэвч өөртөө итгэлгүй учир Бурхан биш байна. Хожим туршлагажиж, олон барилдлага нийлмэгц Бурхан болсноо мэднэ. Агшин зуур билиг нээгдэх номын цогц нь мөн чанараа хоромхон үзээд Бурхан болох нь дамжиггүй (3, х 135).

Бурханы гэрлийг олж үзвэл Бурхантай нэгэн цогц болж Бурхан болно. Хэзээ Бурхан болохоо хүлээсний хэрэггүй, сэтгэлийн Авшиг хүртмэгц Бурхан болно. Бурханы аялгуу сонсвол их, бага ч гэсэн Бурхантай нэгэн цогц болох юм. Доод зэргийн аялгуу ч Бурханы аялгуу, доод зэргийн гэрэл ч Бурханы гэрэл болно (3, х 137). Сайн бясалгаж бүрэн гүйцэд дияанч хүчтэй болоод хамаг амьтныг гэтэлгэх үед Бурхан болсноо мэднэ. Гэвч хамаг амьтныг гэтэлгэхэд ном хаялцах эрдэм, билиг ухаан хэрэгтэй (3, х 138).

Авшиг хүртэнэ гэдэг нь шинэ эмх журмаар шинэ амьдрал эхэлж байгаа хэрэг юм. Энэ нь Багш таныг гэгээнтнүүдийн хүрээлэлд харъяалагдахыг зөвшөөрч хүлээн авсныг илэрхийлж байгаа юм. Тэр үеэс эхлэн та жирийн нэгэн байхаа больж өндөр дэсэд хүрсэн хэрэг. Үүнийг Багшийн авралд багтах гэдэг (2, х 122-123).

Авшиг хүртсэний дараа тамд хуримтлагдсан үйлийн үр байхгүй болох учраас та өөрөө хүсэхгүй бол дахин төрөл авах хэрэггүй болно. Хэрэв дахин төрөл авъя гэвэл үйлийн үр үүсгэх юм уу, эсвэл олон амьтнаас үйлийн үр зээлдэж болно. Авшиг нь аливаа амьтан урьд төрлийн бүх үйлийн үрийг устгаж, ирээдүйд эргэж төрөх боломжгүй болгодог юм (2, х 52). Бурханд хүрэх цорын ганц зам бол Авшиг юм (2008.9.10).

Авшиг хүртэнэ гэдэг бол агуу их сүнсээ танин ухаарах агшныг илэрхийлж байгаа юм (2, х 102). Авшиг хүртэх нь зөвхөн эхлэл, гэхдээ маш мундаг эхлэл. Учир нь ихэнх хүн доод хүрднээсээ эхэлж бясалгасаар дээд хүрдэнд хүрдэг. Энэ нь 10 жил ч шаардаж мэднэ. Харин Арьяабалын бясалгалаар бид дээд хүрднээсээ эхэлдэг. Биднийг гэрэл харуулахын тулд Багш бүх хүчийг толгойн оройд татаж авчирдаг юм. Энэ бол Бурханы оронд хүрэх үйл бөгөөд шавь олон орд харшаар дайрч гарах болно. Энэ аргыг уламжлах үед бид юу ч ярьдаггүй, харин шавь нар хамгийн сайн гэгээрлийг олж авна. Гэхдээ өмнө маань нээж таних олон олон түвшин байдаг учраас цааш бясалгасаар байх болно. Бурханы дуу хоолойн дотоод хэлбэлзлийг

чихнийхээ оролцоогүйгээр сонсоно. Бурханы төрлийг нүднийхээ оролцоогүйгээр харна (2, х 123-124).

Авшиг хүртэн Арьяабалын бясалгалд (Quan Yin Method) орох нь тийм тайлагдашгүй нууц ёс буюу шинэ шашинд орж буй хэрэг биш юм. Их Багш Чин Хай Авшигийг “Оюун санаагаараа уламжилдаг” юм. Бурханлаг Оршихуйг анхлан мэдрэх ахуй ойлголт чимээгүйгээр өгөгдөнө. Таны энэ “үүд”-ийг нээж өгөхийн тулд Их Багш Чин Хай заавал өөрийн биеэр байх шаардлагагүй. Номыг сэтгэлээр сэтгэлд уламжилна. Энэ сэтгэл бидний уг сэтгэл, үнэн сэтгэл юм. Дияан үг хэрэглэдэггүй гэдэг нь энэ (5, х 106).

Энэ Уламжлан өгөх үйл явц бол Бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь юм. Багшийн Аврал үгүй бол бясалгалын арга техник нь өөрөө ашиг тус багатай.

Сэтгэлийн авшиг хүртэх үед та агшин зуур дотоодын Гэрэл үзэж, дотоодын Аялгуу сонсож болдог учраас заримдаа энэ үйл явцыг “гэнэтийн” буюу “агшин зуурын гэгээрэл” гэж нэрлэдэг юм.

### **АВШИГ ХҮРТЭХ БОЛЗОЛ**

*Үзэх: Сахил*

Их Багш Чин Хай ямар ч шашин шүтлэг, соёлын уламжлалтай хүмүүст сэтгэлийн авшиг өгөхийг зөвшөөрдөг. Та одоогийн шашин суртахуун эсвэл итгэл үнэмшлийн тогтолцоогоо өөрчлөх албагүй. Цаашид ахиж дэвшихийг хүсвэл өөрийгөө өөрөө хариуцахаас биш өөр ямар ч уяа хүлээсэнд баригдахгүй. Нөхцөл нь гэвэл ямар ч дадал туршлагын шаардлагагүй. Аль нэг йог юм уу бясалгалын тухай өмнөх мэдлэг хэрэггүй. Гэхдээ танаас веган хоолтон болохыг хүсэх болно. Насан туршдаа веган хоолтон байх нь сэтгэлийн авшиг хүртэхийн тулд хангах зайлшгүй нөхцөл шаардлага болно (23).

Сэтгэлийн авшиг хүртэхэд үнэ төлбөр авахгүй. Арьяабалын Бясалгалын /Гуань Инь/ Аргаар өдөр бүр бясалгаж, Таван Сахилыг сахих нь л сэтгэлийн авшиг хүртсэний дараа таны биелүүлбэл зохих шаардлага юм. Сахил бол таныг өөртөө болоод өөр бусад амьтанд хор хүргэхгүй байхад туслах дүрэм юм. Энэ бясалгал дасгал нь гэгээрлийн тухай таны анхны ахуй ойлголтыг бататган гүнзгийрүүлж, эцэст нь танд өөрийн тусын тулд Бурханлиг оршихуйн буюу Гэгээрлийн хамгийн өндөр түвшинд хүрэхэд тусална. Өдөр дутмын бясалгал дасгалаа хийхгүй бол та гэгээрлээ бараг гарцаагүй мартаж, энгийн ухамсрын түвшиндээ буцаж ирэх болно (23).

Их Багш Чин Хайн зорилго бол биднийг өөрсдийнхөө хүч чадалд итгэж сэтгэл хангалуун байхад сургах явдал юм. Тийм болохоор Тэрбээр аливаа хүн, ямар нэг дэмжлэг тусалцаа, урьдчилсан бэлтгэлгүйгээр бие даан бясалгаж болдог энэ аргыг заадаг билээ. Тэрбээр шүтэн бишрэгч, шавь, дагалдагч эрдэггүй, бас гишүүний татвар хураамж төлөх байгууллага байгуулдаггүй юм (23).

Тэр таны мөнгө, бэлэг сэлт, залбирал мөргөлийг хүлээж авахгүй, тийм болохоор түүнд ийм зүйл өргөх хэрэггүй юм. Тэр таныг Бурхан чанартаа дэвшин хүрэхийн тулд өдөр дутмын амьдралдаа болоод бясалгал хичээлдээ чин сэтгэлтэй байхыг тань л хүлээн авах болно (23).

### **АВШИГТАН**

*Үзэх: Авшиг, Арьяабалын номын цогц, Шавь*

Авшигтан хаа явсан ч, ямар ч нөхцөлд хүмүүсийг болон орчин тойрноо адислана (40). Бид энэ дэлхийг адислахаар, мөн өөрийнхээ аугаа ихийг таньж мэдэхээр энд байгаа юм. Бид өөрийгээ аугаа их гэж мэдмэгц бүхий л орчлонгийн хүчтэй нэгдмэл болно. Тэгээд бидэнтэй холбогдсон хэн ч бай орчлонгийн энэ хүчээр адислагдах болно (56).

Бясалгагч нар өөрсдийгөө амар амгалан, аз жаргалтайгаар мэдэрдэг, аливаа бүхэнд санаа зовнихгүй ханддаг. Бас бусад хүмүүс аливаа зүйлийг ноцтой байдлаар хүлээж аваад, салж ядан зууралдаж байхад тэд энэ амьдралд тохиолдох ямар ч утгагүй хөгийн зүйлс, бусад хүн хийгээд өөрсдийгөө шоолон инээж чаддаг. Бясалгаж эхэлсний дараа ямар нэг байдлаар сул чөлөөтэй болж, тийм “сүрхий чухал” улс байхаа больдог юм. Хэрвээ маргааш үхэх л бол үхнэ, амьдрах л бол амьдарна. Хамаг юмаа алдчихсан бол алдаа л биз, хэрэв бүх юм байгаа бол тэр л биз.

Гэгээрсний дараа ямар ч нөхцөлд өөрийгөө аваад явчих хангалттай билиг ухаантай, авъяас чадвартай болно. Тэгээд юунаас ч айж эмээдэггүй. Бид айдас хүйдэс, зовлон түгшүүрээ хаячихсан. Тийм ч учраас амар амгалан байдаг хэрэг. Бид энэ ертөнцөд татагдаж хоргоддоггүй.

Олж авсан, алдаж гэсэн зүйлс маань бидэнд нэг их юм байхаа больдог. Хэрэв ихээхэн олз ашиг олвол түүнийгээ гагцхүү бусад хүний тусын тулд мөн ойр дотныхны ашиг тусын төлөө өргөчихдөг юм. Түүнээс биш бид өөрсдийнхөө бие болон амьдралаа тэр их тэмцэл зөрчил, зовлон бэрхшээлийг туулан байж хадгалж хямгадаад байх тийм чухал зүйл гэж үздэггүй. Хадгалж хямгадаж байгаа бол болж л байна. Энэ нь бид өдөржингөө орон дээр, битүү хадаас арзайлгасан йогийн дэвсгэр дээр суугаад л бясалгаад л байж байдаг гэсэн үг биш.

Бид ажиллаж хөдөлмөрлөдөг. Гэгээрсний дараа амьдрал маань нэн амар хөнгөн болдог учир санаа зовоод байх шаардлага огт үгүй гэдгийг мэдэрдэг. Бид зүгээр цаанаасаа л нэг санаа амар байдаг юм (23).

## **АВШИГИЙН ҮНЭ ЦЭН**

*Үзэх: Авшиг, Аръяабалын номын цогц, Аръяабалын бясалгал, Үхэл*

Авшиг бол сая жилд ганц тохиох боломж юм (69).

Авшиг хүртэх нь орчлонгийн хамгийн үнэт бэлэг мөн (57).

Авшигаар та Бурхан чанараас өөр юуг ч олж авахгүй. Гэхдээ үүнийг солиод авчих юм танд юу ч байхгүй, үүнийг худалдаж авах юу ч байхгүй. Та мянган жил мөргөж залбираад ч энэ бэлгийг авч чадахгүй. Энэ бол таны энэ хорвоогоос олж авч чадах хамгийн аугаа зүйл юм (23). Авшиг бол маш агуу хүч юм (37). Их хүчийг үгээр илэрхийлэх аргагүй. 7-9 үеэ аврах боломжтой. Бас огт мэдэхгүй өнгөрсөн элэнц дээдсээ, мөн хэзээ төрөх нь тодорхойгүй хойч үе тань цусан холбоогоор дамжаад чөлөөлөгдөнө (38).

Энэ бол агшин зуур билгийн мэлмий нээгдэж Мөн чанартайгаа учрах агшин зуурын гэгээрэл юм. Авшиг хүртмэгц Бурхан болно (3, х 135).

Их Багш Авшиг хүртээх үедээ таныг дээш хол татна. Авшиг хүртсэний дараа танд хуримтлагдсан үйл үр байхгүй болох учраас хэрэв өөрөө хүсэхгүй л бол дахин төрөл авах хэрэггүй болно (1, х 135).

Сэтгэлийн Авшиг хүртмэгц Бурхан болно. Та нар бүгд Бурхад. Энд байгаа хүмүүсийн дотор Бурхан болоогүй нэг ч хүн байхгүй. Гэвч өөртөө итгэлгүй учир Бурхан биш байна. Туршлагажаад ирэхээрээ, хожим олон барилдлага нийлмэгц Бурхан болсноо мэднэ. Хэзээ Бурхан болохоо хүлээх хэрэггүй. Авшиг хүртмэгц Бурхан болно (3, х 135). Сайн бясалгаж бүрэн гүйцэд дияанч хүчтэй болоод хамаг амьтныг гэтэлгэх үед Бурхан болсноо мэднэ (боть 3, х 138).

Авшиг хүртээд орхигдсон хүн гэж байдаггүй. Оройн Дээд Их Бурханы Вант Улстай холбогдоогүй авшигтан гэж байхгүй. Надаас Авшиг хүртээд юу ч үгүй хоосон хоцорсноос тэнгэр нурж унах нь хавигүй хялбар” (10).

Сэтгэлийн Авшиг хүртэх нь хамаг амьтныг гэтэлгэж байгаа хэрэг. Аяндаа хамаг амьтныг гэтэлгэнэ. Учир нь шавь нар Багшийнхаа хүчийг түгээж энэхүү ертөнцийг цэвэршүүлж байгаа юм (3, х 185).

Хэн нэг нь Их Багшаас авшиг хүртвэл урагш 5-7 үе нь чөлөөлөгдөж, үүнээс ч илүү үеийг, өөрөөсөө хойших мөн төчнөөн үеийг гэтэлгэх ба энэ үеүдэд хамаарах мал амьтан, бас тэдний ах дүүс төрөл садан, мөн найз нөхөд бүгд чөлөөлөгдөнө (74).

Авшиг хүртсэнээр 5, 6, 7, түүнээс ч олон үеийн хамаатнууд чинь чөлөөлөгдөнө. Тэднийг биеэ орхисны дараа Багш өндөр төвшинд тэдэнд зааж сургах болно. Тийнхүү тэднийг бас анхаарсаар байх юм. Та нар хэрэв хүсэхгүй бол эцэг эх тань хэзээ ч эргэж төрөхгүй. Харин тэд энэ дэлхийгээс нэгэнт явчихсан бол хэд дэх үе гэдэг нь хамаагүйгээр чөлөөлөгдөх болно. Энэ насандаа хэнд хайртай байсан, хэнийг энэрэн хайрлаж байсан бүх хүмүүс, бүр муур, нохой нь хүртэл ач тусыг нь хүртэнэ. Тиймээс Авшиг бол маш агуу хүч юм (37).

Аръяабалын бясалгалаар зөвхөн та өөрөө чөлөөлөгдөөд зогсохгүй найз нөхөд, хамаатан садан, хойч үе тань бас чөлөөлөгдөнө. Тэд энэ дэлхийгээс явсан бай, яваагүй ч бай хамаагүй чөлөөлөгдөнө. Тэднээс чинь хэн нэг нь тамд байсан ч чөлөөлөгдөнө.

Багш дотны хайртай бүхэнд тань тусална. Гэхдээ үйлийнх нь үр ба явал түүнд ач тустай вэ гэдэгт нь тохируулдаг (2, х 116).

Хэрэв хэн нэгэн санадаг л юм бол Багш түүнийг лавтай орхихгүй, аль болохоор арга сүвэгчилж аврах болно (6, х 16).

Шавь өөрийн найз нөхөд, хайртай бүхэндээ тусалж, зөвхөн тав, зургаа, есөн үедээ ч биш, хайртай бүхнээ дагуулаад, бүр тэдний нохой, муурыг нь хүртэл аваад дээш явна.

Учир нь Багш амьдрал үхлийг удирдаж, сансар огторгуйн хуульд суралцсан байдаг. Тиймээс шавь нартаа гайхалтай зүйл хийхэд нь тусалж чаддаг, шавь нарынхаа хайртай бүхний сүнсийг аварч өргөх чадвартай байдаг (39).

Авшиг гээч зүйл ямар аугаа шагнал вэ гэж мэдэхдээ та балмагдах болно. Энэ бол үнэхээрийн гайхамшиг. Ямар гайхамшигтай гэдгийг би үгээр тодорхойлон илэрхийлж чадахгүй байна. Би зөвхөн таны төлөө л баяртай байж чадна. Та үнэхээр азтай, тийм ээ, их азтай.

Хэн нэгэн, танаас илүү өндөр оршинолууд ч энэ Авшигийг авч чадаагүйдээ танд атаархах болно. Яагаад гэвэл та тэргүүн өндөрлөгт байгаа учраас л танд атаархаж байгаа юм. Тэнд оюунлиг оршинолууд буюу сахиусан тэнгэрүүд, эс бөгөөс сүйтгэгчид (Орчлонгийн янз бүрийн хязгаар оронд амьдрагсад) байдаг. Тэд нэг л өдөр үхдэг бол та үхэхгүй. Тэд доошилно, харин та тэгэхгүй. Та бүх цагийн туж тэдний хажуугаар өнгөрч, улам алдаршиж, улам гоо сайхан болж, тэднээс хавигүй өндөрт дээш явж байх болно. Тэднийг гурван ертөнц дотор аргаа олж ядан байхад та харин Бурханы дэргэд байна. Ийм Авшигийг хүртэх үнэхээр хэцүү. Энэ тухай бодоход, ээ Бурхан минь, яанаа гэмээр болдог юм. Хонжворт сугалаагаар 6 сая ам.доллар яаж хожихыг мэдэх үү. Үүнийг оюун санааны ертөнцөд буулгаж харьцуулвал ийм л юм болно. Бүхий л орчлонд та хамгийн сайн нь, шилмэл ганц нь, аргагүй сонгогдсон нь, хамгийн их хувь заяатай нь байх болно. Үнэхээр тэр мөчийг хүртэл та юу ч мэдэхгүй. Эцэг эх тань таныг гэртээ харихыг үнэхээр хүсэхийг мэдмэгц... Бурхан минь, та үүнийг төсөөлж ч чадахгүй (57).

## ***АДИСЛАЛ***

Хүмүүн бид азтай юмаа. Эргэн тойронд маань хаа сайгүй адис хүч. Оюун санааны, нарны, салхины, мод, мал амьтны адис хүч. Би энэ бүхэнд өдөр бүр талархдаг. Хичнээн их талархана, адислал төчнөөн их бууна. Төвшин тань дээшлэх тусам улам их адислалыг шингээж авна. Мал амьтан, мод, ургамал, бүгд л хариу нэхэлгүй өгч байдаг.



Хүмүүн бид талархалтай байхдаа өөртэйгээ болон эргэн тойрныхоо юмстай нэгдэл зохиролд орж байдаг ба биднийг ийм даруухан байхад тэд адислалаа буулгадаг. Даруу байна гэдэг нь эго байхгүй гэсэн үг. Эго үгүй гэдэг нь Бурхан чанар маань илүү гэрэлтэнэ гэсэн үг. Бурхан чанар тань эгогоос их байж гэмээнэ та сайн чанар, бурхан чанартайгаа нэгдмэл байж өөртөө адислах хүч их агуулна. Энэ чанар чухамдаа зүрхэнд оршдог.

Адислаж өгөөч гэж Надаас бүү гуй. Өөрөө өөрийгээ адисла. Болзол нөхцөлгүй эрхэм чанараар өөрсдийгээ адисла, хязгааргүй хайраар өөрийгээ адисла. Өчүүхэн явцуу бүү бай. Гуйлгачин аятай бүү бай. Учир нь та цаг үргэлж адислагдаж байгаа. Бүр 24, 25 цаг шүү. Багшийгаа байхгүй ч адислагдсангүй гэж бүү зов. Багш чинь адислаж байгаа, тэр бүүхэл юу хийж байгааг чинь ч мэдэж байгаа. Нарны адислалыг хүртээ гэвэл түүний болзол нөхцөлгүй чанарыг сана. Нар ивээснийхээ төлөө эргээж танаас юу ч нэхдэггүй шиг, сар, од эрхэс, мод, агаарын аль нь ч юу ч хүсэхгүй адисладаг. Тэдэн шиг бай. Энэ бол ухамсрыг дэвшүүлэх арга зам ба хариу нэхэлгүй, болзол нөхцөлгүй байж гэмээ нь бусдыг адислаж чадна гэсэн үг.

Өгсөн ч, авсан ч тэнд “би” байхгүй бай. Хэрэв хүссээр л байвал миний адислалыг ч хүртэж чадахгүй. Энэ бол доод түвшин. Юуг ч бүү хүс, зүгээр л бай. Тэр юм таных болох ёстой бол хүрээд л ирнэ, тэгэхээр хадгалчих. Ямарваа юмыг хүсэх нь танд маш муу. Хүссэн зоргоор олддог ч юм биш, энд би оюун санааны адислал, хүч, төвшин ч мөн адил хамаарна (72).

*Дээд төрөлтнүүд, оюун санааны бясалгал, байгалийн болон бусад төрлийн адислал (73). (72).*

Хэдийчинээ ёс суртахуунтай бол та төдийчинээ сахиусан тэнгэрүүдтэй байна. Энэ бол бодит зүйл. Жишээ нь, нийт адислалыг 100% гэвэл: Сахиусан тэнгэрүүд таныг 5%, бурханлиг төрөлтнүүд 5% тус тус адислана. Та буруу юм хийдэггүй бол, ногоо хоол зооглодог бол бүх цаг хугацаанд улам их адислал хүртэнэ.
Бясалгал хийдэггүй хүн 5% адислагдана.
Бясалгадаг бол 15% (Учир нь тэдгээр хүмүүс ухамсрын өндөр төвшинд байдаг. Төвшин дээшлэх тусам адислалын хувь өндөр байна).
Хэрэв та гэрэл бясалгадаг бол, жишээ нь “Ум” юмуу “Ум Мани Падме Хум”, эсвэл Випашна, Хатха болон Ража Йог мэтийн амьсгалын бясалгал хийдэг бол 5%-ийн оюун санааны адислалын оноо нэмж олно.
Гуань Инь бясалгагч өдөр бүр 30-40% нэмүү бясалган веган хоолтой бол дунджаар: Өдөрт 3 удаагийн веган хоолтой бол нэмж 10%, түүнээс оноо олно. Өдөрт 2 удаагийн веган хоолтой бол 20% оноо олно. Өдөрт 1 удаагийн веган хоолтой бол 40%-иас дээш оюун санааны оноо олно.
Агаар хоолтон бясалгагч бол оюун санааны 30-70% оноо олно.
Дээд төвшний Их Багш, гэгээнтнүүд таныг 500% адислана.
Тав дахь төвшнөөс дээших Их Багш шавиа оюун санааны 4000 % -ийн оноогоор адислана. Дээд Их Багш нар, тухайлбал Есүс болон Буддагийн зиндааны Их Багш нар цаг үргэлж, өдөр бүр оюун санааны 4000 % оноогоор адислана. Тэдний ойр байгаа бол, тэдэнтэй нэг гараг дээр байгаа бол, мэдээж хичнээн ойр байх тусам илүү адислагдана. Веган /ногоо хоол/ бус хоолтой, бясалгадаггүй нэгэн 3 % адислагдана. Учир нь тэднээс мал, амьтны холбогдолтой үйл үр, муу төлөөс, бусад иймэрхүү зүйлүүд суутгагдан тооцогдох учиртай юм. Тэгээд үлдэх нь ердөө 3 %.
Дэлхий дээр байгаа 9-р төвшний Их Баш шавиа ойролцоогоор 30 000 % адислана. Энэ нь алс хол оршин суудаг шавьд хамаарах ба Их Багшийн ойр байгаа бол илүү адислагдана.
Жирийн гэгээнтэн, тухайлбал цагаан хоолтой, Гуань Инь-ээс бусад аль нэг бясалгал хийдэг энэтхэг лам таныг өөрийн буянаар 30% адислана. Энэ адислал аяндаа хийгдэнэ.
Дээд ертөнцийн төрөлтнүүд биднийг өдөр бүр 10-60% адислана.
Цэвэр агаарт элс, газар шороон дээр хөл нүцгэн явбал 5% адислагдана.
Мод тэвэрвэл 1 мод таныг 15%, мөн жижиг ургамал ч бас адислана.
Сарны адислал 40%.
Харагдаж буй одны адислал 40%. Үл харагдах холын одод арай бага адислана.



Далайн адислал маш их, нар, гол, ус, салхи, агаар ойролцоогоор 10-15% адислана.
Ил задгай орчинд бясалгавал орон сууц мэтэд бясалгаснаас 59% илүү адислагдана. Барилгын хана зузаарах тусам адислал буурна.
Цэцэрлэгт зугаалвал, тэнд амарч суунгаа бясалгавал хаа нэгтээ, өрөө тасалгаанд ч юмуу сууж бясалгаснаас илүү адис хүртэнэ.
Үс бас адисладаг: урт үс 5%. Урт гээгнээс ахиад 5% нэмүү оюун санааны оноо хүртэнэ.

### *Амьтны адислах хүч (73)*

<i>Амьтны төрөл</i>	<i>Адислах хувь, %</i>
Нохой өдөр бүр	3
Миний ноход цагаан хоолтой, Надаар хайрлуулдаг тул тэд надад эргээж 6-8% адис хүртээдэг. Өөрсдийг нь хайрладаггүй хүнийг тэд адислахгүй шүү.	6-8
Цагаан хоолтой нохойн адислал	3
Цагаан хоолтой бус бол	2
Дунд зэргийн биетэй шувуу	4
Том тотьны адислал	8
Цацагт хяруул	5-10
Тахиа 2-6%, цагаан хоолтой бол	10
Молтогчин туулай	4-6
Үнээ	7-15
Гахай	5-10
Хонь	5-10
Адуу	6-15
Заан	40
Ямаа	5
Зэрлэг бар	2
Арслан	1
Галуу	15
Эрвээхэй	1
Зэрлэг шувуу, цахлай	8
Матар	2
Зэрлэг гахай	8
Яст мэхий	15
Шилүүс	2-6
Үнэг	4

*Хэрэв амьтнаар хоолловол бидний буян тухайн амьтанд шилжиж буян маань барагдана.*

### **АЖИЛ**

Хэрэв бид ажилдаа үнэхээр анхааралтай хандвал юу ч хийсэн ямар нэг юм сурч авдаг. Энэ нь үлгэр дуурайллыг даган ажиллах зуураа өөр бусад зүйлийг ойлгож мэддэгтэй адилхан. Тийм ч учраас заримдаа бид ажил хийхээрээ гэнэт олон зүйлийн талаарх үнэнийг ухаардаг. Ажил гэдэг бол өөрсдийгөө дарж зөөлрүүлэхэд болон хувийн зан чанар, тэсвэр хатуужил, авъяас чадвар, гэгээрлийнхээ түвшинг хэмжихэд тус болдог арга юм. Тэгэхээр та нар ажиллахаас айх хэрэггүй. Ажлаас айна гэдэг нь мөн нэгэн төрлийн сэтгэцийн өвчин юм. Бид хэдийчинээ их ажиллана, төдийчинээ их гэгээрнэ.

Аливаа ажлыг гавъяа шагналын төлөө бус, зөвхөн хайрын үүднээс хийхэд бүх зүйл огт саадгүй бүтдэг. Энэ ажлаас өөрт ч юмуу хэн нэгэнд ашиг тус гаргах гэж сэтгэл зовних хэрэггүй. тухайн үед хийх ёстой юмаа л хийдэг. Ийм байвал оюун санааны амьдрал

маань өдөр өдрөөр сайжирч буйг бид мэдэх болно. Хэр их ажиллаж хэр их зүйлийг бусдад зориулна, тэр хэмжээгээрээ хурдан дэвшинэ. Бидэнд хэний ч магтаал хэрэггүй. Бид юу хийж байгаагаа өөрсдөө мэднэ.

### ***АЙДАС***

Айдас төрүүлсэн мэдрэмжиндээ битгий авт, учир нь айх тусам айдас хүчтэй болдог. Аливаа юмны талаар бид хэдийчинээ их бодно, тэр зүйл төдийчинээ хүч авч байдаг. Тэгэхээр зөвхөн "хайрын" тухай л бодоцгооё. Цаг үргэлж бид зүгээр л "хайр" болон "хайрын хүчний" тухай бодон, эерэг бодолтой байхад Их Багшийн хүч аяндаа бүх зүйлийг зохицуулах болно. Аажим аажмаар бид энэ байдалдаа дасч, саад тотгор үгүй болж бүхий л айдас хүйдэс арчигдан арилах болно.

### ***АМАР АМГАЛАН***

*Үзэх: Цэвэр ариун байдал*

Хэдийгээр эрх чөлөөгүй газар амьдарч байлаа ч сэтгэл зүрх тань жаргалтай, хангалуун, аз жаргалын дотоод эх сурвалжыг олж авсан бол, та жинхэнэ ЖАРГАЛТАЙ ХҮН.

### ***АМЬДРАЛ***

*Үзэх: Хүн*

Бидний амьдрал яг л сэрж амжаагүй зүүд мэт бөгөөд бид хичнээн удаан унтсан байсан ч хамаагүй, сүнс маань сэрмэгц л өөрсдийн жинхэнэ мөн чанараа нээдэг юм. Гэгээрэх үедээ бид оршихуйн дээд түвшинд хүрч, амьдралыг огт өөр талаас нь харах бөгөөд энэ бүхэн нь үтэр түргэн, ямарч хүч чармайлт, догдлол хямралгүйгээр болж өнгөрдөг. Яг л кинонд хэн нэг нь үхэхэд энэ чинь ердөө л кино шүү дээ гэж бид мэдэж байдагтай адил юм. Бид бүгдээрээ кино од, харин дэлхий бол асар том тайз билээ. Бид төрлөөс төрөл дамжин заримдаа эхнэр, нөхөр, сайд дарга эсвэл хатан хааны дүрд, хааяа нэг их тааламжтай биш дүрд ч тоглодог. Бид мэдэхгүйгээр дүрдээ тоглосоор л, яагаад би энэ дүрд тоглох ёстой, яагаад хаан ширээнд өөр хэн нэг нь сууж байхад би ердөө нарийн бичгийн дарга төдийхөн байна вэ гэж өөрөөсөө асуудаг.

Нойрноосоо нэгэнтээ сэрчихсэн хүмүүс бол ертөнцийг бидний суралцахад болон хүсэл, хэрэгцээгээ биелүүлэх, төгс төгөлдөрт улам ойртоход зориулсан тайз төдий юм гэдгийг мэднэ (1, х 14-15).

Өөрийгөө зөв болгон засаж, дотооддоо байгаа сайн сайхан шинж чанараа нэмж аривжуулбал амьдрал тань хайр адислал, хариу хишиг гэгдэх зүйлээс олныг хүртэх болно.

### ***АНАГААХГҮЙГЭЭР АНАГААХ***

*Үзэх: Хийхгүйгээр хийх*

Намайг хараад эмчлэгдсэн гэж боддог хүмүүст би: 'энэ чинь Бурханы таалсан хэрэг шүү дээ. Би бол зөвхөн хэрэгсэл. Бурхан эмчлэхээр сонгосон хүндээ адислалаа надаар дамжуулан хүртээдэг юм' гэж хэлдэг" (11, х 174).

## **АРДЧИЛАЛ**

Ардчилал гэдэг бол та хүн болгоныг хүндэлнэ гэсэн үг. Гэхдээ чадвартай, билэг ухаантай хүмүүс нь шийдвэр гаргаж, хүч чадалтай нь нийтийн төлөө ажиллах шаардлагатай хэвээр байдаг юм.

## **АРИУН НЭР**

Ариун Нэрсийг олох нь хэдэн сая жилд ч олдох юм биш. Таван Эзний нэрийг диваажин, там, ер хаана ч бай сонссон бүхэн мэхийнэ, учир нь тэд ертөнцийн хаад (41).

Оройн Дээд Их Бурханыг бодох бүр, Таван ариун нэрээ унших бүрд адислал асгаран бууж байдаг (29).

Ариун нэрсийг унших нь Бурхадаас анхаарлаа салгахгүй л гэсэн үг. Уншихаа мартвал ингээд хэлчих: “Би мартвал Та нар минь намайгаа бүү мартаарай”.

Таван нэр нь маш хүчтэй, тамд санасан ч тэр дороо өөрчлөгдөнө. Таван нэр бол тамаас ч суга татна. Таван ертөнцийн эздийн хэрийг хаана ч сонссон бай сонссон бүхэн бөхийнө. Таван ариун нэр биднийг 24 цаг хамгаалж Оройн Дээд Их Бурхантай холбогдог, самадид ороход тусалдаг.

Тамд орсон байсан ч Таван нэр татаад гаргана. Мэдрэхгүй байсан ч Бурханы адис бүгдийг угаадаг. Таван нэрээ байнга санаж байвал Бурханд ойр байдаг юм (83).

Ариун нэрсийг уншиж бясалгах үед диваажинтай холбогддог. Ийнхүү диваажингийн чанараас хүртэж байдаг (79).

## **АРЪЯАБАЛЫН БУЮУ ГЭРЭЛ, АЯЛГУУНЫ БЯСАЛГАЛ**

*(хүчлэл чармайлт үгүй бясалгал)*

*Үзэх: Авишг, Аръяабалын номын цогц*

Бидний хийж буй бясалгал бол үхэж төрөхөөс ангижрахын төлөө, Бурхан болчхоод хамаг амьтныг гэтэлгэхийн төлөө, бүх орчлонг адислахын төлөө юм (6, х 324).

Бясалгал бол Оройн Дээд Их Бурханыг сонсох цаг юм. Бурханы орон, Бурханы вант улс буюу дээд ертөнцөөс сургаал номлол хүлээн авахын тулд сэтгэл санаагаа амирлуулах гэж бясалгадаг юм. Өөрийгөө тайвшруулаад дотроосоо эрж хайвал аз жаргал, амар амгаланг олж авна. Бясалгалын утга учир үүнд оршино. Бид гэдэг чинь бие цогцос ч биш, сэтгэл ч биш. Хийж буй зүйл, сурч буй юм маань ч бид биш, толгойгоо эргүүлүүлж өөрсдийгөө гээд итгэчихсэн зүйл бид билээ. Хэрэв өөрсдийгөө ийм маягаар ойлгох юм бол бидэнд угтаа оршихуй байхгүй юм (2, х 145).

Жинхэнэ мөн чанар тань бясалгаж өөрийгөө сэрээх нь бидний бясалгал юм. Бурханаас ирж буй сургаал номлолыг сонсохыг л бид бясалгадаг юм.

Аръяабалын бясалгал бол төгс гэгээрэлд хүргэж чадах цорын ганц арга. Үнэн хэрэгтээ энэ бол ямар нэг арга ч биш. Энэ бол Их Багшийн хүч. Бясалгал бол гэгээрэх арга хэрэгсэл биш.

Манай арга бол бясалгадаггүй (1, х 61). Зүрх сэтгэлдээ Бурхантай хамт байгаа нь жинхэнэ бясалгал (1, х 250).

Бясалгал хийхийн зорилго юу вэ? Үхэж төрөхөөс ангижрахын төлөө, Бурхан болчихоод хамаг амьтныг гэтэлгэхийн төлөө, бүх орчлонг адислахын төлөө юм (6, х 324). Энэ ертөнцийн чанадад хүрч, Бурханы Оронд буцаж очно, билиг ухаанаа танин мэдэж энэ төрөлдөө ч илүү төгс төгөлдөр хүн болно (23).

Авшиг авмагц бид цаг хугацаа, орон зай, дэлхий ертөнцийн зүй тогтлоос ангид, зүтгэл чармайлтгүй үйлдэх тэр л оршихуйд хөл тавьдаг юм (1, х 1).

Манай арга бол бясалгадаггүй. Манай аргаар бясалгахад хөдөлмөрлөх хэрэггүй (1, х 61). Бүх чармайлт тань ямар ч хэрэггүй (1, х 298).

Бидний бясалгал бол бясалгахгүй бясалгал, зүдрэхгүй бясалгах арга юм (1, х 65). Мөн чанартаа бол зүгээр сууж байгаад Оройн Дээд Их Бурханы адислалыг хүлээн авч, өөрийн төгс дээд хүчээ танин мэдэж байгаа хэрэг юм (1, х 96).

Нойрмоглож суухад ч, унтаж байхад ч гэгээрнэ (1, х 61).

Энэ дэлхий дээрх хөдөлмөрийн үр дүн буюу аливаа 1 үйлдлийн үр дүн нь зөвхөн дэлхий ертөнцийн бүтээгдэхүүн байх бөгөөд материаллаг ертөнцийн хүрээнд л оршино. Тиймээс бидний бясалгал бол бясалгадаггүй бясалгал, зүдрэхгүй бясалгах арга юм. Манай аргаар хичээллэхэд хөдөлмөрлөх хэрэггүй, чармайх шаардлагагүй. Багшийг бодох замаар Багшийн тань бүх чанарууд танд дамжин ирж, Багшаараа дамжуулан та мөн чанараа таньж олно. Угтаа бол зүгээр сууж байгаад Оройн Дээд Их Бурханы адислалыг хүлээн авч, мөн өөрийн төгс дээд хүчээ танин мэдэж байгаа хэрэг юм. Үүнд ямар ч бясалгал оролцдоггүй (1, х 61).

Цорын ганц нууц бол бүхнийг огоорч орхих. Хамаг юмаа хая, бүхнийг хая. Бүх чармайлт чинь ямар ч хэрэггүй гэдгийг бүрэн дүүрэн ойлгох хүртлээ чармайх хэрэгтэй. Цөхрөөд болих хүртлээ чармайна гэсэн үг биш. Ямар ч чармайлт гаргах хэрэггүй болох хожмын тэр үеийг хүртэл чармайх хэрэгтэй. Би хэдийнээ энд байна, хэдийнээ ирчихсэн юм байна гэж ухаарах хүртлээ чармайн оролд. Битгий хичээ гэвэл та одоо больж чадах уу? Зүгээр л даатгаад хамгаа хаяж чадах уу? Та тэгэхээр болоогүй л байна. Тархины түвшинд ойлгох бус үнэнхүү амгалан, үнэхээр гэтэлсэн гэдгээ онох. Ононо гэдэг оюун ухаанаар ойлгож мэдэхээс өөр хэрэг (1, х 44-45).

Минут секунд бүр Бурхан дээр орш. Энэ бол Бурханаас танд тавьж буй цорын ганц шаардлага. Энэ л таны хийх ёстой зүйл. Бурханыг санан дурс. Бурхантай нэгдмэгц үйлийн үрээр хайх зүйл нэгээхэн ч үгүй болно. Та бүхний надаас суралцаж буй сургаалуудын хамгийн чухал, хамгийн сайн нь юм. Бурханд оршиж чадвал тэгээд л боллоо. Зүгээр л Бурханыг сана. Таны юу үйлдэх ёстойг Бурхан хийж байгаа. Бурханд бүхнийг үлдээчих. Ажлыг тань хийх боломжийг Бурханд үлдээчих (7).

Юунаас ч зуурах хэрэггүй. Зүгээр л өөрөөрөө, үргэлж болзол нөхцөлгүй, яг нар, сар, тэнгэр шиг агуу бай (7). Авшиг авмагц бид цаг хугацаа, орон зай, дэлхий ертөнцийн зүй тогтлоос ангид, зүтгэл чармайлтгүй үйлдэх тэр л оршихуйд хөл тавьдаг юм (1, х.19). Бясалгалын 1 минут бүр нь нэг насны амьдралтай тэнцэнэ. Бясалгалын цаг бол танд гарах зуу зуун галав эриний хувьсгал юм. Бясалгалд зориулж буй 2,5 цаг бол мянга мянган жилийн үр дүнтэй. Энэ дэлхийн нэг давуу тал нь оюун ухааныг дадуулахад маш хүнд газар учраас Оройн Дээд Их Бурханы адис хэд дахин хүчтэй буудаг юм. Энд нэг өдөр бясалгах нь диваажинд 100 өдөр бясалгасантай тэнцэнэ. (6, х 62).

Бясалгал бол гэгээрэх арга хэрэгсэл биш. Бүтэн зуун бясалгаад ч гэгээрэхгүй. Учир нь дэлхий дээрх хөдөлмөрийн үр дүн буюу аливаа нэг үйлдлийн үр дүн нь зөвхөн дэлхий ертөнцийн бүтээгдэхүүн байх бөгөөд материаллаг ертөнцийн хүрээнд л оршино (1, х 61).

Бурханы орон ажиглалтаар олддог юм биш, харин бидний дотор оршдог. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр бясалгалаар ч ирдэггүй гэсэн үг. Бурханы орныг бясалгалаар бүтээдэггүй ч бясалгал хийснээр дотооддоо угаас орших бурханы орныг ухаарч ойлгож авдаг (2, х 158). Бясалгаснаар Оройн Дээд Их Бурханы таалалд багтдаг. Оройн Дээд Их Бурханы хүч чадал, хэлбэлзлийг илэрхийлэгч тэр авиа, дотоодын хэлбэлзэл болох тэр авиаг бид бясалгадаг юм (2, х 147).

Бидний бясалгал бол бясалгахгүй бясалгал, зүдрэхгүй бясалгах арга юм (1, х 65).

Минут секунд бүр Бурхан дээр орш. Энэ бол Бурханаас танд тавьж буй цорын ганц шаардлага! Энэ бол таны хийх ёстой ганц зүйл! (7). Зүрх сэтгэлдээ Бурхантай хамт байгаа нь жинхэнэ бясалгал (1, х 250).

Оюун санааны дэвшилтэт арга дандаа энгийн байдаг. Хүмүүс будлиантай ярвигтай байдалд дасчихсан байдаг учраас энгийн болохоор нь ойлгодоггүй (32, х 136).

Бид бясалгах бүрдээ бүх л үнэт эрдэнэсийг зөвхөн өөр руугаа хандуулж, сүнс, бие ба сэтгэлээ хооллохын төлөө бясалгадаг. Төрснөөс үхэх хүртэлх таны хамгийн үнэтэй цаг тань энэ юм. Бясалгал бол та өөрийнхээ төлөө хийж чадах хамгийн сайн зүйл юм. Үүнийг танаас өөр хэн ч танд өгч чадахгүй. Үүнийг хэдийгээр та өөрийнхээ төлөө хийж байлаа ч бусад бүх юманд сайнаар тусаж нөлөөлөх болно. Таны гэр бүл, садан төрөл, нохой, мууранд чинь хүртэл ач тустай. Мод, цэцгэнд бас ач тустай. Бидний эргэн тойрныхон, бусад бүх зүйлд ач тустай. Харин бидэнд өөрт бол бүр ч ач тустай.

Энэ бол таны биеийг хооллох хамгийн сайн хоол, сайн тан, тархийг тань өсгөх хамгийн хүчтэй энерги, оюун ухааныг тань хөгжүүлэх хамгийн сайн ном юм. Энэ бол бүх л орчлонд таны өөртөө зориулж чадах хамгийн үнэтэй эрдэнэ юм.

Өдөр дутам хоёр цаг хагас бясалгах нь олон сая жилийн төлөө хийж байгаа их үйлс гэсэн үг юм. Бясалгалд зориулж байгаа минут бүр нь амьдралын цаг хугацааг төлөөлнө. Учир нь мөнхийн ертөнцөд хоёр цаг хагас юмуу ганц минут гэсэн ойлголт байхгүй. Тэнд юм бүхэн мөнх оршино. Бясалгалын үед таны нэвтрэн орсон тэрхүү мөнхийн ертөнцөд цаг хугацаа зогсдог.

Энэ бол зөвхөн хоёр цаг хагас биш. Энэ нь олон мянган жил, хувьсал хөгжлийн маш урт үе болно. Бясалгалд зориулж байгаа цаг их үнэтэй. Энэ нь агшиж шахагдсан таны хувьслын олон зуун юм. Тийм болохоор энэ нь хэмжээ биш. Энэ нь бидний мэддэг хугацаа биш, тоо ч биш. Бясалгалын цаг нь бүр тэс өөр хугацаа, өөр орон зай юм (59).

Бясалгалын хоёр цаг хагас зарцуулж байгаа бясалгал танд олон мянган жил хэрэг болно.

Та цаг хугацаа, орон зайн өөр төлөвд ороод цэнэглэгдсэн юм шиг шинэчлэгдэн эргэж ирнэ.

Бясалгалын зорилго маань өөрийгээ таньж мэдэх явдал юм. Үүнийг бид энэ амьдралдаа хийхгүй өнгөрвөл дараагийн амьдралдаа, түүний дараагийн, магадгүй дараагийн дараагийн амьдралдаа хийх болно.

Та шавхагдашгүй дотоод баялагаа олмогц хоосрол, тэнэглэл, аймшиг гэж үгүй болно. Энэ бол бясалгалын гол зорилго юм.

Бясалгах санал хүлээж авах нь хүндэтгэл, давуу эрх бөгөөд ийм нууцыг мэдэх чадвартай байх нь бидний амьдралын хамгийн дээд аз заяа мөн.

Энэ нь албадлага биш, тохиролцоо ч биш, мөн ямар нэг даалгавар ч биш.

Энэ нь бүх л ядуу тарчигаас өөрийгээ чөлөөлөх тэрхүү үүд хаалгыг ийм хялбархан нээсэн төрөлтнүүд бидний мянга юмуу сая жилийн маань амьдралын хамаг эрх ямбаас эрхэм дээд нь, бүх аз завшаанаас хамгийн шилдэг нь юм (60).

Бясалгалын эрдэм бол гайхамшигтай их юм. Сэтгэлийн хүч маш их болохоор Диваажинь орныг бүтээж, Эрлэг тамын орныг эвдэж чадна. Аливаа бүхэн цөм энэхүү сэтгэлд л байгаа юм (61).

Чин сэтгэлийн угаас хамаг анхаарлаа нэг зүйлд төвлөрүүлэх тэр болгон нь бясалгал юм. Би анхаарлаа гагцхүү Дотоодын хүчиндээ, Энэрэхүй сэтгэлдээ, Оройн Дээд Их Бурханы хайр болон Өршөөн нигүүлсэхүйд хандуулдаг (23).

Бид хаашаа явж байгаагаа, мөн Хүч чадлаа хааш нь чиглүүлэхээ мэддэг байх ёстой. Хайр энэрэлгүй, нигүүлсэнгүй сэтгэлгүй, ёс суртахууны үнэт чанарын зохих ойлголтгүй Хүч Чадал бол ашиг тусгүй юм. Тэр нь хар дом, муу муухай зүйл болж хувирна (23).

Бясалгал гэдэг ердөө л суугаад байна гэсэн үг биш. Та цэвэр ариун, өршөөл, нигүүсэл бүхий сэтгэлээр төвлөрөх хэрэгтэй. Тийм биш бол зүгээр л цагаа үрж буй хэрэг болно.

## **АРЪАБАЛЫН НОМЫН ЦОГЦ**

*Үзэх: Арьяабалын бясалгал, Бурханыг дурсах*

Арьяабалын номын цогцыг Буддын шашны үл мэрийх, гүн нарийн номын цогц гэж нэрлэж байв (5, х 137). Арьяабалын номын цогцыг бясалгахад аливаа бодис хоосон чанартай, чих, нүд, бодол, биеийг хэрэглэхгүй, төрөхгүй устахгүй, хиртэхгүй, ариутахгүй юм (6, х 60). Судар ном дотор ном уламжлах хүчин байхгүй (5, х 139). Бодидарма: “Судраа аль, би шатааж орхие. Хушуур зурлаа гээд өл дарж чадах уу” гэжээ (5, х 119).

Арьяабалын бясалгал бол Төгс Гэгээрэлд хүргэж яадах цорын ганц арга. Үнэндээ арга ч биш Их Багшийн хүч юм (2, х 135).

Багшийн нь сурсан нь Бурхан болох номын цогц юм. Энэ нь эртнээс нааш уламжлагджээ (6, х 195).

Миний та нарт зааж сургаж байгаа бүхэн цөм судар номд бичээстэй байдаг. Эрт цагаас аваад ёс суртахуунт байдал өөрчлөгдөөгүй. Оройн дээд их бурхан, Буддагийн сахил гэрээслэл өөрчлөгдөөгүй (2, х 115). Жинхэнэ багш бүхэн нэг юм. Тэд бүгдээрээ нэг эх сурвалжаас ирсэн бөгөөд хамгийн дээд багш бол та бүгдийн дотоодод оршин байгаа хамгийг чадагч, төгс дээд багш юм (2, х 105).

Жинхэнэ олон Бурхант судар бол билгийн чанад хязгаарт хүрсэн Очир огтлогч судар юм (6, х.65). Олон бурхант номын цогц бол Арьяабалын номын цогц мөн (6, х 68). Ном уламжлах үед би Очир огтлогч судрыг номлоно. Гэхдээ үг хэл хэрэглэхгүй (6, х 66). Арьяабалын номын цогц бол мөрийн бясалгал буюу Дээд хөлгөн болно (6, х 100). Бидний бясалгал бол мөрөөр бясалгахаас бус эгэл хүний бие, цогц, сэтгэлээр бясалгадаггүй (6, х 33). Бидний мөрийн эзэн, бидний уг дүр, бидний бурхан чанар, бидний хан хурмаст бол их мөр болно. Мөрийг олж, энэ мөрийн дотор бясалгаж, энэ мөртэй нэвтрэлцэж, энэ мөрийн хамгаалалтын хүчинтэй болж, мөрийг хэрэглэж чадах болж, шууд энэ мөртэй хамт байхыг Дээд хөлгөн (Их мөр) гэнэ (6, х 100).

Арьяабалын номын цогц бол номын эрдэнэ болсон 6-р дээд өвөг Багшийн мандалт сударт, жинхэнэ билгийн чанар хязгаарт хүрсэн Очир огтлогч сударт бий. Тэдгээр сударт ямар ч ном тайлсангүй, яаж бясалгахыг, чухам яавал гаднах дүрсээс (хуран мэдэл) салж, дотоодод бодол самуурлаа тогтоохыг заасангүй (6, х 66).

Бодидарма дээд багшийн судрын уламжлалын онолд айлдахдаа: “Таны харсан гэрэл нарныхаас илүү байвал билиг ухаан нээгдсэн хэрэг. Тэр гэрлийг олж, Бурхан чанарыг олж харах буюу тэр хүслэнт ахуйг олвол ном унших, Бурханд мөргөх хэрэггүй” (6, х 258). Энэ бол ном судар, Гурван эрдэнийг муулсан хэрэг биш (6, х 162).

Номыг сэтгэлээр сэтгэлд уламжилна. Энэ сэтгэл бидний уг сэтгэл, үнэн сэтгэл юм. Дияан үг хэрэглэдэггүй гэдэг нь энэ. Ерөөс уламжилчмаар 'ном' үгүй. Гэвч уламжлахгүй бол 'ном' үгүй, уламжлах үед 'ном'-той болно. Энэ нь үнэндээ 'дүрсгүй ном' юм. Аливаа юм энэ 'дүрсгүй ном' дотор буй, Аялгууны урсгал дотор буй. Энэхүү аялгуулж үл болох аялгуу, нэрлэж үл болох нэрийн дор буй. Дияан үг хэрэглэхгүй боловч энэ нь дияан үгүй гэсэн хэрэг биш. Хотол зохилдогч сударт: “Аялгуу ажихын суу алдрыг мэдвэл энэ нь зуу, мянга, түм, бум, дүнчүүр бодисадын нэрийг уншсанаас ч ач тустай. Тийм хэмжээний бодисадыг тахиснаас ч илүү ач тустай. Учир нь түүний нэр аялгуу ажихуй төдий биш юм. Түүний нэр нь нэрлэж үл болох орчлонгийн аялгууны урсгал, бүхэл орчлонгийн өнөд орших хэлбэлзлийн хүч мөн. Тиймээс Арьяабалын номын цогцыг бясалгагч бол хамгийн эрдэмтэй, хамгийн эрхэм дээд хүн” хэмээжээ (5, х 106).

Зарим номын багш, дияанч нар ном судар хэрэггүй, түлш болгон хоол хийж болно гэдэг. Багш чинь мөн цөхөрсөн бөгөөд тэгэж хэлдэг. Судар ном дотор ном уламжлах хүчин байхгүй (5, х 138-139). Бодидарма 'судраа өг. Түүнийг чинь шатаагаад орхиё. Хуушуур зураад өл дарж чадах уу' гэжээ (3, х 118).

Багшийнх нь сургаал номлол бол “агшин зуур билиг нээгдэх, энэ насандаа туулах тонилох “ гэдэг болохоос “энэ насандаа төгс гэгээрсэн багш болно” гэдгүй (6, х 376).

Зөвхөн Арьяабалын номын цогцоор чөлөөлөгдөн гэтэлж, үйл үрийн зовлонг үгүй хийж чадна (2, х 252).

Баатар явагч их хөлгөн сударт Бурхан Багш 'Гуань Инь /Арьяабалын буюу Гэрэл, аялгууны/ номын цогц хүнийг Бурхан болгож чадна. Бусад нь цөм хялбар номын цогц болно' хэмээжээ (6, х 162).

Зөвхөн Арьяабалын номын цогцоор та бүхэн бүрэн чөлөөлөгдөж, эрт орой хэзээ нэг цагт Тавдугаар төвшинд хүрч чадах нь баттай (39).

Арьяабалын номын цогцыг бясалгавал бид бүгд Бурхан болж чадна (6, х 98).

Арьяабалын номын цогцоор шавь нар бүрэн чөлөөлөгдөж, эрт орой хэзээ нэг цагт Тавдугаар төвшинд хүрч чадах нь лавтай” (39).

Бид бүгдээрээ гэртээ гарцаагүй харина. Хэн ч хоцорч үлдэхгүй. Та дахин төрөл авч тодрохгүй. Буцаж ирэх гэж жигтэйхэн их хүсээд байдаггүй л юм бол шүү дээ (1, х 301).

Арьяабалын номын цогцыг бясалгагч энэ ертөнцийг орхисны дараа өөрөө хүн төрөлхтний зовлон зүдүүрийг хөнгөлөх гэж Будда болж эргэн ирэхийг хүсэхгүй л юм бол энэ ертөнцөд эргэж төрөх албагүй. Учир нь Арьяабалын бясалгалыг бясалгагч хүмүүнд очиж болох хавигүй илүү гайхамшигт, онц сайхан ертөнц олон бий. Тэр хүмүүнд зовлонгоор дүүрэн энэ ертөнц хэрэггүй. Тэрээр Арьяабалын номын цогцыг бясалгаснаар билгүүн ухаан, хэлбэлзэл нь гэгээнтнүүдийн хэмжээнд хүрч, түүнийг Бурханы орны ялгуун тансаг орчинд амьдрах шалгуурт багтаадаг (2, х 128).

Гималайн нуруунд их олон бясалгагч сууж байна. Тэд нэг хоёрхон жилээр бясалгахгүй, хэдэн арван жил, зуун жил, мянган жилээр бясалгадаг. Тэдний заримынх нь нас асанги галавтай чацуу. Тэд бидний оршиж байгаа дэлхийн бөмбөрцөг буй болохоос эхлээд одоо болтол амьдарч байгаа юм. Тэд хэдийгээр хэдэн мянга, сая жилийн настай боловч хорин тав буюу гучаад настай юм шиг залуухан харагдана. Тэд маш нууц номын ёс болох Арьяабалын номын цогцыг хамгаалж байна (62).

**АУРА**



Үзэх: Гэрэл, Аялгуу

## **АХУЙ ОЙЛГОЛТ**

Нэгэнт билэг нээгдсэн байтлаа өөрийгөө голж өглөө үдэшгүй Багшдаа хандан: "Би яагаад ийм ядмаг байна вэ? Би яагаад ахуй ойлголтгүй байна вэ" гэж гомдоллодог. Хэрэв Багшдаа зуун хувь бүрэн итгэвэл ахуй ойлголтгүй байсан ч ахуй ойлголттой нэгнээс дээр.

Ахуй ойлголтгүй байтлаа Багшдаа итгэж байгаа нь түүний дэс маш өндөр болохыг үзүүлж байна.

Түүний далд ухамсар нь үүнийг тодорхой мэдэж байгаа болохоор л Багшдаа итгэж байгаа юм. Зарим нь хэдийгээр бага сага ахуй ойлголттой болоод байсан ч мөн л асурийн оронд байгаа болохоор тодогтож магадлах билэг ухаан гүйцээгүй байна. Билэг ухаантай хүн бол Багшдаа итгэдэг. Ахуй ойлголт нь өндөр дэсийг төлөөлж чадна гэж хэлэх аргагүй. Асурийн орон ахуй ойлголтоор дүүрч байдаг бөгөөд тов тодорхой ялгагдаж байдаг. Асурийн ертөнцөд зуун тавь гаруй дэд ертөнц байдаг. Хүслэнт ахуй бүрд бас маш олон дэд хүслэнт ахуй хамаардаг юм. Хэрэв та жуулчилж очоод зуу, мянга, түмэн галав элээн сонирхож үзсэн ч Асурийн орныг дуустал үзэж чадахгүй, нэн өндөр хүслэнт ахуйд жуулчлахыг бол энд дурсахын ч хэрэггүй юм.

Тиймээс ахуй ойлголт гэдэг нь юу ч биш, харин билэг ухаантай байх хэрэгтэй. Билэг ухаан байх эсэхийг амархан мэдэж болно. Хэрэв Багшдаа үнэхээр итгэж байвал тэр хүний барилдлага нь тун гүн болохыг мэдэж болно.

Урьд төрөлдөө бясалгал хийж, билэг ухаан маш өндөр болсон хүн Багшийнхаа ярьж байгааг бүрэн ойлгож Багшдаа итгэдэг. Энэ нь Мила Богдтой адил юм.

Тэр анхандаа ямар ч ахуй ойлголтгүй, Багш нь юу ч зааж өгөөгүйгээр барахгүй загнаагүй өдрөө зодож, зодоогүй өдрөө загнаж, өдөр бүр ийм байна. Бас үлдэн хөөж, зүйл бүрийн зовууртай номын цогцоор түүнийг гасалгаж байсан ч бас л Багшдаа итгэсэн хэвээр байж, хүлцэн тэсвэрлэхүйеэ бэрх зовлонг долоон жилийн турш амссан юм.

Хэрэв түүний оронд нэгэн эгэл юмуу билэг ухаан дорой нэгэн байсансан бол тэр даруйдаа явчих байсан. Тэр даруйдаа биш юмаа гэхэд гурав дөрвөн жилийн дараа лавтай явах л байсан. Гэвч тэр явалгүй үлдэж долоон жил болжээ. Өдөр бүр байшин барина, дараа нь нураана, ахиад барина, нураана. Загнуулна, зодуулна, хөөгдөнө, хийсэн бүхэн нь буруудна, Багшдаа магтуулж үзээгүй юм. Юуных нь магтуулах, харин загнуулахгүй шиг өнгөрвөл дээдийн заяа. Тэр зөвхөн бэрхийг л тэсвэрлэн суусан болохоос юуных нь ахуй ойлголт, ийм юмны тухай ч мэдэж байсангүй. Багш нь түүнд номын цогц зааж уламжлаагүй юм чинь ямар ахуй ойлголт байхсан билээ?

Түүний өдөр бүрийн ахуй ойлголт гэвэл нь ажил хийнэ. Хөлс цусаа гоожуулна, бүх бие нь шарх сорвиор дүүрсэн ч ам нээж хэлж зүрхлэхгүй. Багштайгаа уулзаж үг хэлцэх нь нэн бэрх, хааяа юм асуувч Багш нь хариулж хэлж өгөхгүй, номын цогц уламжлахыг гуйвч зааж өгөхгүй. Гэвч тэр эцэстээ Их Багш болсон ба одоо болтол алдаршсан хэвээр байна

Тиймээс заавал ахуй ойлголттой бол сайн гэсэн хэрэг бишийг мэдэж авах хэрэгтэй. Ганц ахуй ойлголт байгаад хангалтгүйг их билэг ухаантай хүмүүс сэтгэлдээ тодорхой мэдэж байдаг учраас тэд Багшдаа ихэд итгэдэг юм. Ахуй ойлголттой байгаа эсэхийг ойшоосны хэрэггүй.

Зарим чинь Багштайгаа хамт ажиллах хэрэгтэй, Багштайгаа хамт энэхүү Замбуулингийн оронд оршин тогтнох хэрэгтэй юм. Энэ тохиолд их ахуй ойлголттой байж болохгүй, хэрэв ахуй ойлголт чинь хэт ихэдвэл ажиллах аргагүй болж, сэтгэл ханан мансуурах болно. Багш чинь ганцаараа ажиллах болно. Ажиллах хүнгүй болоод, бүгдээрээ сэтгэл ханаж, рашаан ус ууж

мансуурцгаана. Тиймээс бясалгагч зарим үед тийм их ахуй ойлголттой байж болохгүйн учир гэвэл бид ажил хийж байна.

Ажиллах дуртай хүн тун цөөн, бодь сэтгэл үүсгэх хүн маш цөөн байна. Хамаг амьтан Будда бодисадыг түшиглэхээс биш өөрийн биеийг түшиглэхгүй. Ажиллаж байхдаа жаргаж болохгүй. Хэдийчинээ ажиллана, хэдийчинээ их бусдад туслахыг хичээнэ, тэр хирээр хөгжинө (4).

## **АЯЛГУУ**

*Үзэх: Гэрэл Аялгуу*

Энгийн үед аялгуу сонсвол их сайн. Ингэвэл Багшийгаа байгааг мэдэж болно. Энэ нь Багшийн чинь бие биш, харин Багшийн чинь Гэрэл, Аялгуу мөн, бас Хүч мөн (3, х 214).

Удаан бясалгасны дараа бид юу ч хийгүй байсан ч дотоодын дуу аялгуутайгаа хамт байж, үүрд салшгүй андууд болно. Хэцүү бэрхшээлтэй тулгарсан ч бидэнд тусалж, биднийг орлон хамаг ажлыг маань хийж өгнө. Бид тусгайлан энэ тэр ажил явдал гэж анхаарах хэрэггүй, ямар нэг юмыг хүсч эрмэлзэх ч хэрэггүй, мөн аяндаа Будда болно. Тиймээс явавч дияан, хоолловч дияан, унтаж хэвтэвч дияан, амьдралд дияангүй юм байхгүй болно (5, х 96).

## **БАГШ**

*Үзэх: Их Багш, Жинхэнэ Багш*

Хоёр янзын багш байдаг. Нэг нь ерөөс үйлийн үр огт байхгүй бөгөөд манай энд бууж ирэхийн тулд бусдаас үйлийн үр зээлддэг. Нөгөө нь бидэнтэй адил, ертөнцийн жирийн хүн бөгөөд тэрээр үйлийн үрээ цэвэрлэсэн байдаг. “Үйл үр зээлдэх” гэхлээр ямар сонсогдож байна? /Багш инээв/. Гэхдээ энэ бол бүрэн боломжтой, бүрэн боломжтой зүйл шүү. Жишээлбэл: та урьд өмнө энд бууж ирээд саатаж байжээ. Олон зуу, мянган жилийн туршид өдий төдий хүмүүстэй өгөө аваатай байжээ. Дараа нь та тэнгэр лүү буюу өөрийн гэр орон байдаг ямар ч гэсэн Тавдугаар Түвшин хүртэлх нэн алсын ертөнцүүдийн нэг рүү буцсан байж. Тавдугаар Түвшин бол Багш нарын оршин суудаг газар юм. Гэтэл бас түүний дээр өөр олон түвшин байдаг юм. Хэрэв бид Дээд Тэнгэрийн бошиг зарлиг юм уу нигүүлсэнгүй сэтгэлийн улмаас жишээ нь, буцаж ирэхийг хүсвэл доош бууж ирэх хэрэг гарна. Өнгөрсөн үедээ хүмүүстэй холбоотой байсан учир тэдний данснаас, та нарын мэдэх үйлийн үрийг зээлдэж болно.

Хүмүүст зөвхөн өр төлөөс л байна, өөр ямар ч өөдтэй юм байхгүй. Бид хэсэг өр төлөөсийг нь зээлэн авч, энэ ертөнцөд ирсэн үүрэг зорилгоо бүрэн биелүүлэх хүртлээ бясалгалын хүчээрээ эргүүлэн төлж, барагдуулна. Иймд энэ бол өөр маягийн Багш юм. Мөн энэ ертөнцөөс гаралтай, дээд сургууль төгсөхтэй адил бясалгал хийж байж Багш болсон хүмүүс байна. Тийм ээ. Их сургуульд багш нар байдаг, сургуулиа төгсөөд дараа нь багш болдог оюутнууд ч байдагтай яг адилхан. Маш олон жил ажилласан багш нар, бас дөнгөж төгссөн багш нар гэх мэт байдаг. Үүнтэй адилаар Гэгээрсэн Багш нар ч ийм янз бүр байна (23).

Багшийн бие цогцос 2 шалтгааны тулд байдаг. Шавиас салж арилах ёстой бүхнийг авах, шавь нарын нүглийг цуглуулан цэвэрлэж ариусгахын тулд Багшийн бие цогцос оршдог (2, х 78).

## **БАРИЛДЛАГА**

Урьд насандаа төдийлөн буян хураагаагүйгээс барилдлага үүсдэггүй (буян дутсан гэсэн үг). Сүсэг барилдлага гэдэг нь Бурханд даатгах үед олсон хариу барилдлагыг хэлнэ (6, х 385).

## **БИ ҮЗЭЛ**

Үзэх: Адислал, Будда

“Би” үзэл гэдэг нь хувь хүний зан төлөв, аливаад хандах хандлага гэж хэлж болох юм (2, х 146). Бидний дуртай, дургүй, жигшин зэвүүцдэг, дурладаг нөхцөл байдлууд би үзэл гээчийг бүрдүүлдэг. Дуртай бүхэндээ уяатай байх нь би үзэл (2, х 148). “**Би үзэл бол бодол сэтгэл юм (22).**”

“Би” үзэл бол билиг ухаан нээгдэх болон Төгс Гэгээрсэн Их Багш болоход хамгийн аюултай дайсан мөн” (1, х 41).

Бид эхлээд 'би' байхгүй болж хувираад 'үнэ цэнгүй, нэр алдаргүй зарц' болж хувирах ёстой. Би хэвээрээ байж хоосорч чадахгүй бол Бурханы соёрхох хүчийг бүрэн хүлээн авах аргагүй (1, х 41). Энэ бол Төгс Гэгээрсэн Их Багш болох нөхцөл болно (6, х 379).

Би-г дарах нь зөвхөн өөрийгээ ажиж дадуулснаар шийдэгдэх зүйл биш. Зөвхөн Бурханы Вант Улстай холбоо тогтоосноор шийдэгдэх зүйл.

### Би үзэлгүй байх гэдэг нь:

Бурханы Вант Улстай нэгдсэн,

Хийхгүйгээр хийдэг, анагаахгүйгээр анагаадаг болсон,

Юмыг зөвхөн Бурханы тааллын дагуу хийдэг,

Хэзээ ч нэр төр хайдаггүй гэсэн үг .

Бурхан таалвал ажил хийж, эс таалвал ажил үүргээ орхино.

Тэр цагт бид 'би' үзлээ үнэхээр дарсан байх юм. Гэхдээ өөрийгээ хүндлэх сэтгэл, нийгэмд эзлэх байр суурь, бусдын хүндэтгэлийг алдахгүйгээр дарна.

Тэр цагт Бурхан бүхнийг хийж байгааг мэддэг болсон байна.

Бид хийхгүйгээр хийдэг учраас үйл үрийн төлөөсөнд унахгүй.

Өдөр бүр эго маань өсөөд байхгүй, учир нь бид хэнийг хэзээ эдгээснээ мэдэхгүй. Бидний мэдэх зүйл бол тэнгэрийн адислал бидний биеийг багажаа болгон тэр хүнийг эдгээсэн гэдгийг л мэднэ” (10).

Бурхан бодисад юу ч хийсэн ялгүй, үйл үргүй. Учир нь тэд барилдлагыг нэвт шувт үзэж, тодорхой мэдсэн болохоор үйл үрийн хүрээнд орохгүй. Бурхан бодисад юу ч хийсэн тархи толгойдоо шингээж авдаггүйтул үйл үргүй.

Харин хамаг амьтан үүнийг мэдэхгүй, тэд өөрсдөө хийсэн гэж боддог тул үйл түйтгэр бий болдог” (3, х 155).

Би гэх үзлийг гаргахгүйг хичээж л байвал та Бурхан (7, 1-р хэсэг).

## **БИЕ МАХБОД**

Бие бол гайхамшигтай сүм, дотроо гэрэл хайр бүр бүх ертөнцийг тээж байдаг. Будда: “Хүний төрөл олонх нь гайхамшиг” хэмээсэн. Учир нь энэ бие байж л бясалгаж болно. Сахиусан тэнгэрт бие байхгүй (81).

## **БИЛИГ НЭЭГДЭХ**

Үзэх: Авшиг, Будда, Дияан

## **БИЛИГ УХААН**

Хамгийн дээд билиг ухаан бол нинжин сэтгэл юм.

## **БОДИСАД / БОДИСАДВА**

Манай бясалгагчдын төрөл садан сэтгэлийн авшиг хүртээгүй, Арьяабалын номын цогцыг бясалгаагүй ч ойр төрлийн хүн нь Арьяабалын номын цогцыг бясалгасан болохоор тэд ч мөн Бурханы оронд мэндлэх болно. Энэ нь тэдний төрөл садангийн хүн нэгэнт бодисадва буюу архадын зэрэгтэй болсныг харуулж байна.

“Билгийн чанад хүрсэн Очир” хэмээх сударт: "Хэрэв архад буюу бодисад болсноо ухаарч мэдсэн бол нь тэрээр бодисад биш" гэжээ (4).

Будда бодисад өөрөө Будда бодисад гэдгийн утгыг мэддэггүй. Тэд бардамнахгүй, өөрийн биеэ нэгэнт Бодисад болчихлоо гэж хэлэх ч үгүй. Түүнд тийм санаа байхгүй болохоор бардамнахгүй.

Гэвч тэд өөрийгөө хэн болохыг мэднэ. Мэдэж байгаа хирнээ бас мэдэхгүй юм шиг. Өөрийгөө ямар нэгэн багаж хэрэгсэл шиг ч юмуу ганц бие цогцос төдийгээ л мэднэ.

Ийнхүү эгэл хүний "би" нь үгүй болон арилж, зөвхөн Будда бодисадын хүч чадал л түүний дотор орших болно. Тэрхүү хүч чадал нь юу хийе гэнэв, түүнээ л хийхээс биш бид түүнийг яахын ч аргагүй (4).

Одоо та нар Багштайгаа адилхан, адилгүй юм нэг ч үгүй. Багахан зөрөө гэвэл нь энэхүү хүч чадлыг хэрэглэхийг та нар мэдэхгүй бөгөөд хэрэглэж ч чадахгүй. Та нар өөрийн хүч чадлаа ухаарч мэдээгүй байгаа. Аажмаар барилдлагатай болоод, гэнэт хамаг амьтныг гэтэлгэж чадах тэр үед мөнгө хөрөнгө маань зараад дуусамгүй, бидний хүч чадал сэтгэшгүйг мэдэхтэй зэрэг Будда болж сэтгэл тайвширна.

Элдэв маяг чимэг, өмсгөл баггүй байгаагаараа л бай. Яг нар, сар, тэнгэр шиг агуу, хариу нэхэлгүй ухаалиг бай. Агуу их, уужим, хязгааргүй бай: Энэ л чухамхүү та мөн.

Цаг ямагт би үзэлгүй, болзол нөхцөлгүй бай. Хэзээ ч ашиг бүү горил. Тэгвэл хүссэнээсээ ч илүүг хүртэх болно. Үргэлж аминч бус болон нөхцөл болзолгүй бай. Энэ нь диваажингийн ажлын арга зам юм.

Нар ивээснийхээ төлөө эргээж танаас юу ч нэхдэггүй шиг, сар, од эрхэс, мод, агаарын аль нь ч юу ч хүсэхгүй адисладаг. Тэдэн шиг бай. Энэ бол ухамсрыг дэвшүүлэх арга зам ба хариу нэхэлгүй, болзол нөхцөлгүй байж гэмээ нь бусдыг адислаж чадна гэсэн үг. Өгсөн ч, авсан ч тэнд “би” байхгүй. Хэрэв хүссээр л байвал миний адислалыг ч хүртэж чадахгүй. Энэ бол доод түвшин. Юуг ч бүү хүс, зүгээр л бай. Тэр юм таных болох ёстой бол хүрээд л ирнэ, тэгэхээр нь хадгалчих. Ямарваа юмыг хүсэх нь танд маш муу. Хүссэн зоргоор олддог ч юм биш, энд оюун санааны адислал, хүч, төвшин ч мөн адил хамаарна (72).

## **БОДОЛ**

*Үзэх: Сэтгэл*

Хэн нэгнийг бодуут үйлийн үр холбогдчихно. Энэ дэлхийд юу ч тохиолдлоор болдоггүй. Бурхан Багш бээр: “Бүх юм сэтгэлээр бүтнэ” гэж айлдсан. Бид бодлоо зөв болгох хэрэгтэй. Сайн зүйл ярьж, сайн зүйлийг бодох хэрэгтэй. Тэгвэл нь сөргийг эерэг болгон хувиргаж чадна. Биеийн эсүүдээ эерэгээр бодуулж сургах хэрэгтэй. Сайн юмны тухай ярихад л таны бодол, бие, олон сая, тэрбум эсүүд түүнийг тэр дор нь сонсоно. Би яагаад “Та нар өөрсдийнхээ эзэд” гэж хэлдгийн учир энэ. Та нар өөрсдийгээ яаж сургахаа мартчихаад байна. Амьдралын маань сайн муу бүхий л зүйл биднээр, өөрсдөөр маань бүтээгддэг. Хэрвээ гадны хог новш таны саванд хаа нэгтээ үлдсэн бол түүнийг гаргаж хаяхаар бясалга (58).

Бодол бүү тээ. Бодол Бурханаас холтгож учир шалтгааны ертөнц рүү унагана (7). Бурханд бүхнийг үлдээчихвэл бодлыг ялган дийлэх маш хялбар болно. Бодол байсаар л бол бясалгал биш, Бурханы мэдээ сургийг сонсох арга биш (6, х 393). Бодол бол ертөнцийн ноцтой зэмсэг, дэвшлийг буцааж татна. Бодлоо зөв дадуулж сурга. Бодлоо аргадаж түүнтэй сайн найз бол. Хэлэхэд ойлгоно. Сөрөг бодлоо эерэг болго, бодлынхоо дээр гарч байж бүхнийг хардаг, ойлгодог болно. Эс бөгөөс бодлынхоо л хэмжээнд эргэлдэнэ (80). Бид хэрхэн амьдарч буйдаа тун хянамгай байхгүй бол болохгүй, учир нь бодсон бүхэн маань биелж бүтэж байдаг. Хэрэв олиггүй бодол орж ирвэл тэр дор нь тархинаасаа гарган хаяж, ариун нэрсээ уншин төвлөрч

өөрийгөө ариусган амьдралын тань хором бүрд Бурханаас хайрлаж буй адислалд баяс (1, х 170).

Уурлавал Оройн Дээд Их Бурханд хандан энэ хорыг зайлуулж өгөөч гэж залбир. Багшаасаа даруй тусламж эрэн сайн бодол хайрлаач, эсвэл муу бодлыг хайрын сэтгэлээр сольж өгөөч хэмээн залбирч байгаарай (1, х 172).

## **БУДДА**

*Үзэх: Бодисад / Бодисадва*

Хэдийд Будда болохоо хүлээсний хэрэггүй, сэтгэлийн авшиг хүртмэгц Будда болно. Бидэнд зөвхөн итгэл дутаж, туршлага дутаж байгаа төдий юм.

Сэтгэлийн авшиг хүртэх үед "агшнаа гэгээрэх" гэдэг нь тэр дороо билэг нээгдэж цэцэг дэлгэрэн Будда харагдаж, тэр даруй дотоод мөн чанараа үзэж Будда болохыг хэлж байгаа юм. Энэ бол бодит үнэн юм. Гэвч бид билэг ухаангүй, итгэл зориггүй учраас билэг нь хэдийгээр нээгдсэн ч өөрөө түүнээ мэддэггүй.

Сэтгэлийн авшиг хүртсэн хүн нэгэнт Будда болдгийг Багш нь та нарт батлаж чадна. Тиймээс Будда болох ба болохгүй нь бидний сэтгэлд, итгэл зоригийн маань хүчинд байна. Сэтгэлийн авшиг хүртсэний дараа ядахдаа та нарыг Буддагийн хүчтэй нэвтрэлцүүлж, Буддагийн эх сурвалж уруу чинь буцааж чадна. Буддагийн эх сурвалждаа буцаж чадвал болох нь тэр.

Хүн бүр цөм Будда болж болно. Будда гэж билэг нээгдсэн хүн, их гэгээрэгсэд, Төгс Гэгээрсэн Их Багшийг хэлж байна.

Аливаа юмыг ойлгож чадсан даруйд Буддагийн дэстэй болох буюу Төгс Гэгээрсэн Багш, туулан ангижруулагчийн дэв зэрэгтэй болно.

Бид Буддатай уулзахаар очиж байгаа үедээ даруй Будда мөн. Зөвхөн Будда л Буддагийн улс оронд сууж чадна. Эсвэл ядахдаа Буддатай адил мөн чанартай байж гэмээнэ Буддатай хамт байж чадна.

Тиймээс Буддагийн оронд очиж чадаж байвал Будда болох нь тэр. Буддагийн гэрлийг харж байвал Будда болжээ гэсэн үг, Будда ийм л байдаг юм.

Будда мянган мутартай, мянган мэлмийтэй төдийхөн биш, Тэр бээр хэмжээ хязгааргүй мэлмийтэй, хэмжээ хязгааргүй мутартай юм.

Удаан "сууснаар" Будда болчихгүй, хэрэв тэгдэгсэн бол нь "Суумал Будда" болно. Удаан хэвтсэнээр Будда болчихдог бол нь "Хэвтээ Будда" болно.

Зөвхөн Будда болох төдий нь ямар ч хэрэггүй юм.

Бэридагабад Будда хүмүүнд ном уламжилж чадахгүй. Учир нь тэр багшгүйгээр мөрийг олсон байна. Энэхүү "амаар ном уламжлах" мэдлэг нь хамаг амьтанд ном сонсгож, тэдний анхаарал хийгээд бишрэл, сэтгэлийг татах хүч юм.

Тиймээс билэг маань хэдийгээр ихэд нээгдсэн боловч ойрын эрдэмгүй бол түүнээ билэг нээгдээгүй хүмүүнд илэрхийлэн ойлгуулж чадахгүй юм. Энэ бол харамсалтай хэрэг мөн.

Билэг нээгдэх нь бэрх биш, харин хамаг амьтныг гэтэлгэх нь бэрх юм.

Будда болсон хүн өөрийгөө Будда гэх нь бардамнахын үүднээс биш, нэгэн үнэн явдлыг, аяндаа болсон тун энгийн нэгэн явдлыг ярьсан төдий юм. Энэ нь хооллоод: "Би цадлаа" гэж хэлж байгаатай адил юм. Цадсан бол "цадлаа" гээд хэлчхэд бардамнасан хэрэг болох уу?

Будда болсон бол: "Би Будда боллоо" гэнэ. Учир нь өөрийнхөө Будда чанараа нэгэнт таниад, өөрөө Будда болсноо мэдээд, бас хамаг амьтан цөм Будда гэдгийг мэдсэн тэр цагт бардамнахаар юм огт байхгүй.

Бурхан гэдгээ мэдсэн болохоор хамаг амьтнаас жаахан ялгаатай юм. Хамаг амьтан өөрийгөө Будда гэдгээ мэдээгүйгээс жаахан ялгаатай төдий л юм. Гэвч Будда болсон тэр хүн олон түмэнтэй эрх тэгш гэдгээ мэддэг болохоор бардамнаж чаддаггүй юм. Тэр нэгэнт хамаг амьтантай адил тул бардамнах юм үнэндээ алга. Тийм учраас Будда болох нь тун энгийн явдал, сэтгэлийн авшиг хүртмэгц Будда болно.

Буддагийн далайтай нэвтрэлцэж, бид бас энэ далайн ус болно. Нэг дусал ус далайд унаж, далайтай нэвтрэлцээд далай болчихсон байтлаа: "Би хэзээ далайд нийлэх юм бэ" гэж асуух гэж үү? Далай дотор байсаар байж шүү. Аажмаар арилж уусаад эцэстээ бүр далай болно.

Түүнчилэн бид сэтгэлийн авшиг хүртэх үедээ нэгэнт Буддагийн далайд ороод Будда болсон билээ. Бидний хүч чадал сэтгэшгүй их, гагцхүү хэрэглээгүй азнаж буй төдий л юм. Хэрэв цаг нь болоод хэрэглэвэл хүч чадал маань хичнээн ихийг мэдэх болно. Гагцхүү та өөрөө л мэдээгүй байгаа болохоос үнэндээ бол одоо ч хэрэглэж буй. Наманчилж бясалгаад сууж байхдаа хамаг амьтанд ач тус хүргэж байгаа юм.

Бид хэлбэлзлийн хүчээрээ бүх улс орныг гийгүүлж, бүх орчлонгийн далд ухамсарыг дээшлүүлэх юм. Үүнийг мэдээгүй нь дээр. Мэдчихвэл нь бидэнд "би" хэмээгч үүсэх болно.

Энэ нь удтал бясалгасны дараа Төгс Гэгээрсэн Багш болж чадах эсэхийн гол шалтгаан юм. Эхлээд өөрийнхөө "би"-г дадуулах хэрэгтэй, өвөрмөц чанараа боловсруулах хэрэгтэй, өөрийнхөө "би"-г тэвчин барих хэрэгтэй. "Би" хэмээгч арилсны хойно л бид энэхүү угаас нэгэнт бүрэлдсэн хүч чадлаа хэрэглэхэд аюулгүй болно.

Буддагийн сургаалиар бол ял, муу гэж байхгүй, бас сайн гэж байхгүй юм. Ялгүй, муугүй, сайнгүй нь яг бяцхан хүүхэд шиг гэсэн үг юм. Юуг гэм зэм, юуг муу гэдгийг бяцхан хүүхэд мэдэх билүү? Мэдээж мэдэхгүй. Тэдний сэтгэл үнэнхүү цайлган. Тиймээс эргээд хүүхэд болох гэдэг нь ийм санаа билээ.

Будда болсны дараа сайн гэж байхгүй, муу гэж байхгүй болохоор зургаадугаар үеийн багш Хүй Нэн бас: "Сайн гэж бодохгүй, муу гэж бодохгүй нь Будда чанар мөн болно" гэж хэлжээ.

Тиймээс Будда хэзээ ч гэм зэм хийхгүй. Тэр юу хийсэн ч ерөөс гэм зэмгүй юм. Гэм зэм хийхгүйн учир гэвэл тэрээр хамаг амьтан эндүү ойлгохоос айна, хамаг амьтан ойлгохгүйгээс айна. Хэдийгээр Буддагийн билэг нээгдсэн ч хамаг амьтны билэг хараахан нээгдээгүй болохоор Буддагийн хийсэн бүхэн хуульд нийцдэг (4).

## ***БУРСАН ХУВРАГ***

Бурсан хувраг гэдэг нь Бурхан Бодисадва, Архад, Гэлэн, Гэлэнмаа. Багшийгаа дагаж бясалгаж буй та нар бол бодисадва мөн.

Бурхан бодисадва гэдэг нь дотоод хувиралт, далд ухамсрын хувиралт, сүнсний хувиралт, зэрэг дэвийн хувиралт болон билиг нэгэнт нээгдсэнд оршино (3, х 71).

## ***БУРХАН***

*Үзэх: Дао, Түүнчилэн ирсэн*

Дотоодод маань хамгийн дээд Бурхан бий. Энэ бол сүнс, дотоодын багш, өөрийн билиг ухаан мөн (6, х 383).

Сэтгэлийн авшиг хүртмэгц агшин зуур билиг нээгдэж цэцэг дэлгэрэн Бурхан харагдаж, тэр дороо мөн чанараа үзэж Бурхан болно (5, х 139). Бурхан гэж билиг нээгдсэн хүн, их сэхээрэгчид, төгс туулсан Их багшийг хэлж байна. (5, х 141). Бид Бурхантай уулзаж байгаа үедээ даруй Бурхан мөн. Бурханы оронд очвол, эсвэл Бурхантай адил мөн чанартай Бурхантай хамт байж чадна. Тиймээс Бурханы оронд очиж байвал Бурхан болох нь тэр. Бурханы гэрлийг харж байвал Бурхан болжээ. Бурхан ийм л байдаг юм (5, х 141). Бурхан болох нь тун энгийн явдал. Сэтгэлийн Авшиг хүртмэгц Бурхан болно. Бурханы далайтай нэвтрэлцэж бид энэ далайн ус болно. Нэг дусал ус далайд дусаж далай болчихсон хэрэг (5, х 147). Аажмаар бүрэн уусч эцэстээ далай болно (5, х 147).

Бурхан болсоны хойно сайн, муу аль нь ч байхгүй болохоор 6-р үеийн Их багш Хүй Нэн: “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй нь Бурхан чанар мөн” гэжээ (5, х 155).

Хүн бүр төрөлхийн Бурхантай, учир нь Бурханы орон бидний дотоодод маань байдаг. Хүн бүрд байдаг болохоор түүнээ эрж олж чадна. Тэгэхдээ бүр агшин зуур шүү. Та үүнийг хүссэн даруйдаа л олоод авчихна, ийм хурдан. Бурханы орныг олчих юм бол энэ нь үүрд мөнх байх болно. Бид оюун сэхээрэл, билгүүн ухаан, аз жаргал баяр цэнгэл ер юу л олдогсон бай тэр нь хэзээд биднийх байх ба хэзээ ч үл шамшигдана. Хэн ч түүнийг биднээс хулгайлж үл чадна (2, х 84).

Бурхан гэдэг нь Төгс Гэгээрсэн Их Багш гэсэн үг. Цог чанар нь: Бүрэн төгөлдөр, элбэрэлтэй, цэцэн мэргэн, ном хаялцах чадвартай, гоё сайхан, хүмүүнд эетэй, хаа очсон ч хүн бүр бахархдаг (6, х 154). Бурхан Багш бээр тэгш сэтгэл, түгээмэл хайр, нигүүлсэнгүй сэтгэлтэй (6, х 193), хатуу зоригтой, эрэлхэг, хүлцэнгүй (6, х 148). Хүлцэнгүй гэдэг нь аливаа юмыг эцэст нь тулгал хийх гэсэн утгатай (6, х 148). Бурхан болчихвол “Би түүнчлэн ирсэн” боллоо гэж хэлж болно. Түүнчлэн ирсэн гэдэг нь ирэх ч үгүй, очих ч үгүйг хэлнэ 6, х 208). Хамаг амьтны дэс адилгүй тул бүгд Бурхан болж чадахгүй 6, х 145). Бурхан орчлонгийн үйлийн үрд гар дүрэхгүй 6, х 227).

Бурханаар бахдан баясч, Бурханд итгэж байгаа чинь Бурханд барьж буй бэлэг (34).

Таны үйлдэх ёстойг Бурхан үйлдэж байгаа. Үүнийг л мэдэх төвшинд хүрэх хэрэгтэй (7). Зүгээр л Бурханыг сана. Тэгээд юу үйлдэж байгааг чинь Бурхан үйлдэж байгаа. Одоо та, би, чи гэсэн ойлголт байхгүй болсон. Бурхан хэнийг ч удирддаггүй. Харин Бурханыг санамагц та аливаа зүйлийг давхар давхар үйлдэж байдаг. Үүнийг мэдээж та биш Бурхан үйлдэж байдаг (7, 3-р хэсэг).

Сэтгэл дүүрэн байхын тулд бид 2 зүйлийг хийх хэрэгтэй. Нэгд, дэлхийнхээ үүрэгт анхаарал тавих, хоёрдугаарт гэгээрэх. Гэхдээ эхний үүргээ бүр сайн гүйцэлдүүлэх хэрэгтэй.

Бид энэ дэлхийг адислахаар, мөн өөрийнхээ аугаа ихийг таньж мэдэхээр энд байгаа юм. Бид өөрийгээ аугаа их гэж мэдмэгц бүхий л орчлонгийн хүчтэй нэгдмэл болно. Тэгээд бидэнтэй холбогдсон хэн ч бай орчлонгийн энэ хүчээр адислагдах болно.

Хүний амьдралын зорилго нь Бурханыг танихад оршино. Бурханыг таних гэдэг нь бид аугаа их гэдгээ, бүхэл орчлонгийн хүчний хэсэг нь юм гэдгээ мэдэхийг хэлнэ. Хэдийгээр хэсэг нь гэж хэлж байгаа ч үнэндээ бол бүхэлд нь гэж хэлж байгаа хэрэг юм. Завсрын салангид жижиг холбоосууд Авшиг авах үед эргээд холбогдохдог юм. Бид дотогшоогоо хандаж, дотоод уруугаа нэгдэж байвал нь залгагдан холбогдож, залгагдсан л бол бүх л орчлонтой нэгдмэл болно. Ингэж бид бүрэн бүтэн болно. Энэ нөхцөлд бид ойртсон хэн бүхнийг гараа хүргэлгүй,



түүнд зориулж тусгайлан юу ч хийлгүйгээр адислах болно. Бид хэн нэгнийг сонирхох юмуу цусан холбоотой бол тэд аврагдах буюу бусад хэлбэрээр адислагдана (56).

Бурханы үйлдэл нь би-үгүй үйл тул үйл үргүй (5, х 155).

Бурхан сайн ч биш муу ч биш. Тэр зөвхөн үл ялгаварлахуй болоод хайр энэрлийн далай юм. Бурхан үзэн ядахуй хийгээд бохир бузар, муу муухай, нүгэл хилэнцийн алийг нь ч мэдэхгүй. Тэр сайн ба муу, сайхан ба муухайг хооронд нь ялгадаггүй. Тиймээс бид Түүнийг Хайр Өршөөлийн далай гэдэг юм (2, х 88).

## **БУРХАН ЧАНАР**

*Үзэх: Самади, Адислал*

Бид Бурхан чанараа олж авах, Оройн Дээд Их Бурхантай нэгдмэл болох гэж бясалгаж байгаа (1, 253).

Бурхан болсоны дараа сайн, муу аль нь ч байхгүй болохоор 6-р үеийн Их Багш Хүй Нөн “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй нь Бурхан чанар мөн” гэжээ (3, х155).

Бурхантай нэгдсэнээр 'би, өөрөө' гэх юм аяндаа байхгүй болно. 'Өөрөө' аажим аажмаар алга болно. Өөрийгээ мэдрэх нь улам багасч, тэгээд та улам алга болсоор байх болно. Энэ бол бидэнд үл ойлгогдох Оройн Дээд Их Бурханы гажууд үнэн юм (1, х 41).

Хүмүүн бид аливааг Бурханлиг оршихуй буюу Дээд оршихуйн эсрэг хийж байдаг. Бид тэр дээр байвал юу ч хийх хэрэггүй байхсан. Бидэнд идэх хэрэгцээ үгүй, мөнгөний төлөө санаа зовох шаардлагагүй, секс, гэр бүл, хайр дурлал хэрэггүй. Ер юу ч хэрэггүй. Тэгэхээр бидний үйлдэл бүхэн байх ёстойгоос маань эсрэг байдаг байх нь. Ингэж бид өөрсдийн Жинхэнэ мөн чанарыг олж таньдаг юм (4).

*Хүн, амьтны бурханлиг чанар (6)*

<b>Хүн, амьтны бурханлиг чанар</b>	<b>Хувиар, %</b>
Хүнийх (байвал зохих)	100
Одоогийн байдал:	
- Хүн төрөлхтний 2%	87
- Хүн төрөлхтний 5%	65
- Хүн төрөлхтний дундаж	50
- Хүн төрөлхтний хамгийн бага нь	40
- Үлдсэн хэсэг нь	Янз бүр
Хамгийн өндөр бурханлиг чанартай амьтад:	65
1. Нохой	61
2. Адуу 3. Далайн гахай, халим 4. Шувуунууд, тоть г.м 5. Тагтаа 6. Туулай 7. Үхэр 8. Буга 9. Яст мэлхий 10. Оцон шувуу 11. Тогос 12. Далайн хав 13. Гахай	

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай айлдахдаа: “Ихэнх хүмүүс сүнслэг ядуурлын байдалд орсон байгаа учраас дайн болон бусад асуудлууд байсаар байна. Нийт хүн амын 80% нь дордсон буюу өөрсдийн бурхан чанарын түвшинг дордуулж, зөвхөн 50%-ийн бурхан чанартай болсон. Учир нь бид бусдад буюу хүн, амьтанд, юунд ч бай муу зүйл хийх бүрд, байгаль орчинг шаардлагагүй устган сүйтгэх дутамд улам доод ухамсар луу буурч, сүнслэг ядуурлын түвшинд очдог” хэмээжээ.

**БУРХАНЫГ БУЮУ ИХ БАГШИЙГ ДУРСАХ (САНАХ)**

Арьяабалын номын цогц 3 бүлэгтэй (5, х 96). Энэ нь Гэрэл ажих, Аялгуу ажих болон Буддаг дурсах болой (5, х 105).

Заавал самади агуулахыг хүлээлгүйгээр Буддаг бие хэл сэтгэлээр 2,5 цаг тахиж дурсах хэрэгтэй (1, х 144).

Санаж дурсах бол хоёр хүний хооронд үүсэх сэтгэл. Арьяабалын номын цогц нь Буддаг дурсахыг сургана (5, х 103). Буддаг хараагүй бол яаж санан дурсах билээ (5, х 79).

Багшийнхаа тухай бодсоноор Багштайгаа нэг болж, Багш бол та өөрөө юм байна гэдгийг ойлгоно. Багш бол таны Жинхэнэ мөн чанар юм. Багшийг бодох замаар Багшийн тань бүх чанарууд танд дамжин ирж, Багшаараа дамжуулан та Мөн чанараа таньж олно (1, х 42).

Багшийг санаж, Бурханы ухамсарт 24 цаг орших гэдэг нь Багшийн сургаалыг үргэлж санаж, түүгээр амьсгалж, амьдарч, дагаж мөрдөн хэрэгжүүлэхийг хэлнэ.

Шавь ямагт Бурханыг дурсаж байх ёстой. Тэгвэл Оройн Дээд Их Бурхан хаа сайгүй байх болно (2, х 126).

Бурхантай уулзаж байгаа үедээ бид даруй Бурхан мөн (3, х 141).

Бурханы гэрлийг үзвэл Бурхантай нэгэн цогц болж Бурхан болно. Бурханы аялгууг сонсвол их бага ч гэсэн Бурхантай нэгэн цогц болох юм. Доод зэргийн аялгуу ч Бурханы аялгуу, доод зэргийн гэрэл байсан ч мөн л Бурханы гэрэл болно (3, х 137).

Багшийгаа санавал Багшийн цог чанар тэр талд уламжлагдан очоод түүнтэй нэвтрэлцэн үйл түйтгэртэй нь солио хийх юм.

Үйл түйтгэрийг нь Багш чинь татаж аваад Багшийн билиг ухаан чамд уламжлагдан, хоёулангийн нь үйл түйтгэр хийгээд буян солигдох болно (6, х 15).

Их Багш дэргэд чинь үргэлж биеэрээ байхгүй. Харин сургаалийг нь дагавал Багштай нэг болно (31).

Бурханыг дурсах үед өөрийгээ мартана гэсэн үг. Энэ бол самади агуулах явдал. Билиг самади юм (6, х 386).

Бурханд төвлөрч байхад бүх юм зэрэг дэвшинэ. Тэгээд л боллоо. Энэ нууцыг хүн бүрд хэлээрэй. Ийм хялбар (7). Бурхантай хамт байхдаа бүхий л хорвоог мартана.

Бурхантай хамт байхад хог новш гэж байхгүй болно. Бурханы дэвшилд 6 мэдрэхүй маань хэрэггүй хог новш болдог. Маяагийн урхинд ордог. 6 мэдрэхүйгүй байснаар дотоод жинхэнэ мөн чанартайгаа хамт байна, Буддатай хамт байна. Үнэхээр энгийн.

Бурханыг санаж байхад хүсэл гэж байхаа байна. Бурхантай хамт байхыг дэвшил гэдэг юм, ингээд боллоо. Бүх чадлаараа Бурхантай хамт байхад бие, хэл, сэтгэл чинь бас Бурхантай хамт байна. Ийм байхад яаж унах юм бэ. Та нараас салъя гэвч би салж чадахгүй, тэгэхээр яаж унах юм бэ (7).

## ***БУРХАНЫ ОРОН***

*Үзэх: Бясалгал, Чинагуух ертөнц*

Бурханы орон дотоодод маань оршдог (2, х 147).

## ***БУРХАНЫ УХАМСАРТ ОРШИХ***

*Үзэх: Бурханыг дурсах (санах)*

## ***БУЯН, НҮГЭЛ***

*Үзэх: Үйлийн үр*

Бясалгал нь таны олж авах хамгийн дээд буян. Хүний сүнсийг сэрээж буян руу хандуулах нь их буян. Буян их бол ядаж л оюун санааны хүрсэн төвшнөө хадгалж үлдэнэ. Буян багасвал оюун санааны төвшин доошилно. 1 цаг бясалгахад 100 000 сүнслиг оноо, мөн хугацаанд самадид орсон бол 500 000 оноо хураана (66). Буян юмыг сайн тал руу, Үйл үр муу тал руу өөрчилдөг (68).

Буян хариулал их бол үйлийн үр үтэр түргэн ариусна. Бид бясалгаж байхдаа бусад амьтанд тус болох боломжтой. Ингэснээрээ бас илүү их буян хураадаг (1, х 292).

Ганцаараа бясалгавал ганц л хүний буян хураана. Харин өөрийн хүч чармайлт, ярих ур чадвараараа уриалж, эсвэл байраар хангаж 100 хүнийг бясалгуулвал өөрийнх дээрээ 100 хүний буяныг нэмж хураана. Энэ нь 100 дахин хурдан дэвшинэ гэсэн үг. 100 хүнийг Авшиг авахуулахаар ирүүлвэл буян нь та нарт ч ирнэ. Яагаад гэвэл эцсийн дүндээ бид бүгдээрээ нэгэн цогц юм. Тийм болохоор хичнээн олон хүнтэй холбогдоно, тэр хэмжээгээр тэлж буян маань асар их арвиждаг (1, х 293). Бясалгалын төвийг маш олон хүн ашигладаг учир иймэрхүү ажлыг хийснээрээ нэгэн зэрэг олон хүмүүнд өрөө буцааж төлөх боломж гардаг. Өрийг бүхлээр нь төлөх арга зам энэ (1, х 278). Ингэж л үйлийн үр хурдан арилдаг юм (1, х 278). Бусдын тусыг бүтээснээр өөрсөддөө тус болж байдаг (1, х 285). Энэ бол сүнсээ ариусган дэвшүүлж, өсч хөгжин гэгээнтэн болох зам юм (1, х 286). Хир ихийг бусдад зориулна, тэр хэмжээгээр хурдан дэвшинэ (1, х 265). Энэ дэлхийд үнэгүй зүйл гэж огт үгүй. Тиймээс ч та нар надаас яагаад буян хураах ёстойг асууж байгаа. Амьд явахын тулд ингэх ёстой юм (40).

#### **Буян (40)**

<b>Буяны төрөл</b>	<b>Хураах буян (сүнслэг оноогоор)</b>
Эмч (жилд)	500 000
Сувилагч (жилд)	300 000
Эмийн сангийн эзэн (жилд)	600 000
Эм зүйч (жилд)	300 000
Эмийн сангийн ажилчин (жилд)	100 000
Бусдын төлөө машин барьдаг жолооч (жилд)	400 000
Такси, хувиараа мөнгө олох гэж машин барьдаг жолооч (жилд)	200 000
Цэвэрлэгч (жилд)	100 000-200 000
1м зам барихад тусалвал	1000-5000
1м гүүр баривал	2000-7000
Тоосгон байшин барихад тусалвал (100м <sup>2</sup> )	10 000
4 хүний зөөврийн байр барихад тусалвал	8000
Нэг га газар органик ногооны аж ахуйэрхлэхэд (жилд)	300
Цагаан хоолны газар ажиллуулахад (жилд)	5000
1 м хувцас оёход	100-500
1 оёдлын машинтай компани эзэмшихэд	20 000-100 000
1 цамц, өмд (жилд)	500-1000
Хувцасны дэлгүүр эзэмшвэл (жилд)	20 000
Амьтны арьс ороогүй 1 хос гутал оёход	200-1000
Хүүхдээ өөрөө өсгөвөл	50 000-300 000
Хүүхэд өргөж авч өсгөвөл	70 000-600 000
Амьтан, шувууны амь аварвал	200 000-900 000
1 нохойг цагаан хоолоор тэжээж өсгөхөд (жилд)	4000-6000
1 шувууг цагаан хоолоор тэжээж өсгөхөд (жилд)	3000-10 000

Тайлбар: Дээр дурдсан буян нь олз ашгийн төлөө бус харин өөрийн үйлийг бусдын төлөө хариу нэхэлгүй зориулсны буян хариулал болно.

## Нүгэл (40)

<i>Нүгэл хилэнц</i>	<i>Алдах оноо буюу нүгэл хилэнц (буяны онооноос хасагдагдах хэмжээ, оноогоор)</i>
1 мод тайрч устгахад	100 000-500 000
1м <sup>3</sup> ус бохирдуулвал	100 000-400 000
1м <sup>3</sup> агаар бохирдуулвал /тамхи татах, машин унах, хог шатаах гм/	1 00 000-400 000
Хүний амь хороовол	1-2 тэрбум
Загас агнуурын завь эзэмшдэг бол /жилд/	500 саяас 3 тэрбум
Загасны ажил эрхэлвээс /жилд/	300 саяас 1 тэрбум
Тамхи зарвал	100 саяас 1 тэрбум
Архи зарвал	200 саяас 1 тэрбум
Мах, өндөг, загас зарвал	200-500 сая
Архиар үйлчилдэг цэнгээний газаражилладаг бол /жилд/	100 000-400 000
Мал нядалгааны газар ажиллуулдаг бол/жилд/	500 000-6 тэрбум
Махны аж ахуй /мал бордох/ эрхэлдэг бол/жилд/	1- 3 тэрбум
Загас, махан хоолны ресторан эзэмшдэг бол /жилд/	500 000- 1 тэрбум
Махан хоолны газар орох (хооллохгүйгээр,1 удаад)	300
Амьтны гаралтай ямар нэг бүтээгдэхүүн идэхэд (1 удаад)	700-1000
Морфин, опьом, кокаин зэрэг мансууруулах бодис зарвал	2 00 саяас 1 тэрбум
Хүний наймаа хийх, биеийг нь үнэлүүлэх	600 000-900 000
Мөрийтэй тоглоомын газар ажиллавал /жилд/	50 000-500 000
1 удаа 1 цаг мөрийтэй тоглоомын газар мөнгөний төлөө бус зугаа маягаар тогловол	30 000-100 000
Зурагтаар муу, хичирхийлэлтэй кино 1 цаг үзэхэд	300
Дэлгүүр хэсэх (1 удаад)	200

Буян хариулал гэдэг нь хүн болж юмуу тэнгэрт төрөл авахыг хэлнэ (6, х 330). Хэрэв хүмүүнд буян хариулал заадаг бол тэр нь ертөнцийн ном болно. Ертөнцөөс туулан ангижрахыг заавал тэр нь ертөнцөөс хэтийдсэн ном болно. Юу ч хийсэн бай мөнх бусыг л ойлгох хэрэгтэй (6, х 334). Дэлхийг аврахад маш их буян хэрэгтэй. Амьтдыг тэжээх бус зүгээр орхих, алж тамлахгүй байх, энэрэнгүй байх, хүн, амьтан, бусад оршнолуудыг хайрлах, дэлхийг аврахыг хүсч цагаан, ногоон хоолтон болох нь маш их буян хураана Бурханы нэрийг барьж бусдад үйлчил, өөрийгөө умартаж үйлчил. Ямар нэг сайн үйл хийхэд хувь заяа маань өөрчлөгддөг. Сайн үйлээрээ өөрийгөө мөн адислаж байдаг (79).

## **БЯСАЛГАЛ**

Үзэх: *Аръяабалын буюу Гэрэл, Аялгууны бясалгал*

## **ВЕГАН ХООЛ ХҮНС**

Үзэх: *Сахил, Цагаан хоол*

Веган хоолтой байх нь манай дэлхий өндөр ухамсар луу дэвших нөхцөл мөн. Нийгэмшсэн, соёлт аль ч бусад ертөнцөд амьтны амь таслах тухай ойлголт огт үгүй. Веган хоолтой байснаар дэлхийг аварч, улмаар дэвшүүлнэ. Махан хоолыг дэлхийгээрээ веган хоолоор сольвол дэлхийг

дулааруулагч хийнүүдийн хэмжээг 60% бууруулна. Ийм маягаар дулаарлыг даруй зогсоож дэлхийгээ аврах юм. Энэ арга бол хүмүүс өөрийгээ болон гараг ертөнцөө хамгаалах хүчтэй бамбай юм. Бас хүмүүн бээр энэрэл нигүүлсээ тэлэх шилдэг арга мөн. Амьдралыг аврах шилдэг арга мөн. Хамгийн дээд билиг ухаан бол нинжин сэтгэл юм. Хүн хайрлаг чанараа хөгжүүлж болно. Хүчирхийллээс нигүүсэл рүү шилжүүлэхэд л болно (42).

Веган хоолтон байх нь бүр жинхэнэ утгаараа бидний өөрөө өөртөө барьж буй бэлэг юм. Веган хоол идсэнээр бидний үйл түйтгэр, өр ширийн хүнд ачаа дарамт багасан хөнгөрч, тэр хэмжээгээр өөрсдийгөө улам сайн сайхнаар мэдэрч, амьдрал ахуй маань дэвжин сайжирч, өмнө маань цоо шинэ, тансаг нандин, дотоодын тэнгэрлиг ертөнцөд нэвтрэн орох үүд нээгдэх болно. Энэ бүхэн таны багахан зүйл хийснийхээ төлөө олж авч буй ихээхэн завшаан юм (23).

Веган хоол идэх нь танд энэ дэлхий дээр улам амар амгалан амьдрах боломж өгнө.

Ургамал идэх нь амь хороож байгаа явдал мөн бөгөөд тэр нь зарим талаар үйл түйтгэр бий болговч нөлөө нь тун бага. Өдөр бүр Арьяабалын Бясалгалыг хоёр цаг хагас хийдэг хүн энэ үйл түйтгэрээс салчихаж чаддаг юм. Бид амьдрахын тулд хоол идэх ёстой тул мэдрэл, зовиураар хамгийн бага тийм хүнсийг сонгох хэрэгтэй юм. Ургамлын 90% уснаас бүтдэг тул ухамсрын төвшин доогуур, зовлон шаналлыг бараг мэдрэхээргүй байдаг. Цаашлаад бид өчнөөн төчнөөн ургамал ногоо идэхдээ үндсийг нь тасалдаггүй, харин ч навч мөчрийг нь тасдаж үржилд нь тус болдог юм (23).

Миний доторх Оройн Дээд Их Бурхан үүнийг хүсч байгаа учраас би веган хоолтон болсон юм. Мах идэх нь хөнөөгдөхийг үл хүсэх орчлонгийн хууль ёсыг зөрчинө. Бид өөрсдөө үхлийг хүсдэггүй, мөн өөрсдийнхөө юмыг алдахыг хүсдэггүй. Хэрэв бид бусдад ингэж хандвал энэ нь өөрийнхөө эсрэг үйлдэж байгаа хэрэг болох бөгөөд энэ нь биднийг зовоож шаналгана. Таны бусдад хийсэн хор хөнөөлтэй үйлдэл бүхэн өөрийг тань зовоодог. Та лав өөрийгөө хазаж хутгалж чадахгүй, болох ч үгүй. Үүнтэй адилаар та амь хороож болохгүй, хороовол амьдралын хуулийг зөрчсөн явдал болно. Өөрсдийгөө зовоон шаналгах үйлдлийг бид хийх хэрэггүй.

Энэ бол бид өөрсдийгөө ямар нэг байдлаар хязгаарлаж байгаа хэрэг биш. Бидний амь амьдрал, амьдралын бусад бүх хэлбэр лүү дэлгэрэн дэгжиж, тэлж байгаа хэрэг. Бидний амьдрал зөвхөн энэ биеэр хязгаарлагдахгүй, харин ч амьтан хийгээд бүх төрлийн амьд биетүүдийн амьдралд хүрч томрох болно. Энэ нь биднийг улам агуу их, хүчирхэг, аз жаргалтай, хязгаарлагдашгүй болгоно. Эрүүл мэнддээ санаа тавих бүхий л шалтгаанаар, шинжлэх ухаанч байх бүхий л үүднээс, энэрэл нигүүлсэлийн бүхий л үүднээс бид веган хоолтон байх ёстой. Мөн ертөнцийг аврахын тулд ч бид веган хоолтон байх ёстой. Барууны орнууд болон Америкт хүмүүс долоо хоногт ганц удаа веган хоол идэх юм бол бид жил бүр арван зургаан сая өлөн зэлмэн хүнийг аврах боломжтой болно гэдгийг зарим судалгаагаар тогтоожээ (23).

## **ГЭГЭЭЛИГ, САЙН, МУУ ЧАНАР**

*Үзэх: Нинжин чанар, Хайрлиг чанар, Эрхэм ариун чанар*

## **ГЭГЭЭРЭЛ**

*Үзэх: Авишг, Арьяабалын бясалгал, Бясалгал, Дао, Туулан тонилох, Хайр, Хоосон чанар, Би үзэл*

Эхний зорилго: Бурхан чанараа олж авах, Эзэн Бурхантай нэгдэх (1, х 253).

Гэгээрэл бол зөвхөн эхлэл юм. Цаашаа болзол нөхцөлгүй, хязгааргүй хайрыг олж авахын төлөө л явах хэрэгтэй (43).

Эцсийн зорилго бол туулан тонилох юм (3, х 202).

Гэгээрэл гэдэг амьдралаас ч агуу, нүдээрээ харж бие эрхтэнээрээ хүртэн мэдэрч чадах зүйлсээс ч агуу зүйлийг танин мэдэх үйл явц юм. Чухамдаа өөрсдийн маань дотоодод оршигч бүх орчлон ертөнцийн жинхэнэ эзэмшигчийг таньж мэдэж эхлэх агшин, дотоод сэхээрэл юм. Энэхүү дотоодын эх булаг нээгдсний дараа Христ шиг, Будда шиг хүчирхэг болж хувирна (2, х 89).

Гэгээрэл бол Оройн Дээд Их Бурханы бэлэг болохоос өглөг буян үйлдсэний үр дүн биш. Гэгээрэл гэдэг нь бүрэн төгс гэгээрчихсэнийг илтгэж байгаа бус. Гэгээрлийн амтыг мэдэрсэн хүн цаашид үүнийгээ гүнзгийрүүлэх урам зоригтой болдог.

Гэгээрснийхээ дараа би ертөнцийн хамаг амьтан бие биедээ шүтэн барилдсаныг олж харсан билээ. Бидний мөн чанар нэгэн ижил, бид бүгдээрээ нэгдмэл юм. Би үүнийг ном судраас уншсан юм биш, Би үүнийг олж үзсэн юм (2, х.154). Буддатай, Исүстэй адил болсноор хамгийн дээд дэсэд хүрэх бөгөөд тэр үед та ертөнцийг аврах хамаг хүч чадлыг олж, үхэх төрөхийн хүрд ба зовлонгоос ангижирсан байх болно. Та билгүүн төгс, хамгийг мэдэгч, хаа сайгүй оршигч болно. Үр дүнд бүү хүлэгд. Юунд ч хүлэгдэхгүй болсон цагт гэгээрнэ (1, х. 98 ба 115).

Ялгаварлах сэтгэл их байдгаас бясалгавч Бурхан болж чаддаггүй. Сэтгэлдээ үргэлж “миний, чиний” гэж боддог бодохоор Бурхан болж чаддаггүй (6, х 312). Олон хүн Бурхан болж чаддаггүй нь сэтгэл хэт явцуугаас болдог (6, х 319). Ертөнцийн цаадах зүйлүүдтэй учирч тааралдаад ирэхийг гэгээрэл гэдэг (84).

Зэн буддизмд гэгээрсэн, гэгээрээгүй хүний ялгаа 1 ширхэг үсний ялгаатай гэдэг. Гэгээрсэн, гэгээрээгүй ялгаа нь үнэндээ бол ямар ч ялгаагүйд оршино. Ганцхан ялгаа нь анхаарал юм. Энэ бие махбодид болон хүрээлэн буй орчин, материаллаг ертөнцийн юм бүхэнд анхаарал хандуулж байвал материаллаг ертөнцийн хүмүүс болно. Дотоод сэтгэл рүүгээ, бидний дотор орших төрөлхийн бөгөөд хэзээ ч устаж алга болохгүй Будда чанартаа анхаарвал бид Буддагийн хутгийг олно. Ялгаа гэвэл ердөө л энэ. Бид Буддаг дотроо агуулж буй учир Будда гэдгээ санахад цаг орохгүй. Гарын доош харсан алгыг дээш харуулах шиг анхаарлаа дотогш хандуулах хэрэгтэй.

Гэгээрсэн хүмүүсийн хийж буй бүх үйл нь хамаг амьтны тусын тулд байдаг. Аливаа зүйлийг үйлдэх ба эс үйлдэх, авах ба эс авах, тэр ч байтугай идэх уух гэх мэт юу ч хийж байсан тэр нь бусдын тусын тулд байдаг.

Агуу Их Багш нар, гэгээрэгсэд нь байх, байхгүй алинд ч үл татагдах ба учир нь тэд ертөнцийн юмс мөн чанараараа оршдоггүйг ойлгодог. Бурханы орныг хэдийнээ мэддэгт оршино. Гэгээрэл, мартагнал хоёрын ялгаа үсний ширхэгийг тоолохын дайтай. Иймд өөрсдийгөө санаж мэдэхийн тулд гадаад ертөнцийг мартаад дотогшоогоо жинхэнэ ертөнц рүү хандвал зохино. Аз жаргалгүй зовж байгаа нь бурхан чанараа мэдэхгүй байгаатай холбоотой (48). Гэгээрэл бол энэ ертөнц дээрх бүх юмыг ариусгах, анагаах цорын ганц арга мөн (51).

Өөрийн гэх үзэлгүй, нэр алдар, эд баялаг, эрх тушаалыг дахин хэрэглэхгүй болж, орчлонгийн гаслан зовлон хэвээр оршиж байвч биднийг төлөөлж чадахгүй болж, бидний дотор юу ч үгүй хов хоосон болох үед Хан Хурмаст бидэнд билиг ухаан ба хайрыг дүүртэл цутгаж өгөх юм (6, х 378). Харин бид “би” хэвээрээ байж хоосорч чадахгүй бол Хан Хурмастын соёрхох хүчийг бүрэн хүлээн авах аргагүй. Эхлээд “би” байхгүй болж хувираад, үнэ цэнгүй, нэр алдаргүй “зарц” болж хувирах ёстой. Энэ бол Төгс Гэгээрсэн Багш болох нөхцөл болно (6, х 378).

## ***ГЭР БҮЛ***

Бурхан биднийг эхнэр, нөхрөө дассан сурсанаараа хайрлахыг хориглохоор тийм явцуу бодолтой нэгэн биш юм. Өөртөө ирүүлэхийн тулд хайртай хосуудыг хагацуулах харгис нэгэн ч биш. Бурхан болоод бусад төрөлтөнүүдийг, түүний дотор өөрийн гэр бүлээ хайрлахын тулд бид зүрх сэтгэлээ уужим болгох хэрэгтэй. Бид харь холын хүмүүсийг

хайрлаж чадаж байгаа юм бол яагаад гэр бүлийн гишүүд, ойр дотны хайрт хүмүүсээ хайрлаж чадахгүй гэж? Гэр бүлээ хайрла, тэднийг үнэн сэтгэлээсээ хайрла. Тэгвэл тэд бас таныг хайрлах болно. Энэ хайрын ачаар бид сэргэлэн цовоо, аз жаргалтай байх болно. Гадны хүнийг ойлгож, бусдыг ойлгоход бидэнд амархан болно. Гэртээ хариад оролдоод үзээрэй. Энэ бол аз жаргалд хүрэх зам мөн. Хэн нэгнийг хайрлахдаа түүнд аз жаргал өгч, халамжилж хамгаал. Энэ бол жинхэнэ аугаа хайр. Хэрэв түүнээс өөртөө хайр халамж хүсэж, оюун санааг нь самууруулан зовоож байвал хайр биш харин үзэн ядалт юм.

## **ГЭРЭЛ, АЯЛГУУ**

*Үзэх: Арьяабалын бясалгал*

Бурханы оронд очих зам гэрэл, аялгуугаар тоноглогдоно. Бурхан бидэнд гэрлийн хэлбэрээр үзэгдэж, бидэнтэй аялгууны хэлбэрээр ярьдаг. Бурханлиг аялгуу нь Бурханы орноос ирдэг жинхэнэ ном юм. Энэ бол орчлонг ивээгч хайр ивээл хийгээд агуу их билгүүн ухааны хэл юм. Энэ аргаар бясалгаж өндөр дээд төвшинд хүрсэн бясалгагч оюун ухааны төвшинд бүх хэлийг эзэмшдэг. Энэ бол Бурханы орны хэлийг эзэмшсэн Багшийн төвшин юм (2, х 158). Бурханлиг хэлбэлзэл бол амьд бүхний дотор хэлбэлзэж бүх ертөнцийг тэтгэж байдаг. Энэхүү дотоод аялгуу нь бүх шархыг анагааж, бүх мөрөөдлийг биелүүлж, ертөнцийн хамаг хүсэл шуналыг намжаан тайлж чадна. Тэрхүү аялгуу нь бүхнийг чадагч, хамгийг хайрлагч юм. Энэ нь үйлийн үр гэгч анхдагч нүглийн таагүй ул мөр бүхнийг ариусган цэвэрлэдэг. Энэ нь хамаг муу муухай хог новшийг хаман авч оддог их мөрний үер шиг юм. Дотоодын аялгуу нь орчлон дахь бүтээн туурвигч агуу хүч, хамаг бүхнийг тэжээн тэтгэгч юм (2, х 159).

Аялгуу буюу хэлбэлзэл нь бүх ертөнц дахь бүтээн туурвигч хүч юм. Аялгууны урсгалтай холбогдож чадвал Оройн Дээд Их Бурханы хаа буйг мэднэ, эсвэл түүнтэй холбогдож чадна. Гэрэл бол аялгуу, аялгуу бол гэрэл мөн. Багш гэрэл гэхдээ аялгууг хэлж байгаа юм. Цаглашгүй гэрэл бол мөн цаглашгүй аялгуу юм (6, х 62). Дотоодын гэрэл бол тэнгэрийн орон, Бурхан чанар мөн (6, х 162). Удаан бясалгасны дараа юу ч хийхгүй байсан ч дотоодын дуу аялгуутайгаа хамт байж, үүрд салшгүй андууд болно. Тэр бээр хэцүү үед ч бидэнд тусалж, биднийг орлон хамаг ажлыг маань хийж өгнө. Бид тусгайлан энэ тэр ажил гэлгүй, ямар нэг юмыг хүсч эрмэлзэх ч хэрэггүй, аяндаа Будда болно. Тиймээс явсан ч дияан, хоолловч дияан, унтавч дияан, амьдралд дияангүй юм байхгүй болно (5, х 96).

Бидний жинхэнэ мөн чанар бол гэрэл юм (5, х 75). Дотоодын гэрэл бол тэнгэрийн орон, Бурхан чанар мөн (VI боть, х162).

Бодидарма дээд багшийн судрын уламжлалын онолд айлдахдаа: “Таны харсан гэрэл нарныхаас илүү байвал билиг ухаан нээгдсэн хэрэг. Тэр гэрлийг олж, Бурхан чанарыг олж харах буюу тэр хүслэнт ахуйг олвол ном унших, Бурханд мөргөх хэрэггүй” (6, х 258). Энэ бол ном судар, Гурван эрдэнийг муулсан хэрэг биш (6, х162).

Махан бодь доторх хэмжээтэй гэрлийг тэднээс гаргавал цаглашгүй гэрэл болохоо мэднэ. Үүнээс гадна цаглашгүй насан өлзийт болно. Учир нь бид угаас үл төрж, үл үхэх учраас Зүрхэн тайлбарт: “Хамаг юм хоосныг өгүүлж, төрөхгүй ба устгахгүй, хиргүй ба ариунгүй, нэмэгдэхгүй бас хорогдохгүй болой” гэжээ. Сэтгэл самууралгүй больё гэвэл урьдаар Авид Буддаг үзэж цаглашгүй гэрлийг харах хэрэгтэй. Цаглашгүй гэрэлт болсоны дараа цаглашгүй насан өлзийт болно. Энэ үед нэгэнт үхэж төрөхөөс ангижирч, төрөхгүй бас үхэхгүй, ирэх ч үгүй, одох ч үгүй, түүнчилэн ирсэн болно. Анх эхлэхдээ “хэмжээтэй гэрэл” байх юм. Олонтаа хараад энэхүү олон давхар хувцасаа хуу татаж хаясны дараа “цаглашгүй гэрэл”, улмаар “цаглашгүй насан өлзийд болно” (5, х 78).



## **ГЭТЛЭГДЭХ**

*Үзэх: Авшиг, Арьяабалын номын цогц, Их Багш, Гэтэлгэх*

Энэ үе бол Оройн Дээд Их Бурханы нигүүсэл бялхсан эрин үе. Энэ цаг үед хүн бүрд хүрэлцэхүйц их зай, их өршөөл аврал байгаа учраас 'бөөндөж' байгаа гэсэн үг. Ямар ч асуудал байхгүй. Та нар азтай байна шүү. Оройн Дээд Их Бурхан агуу нигүүлсэнгүй, гэхдээ Тэр бээр хэзээ ч одоогийнх шигээ ийм их авралыг үзүүлж байгаагүй. Эрт цагт сайндаа л хэдхэн хүн, магадгүй мянгаад хүн гэтэлсэн байх. Та нар мөн их азтай улс шүү (1, х 305).

Яагаад гэвэл дэлхийн хувьд энэ их цөвүүн муу цаг бөгөөд Их Багшийн хүч биднийг хэт их зовсон гэж үзэж байгаа юм (1, х 301).

Гэтлэгдэх 3 зам (2, х 91-92):

1. Гэгээнтнүүдийн аль нэгэнд итгэн сүсэглэж, Түүнд мөргөн залбирч, хорвоог орхих үед тань адислан чөлөөлж өгөхийг гуйвал та чөлөөлөгдөнө.
2. Их Багшаас Авшиг хүртэж, өөрөө Их Багш болох зам мөр. Энэ нь зөвхөн өөрийгөө төдийгүй хамаг амьтад хийгээд гэр бүлийнхнээ аварч чадах учраас эрхэм зам юм. Энэ бол эрхэм буянтай хэрэг бөгөөд Оройн Дээд Их Бурхан болон Их Багшийн биднээс хүсч байдаг тэр зүйл мөн. Хэрвээ хүн Их Багш болчихвол Бурханы орноос тамын орон хүртэлх үй олон амьтныг аварч чадна. Авшиг авч өөрийгөө танин ухаарахуйн зам мөрийг дагаснаар бидний өнгөрсөн, одоо, ирээдүйн садан төрлүүд бас чөлөөлөгддөг. Учир нь тэдгээр үе үеийн хамаатан садан маань бидэнтэй олон олон төрөл, үе удмыг дамжин үргэлжилдэг авлага өглөг, шалтгаан үр дагаврыг томъёологч Үйлийн үрийн хуулиар холбогдсон байдаг.
3. Өөрийгөө чөлөөлөх гурав дахь зам нь Авшиг хүртсэн хүний садан юм уу найз байх явдал бөгөөд та нэгэнт нас нөгчсөн байсан ч хамаагүй. Та нас нөгчөөд хэдийнээ тамд уначихсан байлаа гэхэд ач охин тань Их Багшаас Авшиг хүртэх юм бол та тэндээс нэн даруй чөлөөлөгдөж Тэнгэрийн оронд очих болно. Хэрвээ Авшиг хүртсэн хүний найз нөхөр нь бол мөн л Их Багшийн ач тусыг хүртэнэ.

## **ГЭТЭЛГЭХ**

*Үзэх: Авшигийн үнэ цэн, Гэтлэгдэх*

Будда болохоо хүлээсний хэрэггүй, сэтгэлийн авшиг хүртмэгц Будда болно. Бидэнд зөвхөн итгэл дутаж, туршлага дутаж байгаа төдий юм.

Олигтойхон бясалгаж, бүрэн гүйцэд даяанч хүчтэй болоод хамаг амьтныг гэтэлгэх үед бид ямар Будда болсноо мэднэ. Гэвч хамаг амьтныг гэтэлгэхийн тулд ном хаялцах эрдэм, билэг ухаан байх хэрэгтэй.

Дотоодод байгаа билэг ухаан ба туршлагыг заавал бүрдүүлэх хэрэгтэй. Гэхдээ гаднах мэдлэг, туршлага дутаж бас болшгүй юм. Ингэж байж сая хамаг амьтныг гэтэлгэж чадна (4).

Авшиг авснаар 5, 6, 7 үүнээс олон үеийн хамаатнууд чинь бас чөлөөлөгдөнө. Чөлөөлөгдөнө гэдэг бол Бурханы оронд Багш нарын оронд очно гэсэн үг биш. Авшигтнууд Багш нарын төвшинд очих боломжтой. Харин төрөл садангууд бол чөлөөлөгдөнө. Тиймээс авшиг бол маш агуу хүч юм. Тэднийг биеэ орхисны дараа багш өндөр төвшинд тэдэнд зааж сургах болно. Тийм болохоор тэднийг бас анхаарч байх юм.

Энэ насандаа хэнд хайртай байсан, хэнийг хайрлаж байсан бүх хүн бас Авшигийн ач тусыг хүртэнэ. Муур, нохой хүртэл. Та нар хэрэв хүсэхгүй бол эцэг эх тань хэзээ ч эргэж төрөхгүй. Тэд харин Авшиг авах гэж л дахин төрж болно. Хэрэв тэд энэ дэлхийгээс хэдийн явчихсан бол хэд дэх үе гэдгээс хамаагүйгээр чөлөөлөгдөх болно. Авшигтан л Бурханы оронд хүрнэ. Бусад нь чөлөөлөгдөнө (74). 5 дахь төвшин бол зөвхөн Авшигтанд хамаатай. Шавь: үхээд 4-р түвшинд очсон шавь Будда болохын тулд эргэж төрөх ёстой юу? Их Багш: Үгүй багш хэнийг ч орхихгүй. Тэнд нь суралцуулдаг юм. Шавь өөрийгөө ухамсарлах хүртэл нь сургана (51).

### *ДААТГАЛ*

Багшдаа даатгахгүй бол Багш нь тусалж чадахгүй (3, х 67). Чин сэтгэлээсээ даатгах юм бол заримдаа самадийн хүслэнт ахуйд ордог. Энэ бол Бурханыг дурсах самеди. Бурханыг дурсах үед өөрийгээ мартана гэсэн үг. Энэ бол самеди агуулах явдал мөн. Залбирч суунгаа номын гайхамшигт баясгалангаар бялхсан ахуй ойлголтыг эдэлж, аливаа эгэл дадал нисваанисыг мартдаг. Оюун сэтгэл нэгэн зүйлийн туйлын баяр баясгалан, туйлын нам жим хүслэнт ахуйд орох болно. Та нисваанис, айж эмээх юмгүй болно. Энэ бол самеди юм. Самадийн хүслэнт ахуй нь биднийг зовох юмгүй болгож, ерөөс ямар ч асуудалгүй, аливаа бүхэн цөм төгөлдөр сайхан санагдах болно. Ийм байдалд ертөнцийн түмэн бодис өөр өөрийн эмх замбраатай болохыг олж мэднэ. Лууз самеди агуулаад дуу алдахдаа “Орчлон угаас амгалан” гэжээ (6, х 387).

Авдар дотор орж суулаа ч бодол байсаар л бол бясалгал биш, Бурханы мэдээ сургийг сонсох арга биш. Нэгэн энгийн сайн арга бол чин сэтгэлээсээ дотоодын Бурхандаа даатгах юм (6, х 394).

Нам жим суугаад тархиа 5 минут хоосон болготугай. Ингэж чадвал та нар миний багш болно (6, х 393).

Бясалгалын явцад өөрийн шүтдэг дээд хүчний нэрийг дурдаж, дотооддоо тэдний нэрийг санагалзаж, өдөр бүр тэднээс дэмжлэг гуйж, өөрийн хийж буй хэрэг явдал бүхнээ адислуулахаар даатгах хэрэгтэй (6, х 396).

Бодсон бүхнээ түүнд даатгаж, “хүн төрөлхтөнд нэн сайн болох болтугай, өөрийн бие болон гэр орныг минь улам сайн болгох болтугай, намайг нэн сайн билиг ухаантай болгох болтугай” гэж даатгах хэрэгтэй (6, х 396).

Би ном тайлахынхаа өмнө Бурханд даатгаж, төгс чадварт Бурхан минь надад нигүүсэн тусалж, миний 2 цагийн номноос хүн, чөтгөр, энд хуран цугласан бүх амьтад хамгийн их ач тусыг олохыг даатгадаг (6, х 380).

Залбирал, даатгалаар ач тусыг олохгүй бол өөр нэг арга бий. Энэ нь талархал. Бид бүх юмыг талархсан сэтгэлээр эдлэх хэрэгтэй. Талархах сэтгэлгүй бол өөрийн аугаа ихийг мэдэж чадахгүй, нэгэн аугаа хүчин аливаа бүхнийг анхааран болгоож байдгийг мартаход хүрч машинд өнчирч зовох болно (6, х 399).

Сүсэг барилдлага гэдэг нь Бурханд даатгах үед олсон хариу барилдлагыг хэлнэ (6, х 385).

Ертөнцийн хүмүүсийг нэг нэгээр нь гэтэлгэн дуусгах аргагүй. Иймд даатгалдаа бүх ертөнцийн энх тайвны төлөө даатгаж олноороо 3 ертөнцөөс ангижрахыг даатгах хэрэгтэй (6, х 316). Хүмүүс эд юмсыг даатгадаг учраас Бурхан болж чаддаггүй. Авгайнхаа өвчин зэрэг багахан явдлыг дотоодын багшдаа даатган туслуулвал болно. Төрөл төрөгсдөө дотоодын багшаараа харгалзуулах хэрэгтэй.

Дотооддоо “Багш аа, би бүх төрөл садан, найз нөхдөө танд тушаая. Та тааллаараа болгоно уу” гэж хэлж болох юм (6, х 318). Бид ертөнцийн гаслан зовлонг мартаж болохгүй. Сэтгэлдээ хамаг амьтныг бүгдийг нь багтаавал сая бясалгагч болно. Төрөл садан, гэрийгээ гэвэл ертөнцийн хүн болно. Адгуустай адил (6, х 318). Дотоодын багш биднийг харж ханддаг. Бидний хүсэл, шаардлагыг бүрэн мэдэж байдаг. Бид дотооддоо юу хэлж буй тэр бүгдийг мэдэж байдаг (6, х 320).

Дотоодын багшдаа даатгахдаа тухайлбал: Багш аа, миний хамаатан өвчтэй байгааг та мэдэж байгаа хэрэв түүнд тустай бол та туслах болов уу. Түүнд юу хамгаас тустайг та мэдтүгэй. Та хамгийн дээд билэг ухаантан болохоор явал зохистойг мэдэж байгаа. Би түүнийг танд даатгая гэж хэлэх хэрэгтэй (6, х 325). Албадан даатгаж болохгүй. Чин сэтгэлгүй даатгал даатгал биш. Бүх ертөнц энх амгалан болж, олноороо үхэж төрөхөөс ангижран, 3 ертөнцийг давахыг даатгахаас биш 1-2 хүнийг аврахын төлөө бурханд даатгаж болохгүй. Хэрэв багшдаа бүх ертөнцөд туслахыг даатгавал тэр бидний төрөл саданг мартчихна гэж үү.

Бид төрөл садангаа мартахгүй байхад дотоодод маань байгаа багш тэднийг яаж мартах билээ (6, х 336). Дотоодын багш биднийг ямагт харж хандаж, хамгаалж байдаг (6, х 304). Гагцхүү чин сүсгээр түүнд хандвал зохино (6, х 383).

Дотоодод маань хамгийн дээд Бурхан бий. Түүнд найдаж ямар ч тохиолдолд гарч ирэхийг нь хүсэн хүлээж, ямархан хүнд бэрхшээлийг ч түүнд найдаж, түүгээр туслуулвал лавтай бүтнэ (6, х 282). Энэ бол сүнс, дотоодын багш, өөрийн билэг ухаан мөн (6, х 383). Бид дотоодын бурхан чанартаа чин сэтгэлээр даатгахгүй, харин ямар нэгэн бурхан, сахиусын хөрөгт мөргөн, амандаа даатгах нь адад сонсгож байгаа явдал юм (6, х 139). Бид үйлдэгч биш. Юу ч хийсэн Оройн Дээд Их Бурханд даатгаад орхичих. Үр дүн нь ямар байна тийм л байг. Учир нь бид юутай ч энэ бие цогцос биш (2, х 39).

Хэрэв чин сүсгээр ямагт даатгаад байвал дотоодын Бурхан маань арга сүвэгчилж биднийг дагуулж нэгэн газар хүргэх юмуу нэг хүнтэй уулзуулах, эсвэл тохиолыг олгож бурхан чанарыг маань таниулж өгөх юм. Үүнд чин сэтгэл байвал болчихно. Бид өөрөө тэрхүү бурхан чанар мөн (6, х 218).

Минут секунд бүр Бурханд төвлөр, Бурханыг сана. Аливааг хийж байхдаа бурхнаас алсарсан үед уучилж хамгаалж хайрлахыг Бурханаас гуй (Ментон, 2013). Их Багш даатгалын тухай 6-р ботийн 318, 325, 394, 396 дахь талд дэлгэрэнгүй айлджээ.

## **ДАО**

*Үзэх: Төв үзэл*

Дао буюу гэгээрэлд хүрэхийн цагт та хэдийчинээ их гэгээрсэн байна, төдийчинээ амгалан, энэрэнгүй болно (2, х 26). Лууз: Ердийн санаа бол Дао гэсэн байдаг. Дао нь бас дундаж буюу туйлшрал үгүй зам мөр юм. Энэ дэлхийг үгүйсгэх нь буруу, гэхдээ зөвхөн дэлхийн явдалд гүнзгий живэх нь зөв биш (2, х 25). Бие махбодийнхоо хүсэл, мэдрэмжид хэт автаад сүнсээ мартаж өсгүй (2, х 27). Бурханы бидэнд зориулж бүтээсэн зүйлийг эдэлж хүртэх нь нүгэл биш, харин тэдгээрт зүйлст цаг үргэлж хэт шунаад байх нь зөв биш. Энэ дэлхийг үгүйсгэх нь буруу, гэхдээ зөвхөн дэлхийн явдалд гүнзгий живэх нь зөв биш. Бие махбодынхоо хүсэл, мэдрэмжид хэт автаад сүнсээ мартаж өсгүй. Биеэ хаяад бясалгана гэж байхгүй, биедээ л санаа тавиад сүнсэндээ цаг гаргахгүй байж болохгүй (2, х 25).

## **ДАЙН**

*Үзэх: Энх тайван*

Сунжирсан дайныг зогсоох ганц арга нь аллага хядлагын үйлийн үрийг зогсоох явдал юм. Дайсагнагч гэгдэх талын нэг нь нөгөөгийнхээ цусан өшөөг уучлахаар шийдэхэд дайн зогсох хэдий ч хожим хаа нэгтээ, өөр төрөлдөө, өөр газар дахин өшөө хорслоо авах гэж ирдэг. Мөн тухайн газарт буй болсон доод ертөнцийн гарц, зам, тамын зам, гарц дайныг сунжруулахад түлхэц болдог. Ийм нөхцөлд улсын тэргүүн дайныг дэмжих талтай болж, дайныг зогсоохыг хүсэвч ихэнхдээ үүнийг хийх хүчгүй байдаг. Маш өрөвдөлтэй (70).

## ***ДИЯАН***

*Үзэх: Самади, Аялгуу*

Дияан (Зэн) нь билиг нээгдэх гэсэн утгатай (6, х 125-126). Зэн буддизмд Гэнэтийн буюу Агшин зуурын гэгээрэл гэдэг нь дорхноо дотоодын Багш болох жинхэнэ мөн чанараа үзэж гэгээрэх гэсэн утгатай. Учир нь Багшийн нэг л үг биднийг зарим талаар, эсвэл бүр нэлээд ихээр, эсвэл бүрэн төгс чөлөөлдөг (2, х 93).

Дияан гэдэг нь билиг нээгдэх буюу Бурхан чанарыг зааж байна (6, х 125). Билиг нээгдвэл ядарвал унтаж, өлсвөл идэж, юу хэрэгтэй бол түүнээ хийж, тун их чөлөөтэй энгийн амьдрах юм (6, х 127-128). 6-р үеийн Их Багш Хүй нэн ямар ч хэрэг явдал хийлгүй, Бурханд мөргөсөнгүй, яршиг түвэгтэй бясалгал хийсэнгүй, харин түүний билиг дорхноо нээгдэж Бурхан болсон. Учир нь Үнэн ёс бидний дэргэд байдаг (6, х 139).

Сурч дадсаны хойно та ярьж байсан ч, явж байсан ч, унтаж байсан ч цөм бясалгал /дияан/ болно. Хүч чармайлтгүйгээр болчихно. Та тэр байтугай бодож байна уу, үгүй юу гэдгээ ч мэдэхгүй. Зүгээр сууж байхад л болчихно. Гэрэл ирнэ, аялгуу ирнэ, харин та өөрөө юуг ч анзаарахгүй. Үүнээс гаръя гэсэн цагтаа гарч бүх юмыг анзаарч эхэлнэ (2, х 149).

Номыг сэтгэлээр сэтгэлд уламжилна. Энэ сэтгэл бидний уг сэтгэл, үнэн сэтгэл юм. Дияан үг хэрэглэдэггүй гэдэг нь энэ (5, х 106).

## ***ДОТООДЫН БАГШ / ДОТООДЫН БУРХАН***

*Үзэх: Даатгал, Сургааль номлол, Эзэн Бурхан*

## ***ДЭЛХИЙН ДУЛААРАЛ***

*Үзэх: Веган хоол хүнс*

## ***ДЭЛХИЙ***

*Үзэх: Дэлхий*

Алтан эриний 9 дэх жил (2012 он) хүн төрөлхтний түүхэнд мартагдашгүй он байсан бөгөөд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай 2012 оны 3-р сарын 23-наас 4-р сарын 9-нд олон улсын дияан бясалгалыг Европт хийх үеэр Тэрээр дэлхийн насыг 50 жилээр сунгасан тухай гайхалтай мэдээлэл хийсэн билээ. Их Багш: “Дэлхийн төлөө бясалгаснаар цаашид насыг нь ойрын хугацаанд зуу, мянган жилээр сунгах боломжтой хэмээн айлдсан (75).

2012 оны 12-р сарын 22-д Их Багш Чин Хай бээр “Supreme Master” телевизийн ажиллагсадтай телеконференц хийхдээ дэлхийн нас 2012 оны 12-р сарын 18-ны байдлаар 8 сая 331 мянга 171 жилээр сунгагдан адислагдсаныг, цаашид Өөрийн гүн бясалгалаар улам адислахаа дэлхий дахинд мэдэгдсэн (75).

## ***ДЭЛХИЙН НАС***

*Үзэх: Дэлхий*

## **ДЭС**

Хэдий нэг хувийн ч хичээл зүтгэлээс чинь бүх зүйл шалтгаална /тайлбар: 99%-ийг нь Их Багш хариуцаж даана/.

Багшийн зааварчилгааг бүрэн дагаж, бие, хэл, сэтгэлээ Багшдаа бүрэн өргөвөл зохино.

Өөрийгээ хагас зориулчхаад хагас хугасханыг хүсвэл Багш хагас хугасханыг л хүртээнэ. Өөрийгээ бүрэн зориулж бүгдийг хүсвэл бүгдийг өгнө (2, х 41).

Багштай хамтарч ажилла. Хэдий нэг хувийн ч гэлээ хичээл зүтгэлээс тань бүх зүйл хамаарна (44).

Дэс өөрөөс чинь хамаарна. Хэт жижиг, өчүүхэн байх аваас танд ямар ч том зүйл, ямар ч диваажинг өгөөд хэрэглэж чадахгүй. Тиймээс Бурхад Будда нар өөртөө найд, өөрийнхээ чин зоригт түшиглэ гэдэг. Багштай хамтарч ажилла. Өөрсдийн энэ хавчиг явцуу зангаа, мөн бардам зангаа даван туулахгүй л бол хүрэх газраа хүрч чадахгүй. Энэ ганц өөрөөс чинь шалтгаална. Өөрийгээ хянаж, өөртөө ямагт сануулж, сэрж сэхээрэхгүй л бол туйлын хүнд, бас хамгийн амархан энэ замаар замнах боломжгүй. Энэ зам бол бие даасан хүний явах зам юм (30).

Дэс зэргийг ч хайхрахаа больж, бясалгал үргэлжилж, чин сэтгэл ундарсан хэвээр, та бүхий л талаар хөгжих авч юунд ч учир утга өгөхгүй, бүр гэгээнтэн больё ч гэж шунахгүй. Энэ бол хамгийн өндөр дэс (30).

Ухаарч сэхээрэх хүсэл тэмүүлэл үгүй бол 100 жил бясалгасан ч байдгаараа л байж байна. Багшийгаа санаад хүйтний улиралд ч ууланд гарч, ус гаталж үз л дээ. Өндөр зорилготой байсан надад ая тав тух юу ч биш байсан. Хичнээн хүнд бэрх зам туулсныг минь төсөөлөөд үз дээ. Би Бурханы гэрлийг эрсэн сэтгэлээсээ болоод өөр юуг ч олж үзэхгүйгээр сохорсон байсан.

Дадал зуршил, амьдралын хэв маяг, эрэлт хэрэгцээгээ хараад өөрсдийн дэсийг тодорхойлж болдог.

Юмсыг хэрхэн ойгож хүлээн авч байгаагаар дэс чинь тодорхойлогддог.

Агуу мөн чанар чинь аливаад хэрхэн зохирч байгаагаас чинь харагддаг. Жижигхэн цонхоор багахан зүйлийг олж харахаас бус бүх ертөнцийг харж чадахгүй. Үүнтэй ижил юмсыг харах ухаарал, хараагаа л тэлэхгүй бол агуу чанар чинь үүрд өчүүхнээрээ үлдэх болно.

Гагцхүү таны хүрэх төвшин нь Үнэнийг хайсан эрэлдээ та хир их итгэл, чин сэтгэлтэй хандаж буйгаас шалтгаалах болно. Хурдан удаан, зөв буруу явах нь таны л сонголт (1, х 32-33).

Өөрийн агуу сүр жавхлангаа ухаарч мэдэхийн тулд найдах ёстой хүн нь та өөрөө юм. Би зам мөрийг зааж өгнө (2, х 252). Хурдан эсвэл удаан өсч дэвших эрх өөрт тань байгаа (45).

## **ЁС СУРТАХУУН**

Ёс суртахуунлиг амьдрал нь Оройн Дээд Их Бурхантай нэг болох, Дао оршихуйд эргэж очих, Бурханы хутгийг олоход зайлшгүй хэрэгтэй, асар ач тустай (2, х 65).

Оюун санааны агуу хөгжлийг өндөр ёс суртахууны суурин дээр сүндэрлүүлдэг юм (65).

## **ЖИНХЭНЭ БАГШ**

Гэрэл болон Аялгуу бол жинхэнэ Багшийн хэмжүүр юм. Танд агшин зуур Гэрэл, Аялгуу үзүүлж чадахгүй байгаа хэн нэгэн бол Жинхэнэ Багш биш. Тэнгэрт хүрэх зам Гэрэл, Аялгуугаар тоноглогдсон байдаг. Тийм ч учраас та бүхэн Гэгээнтнүүдийн хөрөгт тэргүүн дээр нь өнгөт цагираг байхыг хардаг юм. Энэ бол Гэрэл юм. Гэхдээ аура бол Гэрэлтэй адилгүй. Аура янз бүрийн өнгөтэй байдаг. Заримдаа хар, заримдаа кофе, кофений өнгөтэй, заримдаа бол шар юм уу улаан байдаг. Тухайн үед тэр хүн ямар зантай байхаас хамаардаг. Хэрэв та оюунлаг сүнсний хүчтэй ауратай хүнийг харах юм бол ялгааг нь мэдэх болно (23). Жинхэнэ багш бүхэн нэг юм. Тэд бүгдээрээ нэг эх сурвалжаас ирсэн бөгөөд хамгийн дээд багш бол та бүгдийн дотоодод оршин байгаа хамгийг чадагч, төгс дээд багш юм (2, х 105).

### ***ЗАЛБИРАЛ***

Үзэх: Даатгал

### ***ЗОВЛОН***

Үзэх: Хүн

Гагцхүү бурханлагийг ойлгож ухаараг гэж л бидэнд хүмүүний амьдрал заясан юм. Бурханлагийг ойлгоогүй нь хүн төрөлхтний зовлон гамшгийн цорын ганц шалтгаан бөгөөд өөр шалтгаан байхгүй (2, х 16).

### ***ЗОЛИОС***

Үзэх: Огоорол

5 сахил бол ердөө л жирийн хүний стандарт. Гэгээнтэн болохын тулд та өөрийгээ, дуртай зүйлээ, илүүд үздэг зүйлээ, дургүйцлээ бүгдийг нь золиослох ёстой (46). Аливаа бүхнийг, аз жаргалыг ч огоорох хэрэгтэй (1, х 54). Юу ч гуйж хүсэмжлэхгүй байвал зохино. Амар амгалан, эрүүл мэнд, амжилт, нэр хүнд, эд хөрөнгө, гэр бүлийн алиныг ч горилж хүсэмжлэх хэрэггүй (1, х 256).

Өөрийгөө золиослох сэтгэлгүй бол өсч дэвшиж чадахгүй (1, х 256).

Хамаг юмаа хая, бүхнийг хая (1 х 44). Аливаа бүхнийг, аз жаргалыг ч огоорох хэрэгтэй. Тэгээд л болоод явчихна (1, х 54). Цорын ганц нууц бол бүхнийг огоорч орхих юм шүү дээ. Оройн Дээд Их Бурхан бүгдийг зохицуулна (1, х 45).

Зүгээр л Бурханыг сана. Тэгээд юу үйлдэж байгааг чинь Бурхан үйлдэж байгаа.

Одоо та, би, чи гэсэн ойлголт байхгүй болсон.

Бурхан хэнийг ч удирддаггүй. Харин Бурханыг санамагц та аливаа зүйлийг давхар давхар үйлдэж байдаг. Үүнийг мэдээж та биш Бурхан үйлдэж байдаг.

### ***ЗЭН***

Үзэх: Дияан

### ***ИНЭЭД***

Инээх агшинд Бурхантай хамт байдаг. Инээд бол ухаан оролцоогүй төвлөрөл. Инээд бол Бурханы нэг чанар, өөр юу ч биш. Инээмсэглэхэд бүхий л оршихуй маань тэр чигтээ инээж ухамсар тодорхой хэмжээнд аяндаа дээшилж байдаг. Иймээс сайн инээж байгаарай. Зовлон, жаргалын алинд нь ч инээцгээ. Хэрэгтэй бол уйл, гэхдээ уйлж байхдаа ч инээ. Нулимс

тань урсаж л байг, харин сэтгэлдээ инээ. Болж л өгвөл инээж байхыг хичээ. (1, х 132). Хүн аз жаргалтай байхдаа нирваанд байдаг. Хэнийг ч уучилж, хайрлаж, юугаа ч хүмүүст өгч чаддаг. Оюунлагийг дадуулна гэдэг нь хамаг баяр цэнгэлээс татгалзана гэсэн үг биш, энэ бол буруу үзэл. Оройн Дээд Их Бурхан энэ бүх зүйлийг бидний ойг гутаах гэж бүтээдэггүй. Хэрэв ийнхүү туйлширч, хэт чухал загнаж байгаа бол оюун санааны дадал бясалгалын учрыг буруу ойлгож байна гэсэн үг (1, х 64).

## **ИТГЭЛ**

*Үзэх: Үнэнч сэтгэл*

## **ИХ БАГШ**

*Үзэх: Багш, Жинхэнэ багш, Хайр*

Миний та нарт зааж сургаж байгаа бүхэн бол материаллаг зүйлийн занганаас мултрах, бие болон сэтгэлийг хясагч тэрхүү хүчнээс дээш гарах, өөрийгээ уураг тархи хэмээх компьютер болон энэ бие цогцсоос илүү агуу зүйл гэдгээ ойлгож ухаарахыг эрмэлзэгч бясалгагчдын эрин дамжсан билиг ухааны охь шим юм” (1, х 137).

Төгс бүрэн хайрыг Багш биедээ тээж байдаг. Хайр юм бүхнийг угаан ариусгаж, муу бүхнийг эвдэн нурааж, хил хязгаар бүхнийг уусган сарниулдаг.

Хүссэнийхээ хирээр хэрэглэж болох агуу их дотоод хүчийг хайр гэдэг. Гайхамшиг ингэж бүтдэг юм. Учир нь Хайрын хууль нь бусад бүх хууль, түүний дотор Үйлийн үрийн хуулийг ч даван туулж чаддаг. Тийм болохоор Багш хүн өөрт нь итгэдэг хүн бүрийг чөлөөлж, Бурхадын орныг бүхэлд нь нээж, тамын орныг эвдэж чаддаг (2, х 32-33).

Энэ аугаа дотоод хүчийг яагаад хайр гэдэг гэвэл хайр хамаг л нүгэл хилэнцийг маань уучлан өршөөж, угаан ариугадаг юм. Хайранд нүгэл хилэнц, зааг хязгаар, өнгөрч улирсан гэж огт үгүй, зөвхөн одоо л гэж бий (2, х 32).

Багш бол их хүчтэй холбогдсон Оршихуй юм (47).

Бясалгалаар бус Их Багшийн хүчээр гэгээрдэг (1, х 61).

Би бол Будда чанарыг шууд харуулах чиглэлийн багш (48).

Их Багш энэ дэлхийд залрахуйд билиг увдисыг нь зөвхөн шавь нар нь хүртэж гэгээрээд зогсохгүй хамаг хүн төрөлтөн ариусч, ухамсар нь тодорхой төвшинд өөдлөн дэвшдэг (2, х 118). Би энэ насанд чинь чөлөөлнө гэж амласан (49).

Би та нарт гэгээнтэн байхыг тань, Диваажин дахь суудлыг тань, илүү билиг ухаан, хайрыг олохыг тань батлан даана (50).

Та нар энэ дэлхийд буцаж ирж зовохгүй, тамд унахгүй, амьтны төрөл ч авахгүй, гарцаагүй дээшээ явна гэдгийг би амлаж байна.

Багш бээр авшигтан шавийг 24 цаг унталгүй харж хандах тул санаа зовох явдалгүй (51).

Авшиг авсаны дараагаар хувилгаан биет Багш 24 цагаар дэргэд чинь оршино (боть 6, х 340).

Үхэхдээ та Багштайгаа уулзах нь лавтай. Тэр цагт Багш таныг авахаар ирэх нь гарцаагүй (1, х 58).

Танд хүндрэл бэрхшээл тохиолдох, осолд орох юмуу хэнд ч хандах боломжгүй үед ид шид гайхамшиг тохиохыг та биеэр үзэж мэднэ. Тэр үед та Оройн Дээд Их Бурханы хүч чадлыг ухаарч мэднэ. Тэр үед л Бурхан таныг хайрлаж хамгаалж байдгийг мэдэх болно. Бид Түүнийг олж харахгүй юм бол, хэрэгцээтэй үед тусламж, хамгааллыг нь олж үзэхгүй юм бол Бурханы хэрэг юу байна (2, х 125).



Бид урагш ганц алхам хийхэд Багшийн хүч бидэнд туслах гэж зуун алхам хийнэ (1, х 292).

Тиймээс жаахан чин сэтгэлээр өчүүхэн чармайлт гаргах л юм бол Их Багш бүхнийг авралдаа багтааж бусад юмыг тооцохгүй. Бясалгалын төлөө шавь нар юу л хийх боломжтой байна, эсвэл бясалгалаас ямар л үр дүн гарна, бүгд үнэндээ бол миний энэ бие хүнийх ч биш, харин Их Багшийн хүчний аврал юм (2, х 301).

Багшийн тухай бодлоороо та Багштай нэг болно. Энэ бодлоор дамжин Багшийн хамаг цог чанар шавьд аажим аажмаар, алхам алхмаар шилжинэ. Тэгээд Багшаар дамжин өөрийн мөн чанараа олно (2, х 112).

Шавь бие махбодоо орхихын өмнө, эсвэл Багш тань биеэ орхихоос өмнө та хаана байсан тэр төвшнөөс эхлэн таныг дээш авч явах нь Багшийн үүрэг юм. Багш таныг аль хүрэх төвшинд тань хүргэж дэмжих бөгөөд дээш дээш нь үргэлжлүүлэн замчилсаар байх болно (1, х 309).

Багш энэ ертөнцийг орхисны дараа шавь нь өөр багшийг хайх хэрэггүй. Ингэх хэрэг байхгүй. Хэрэв амьдралын талаар ч юмуу материаллаг зүйлийн талаар ямар нэг тодруулах юм гарвал амьд байгаа өөр Багш, эсвэл Залгамжлагчид хандаж болно.

Түүнээс биш өнгөрсөн Багшийн оюун санааны жолоодлого дотоодод тань байсаар байна. Тэр шавь нараа хариуцсан хэвээр, үүнийгээ үргэлжлүүлэх хүчтэй хэвээрээ байдаг. Учир нь холбоо барилдлага хэдийн тогтоочихсон болохоор тэр.

Хэрвээ та мянган жилийн өмнө Багштай барилдлага тогтоосон бол хичнээн цаг хугацаа өнгөрсөн ч хамаагүй Тэр танд санаа тавьсаар байх болно (2, х 112-113).

Намайг явчихаар та нарт хэн ч байхгүй болчихно гэж айх хэрэггүй. Та нарт цаг үргэлж хэн нэгэн хүн байх л болно. Чин сэтгэлтэй, боломжийн өндөр төвшинд хүрсэн бол намайг одоо харж байгаа шигээ гэрт тань хувилгаан биеэр ирэхийг ч харна. Багш өөр дээр чинь ирэхийг харна. Шаардлагатай цагтаа Багшийг хэзээ ч олж үзнэ. Энэ бие махбодид минь татагдан зууралдах хэрэггүй. Миний бие бол та нарт намайг харах боломж олгохын тулд байгаа гадаад бүрхүүл, гэр орон, ажлын байр төдий юм (2, х 116).

Багш бол энэ бие биш оюун ухаан. Энэ дэлхийгээс явсан ч тантай ямагт хамт байна. Өсөж дэвшихэд тань байнга тусална. Та ертөнцийн их хүчтэй холбогдсон. Бид бол оюун ухаан. Багш бол энэ нэрэндээ тохирч хаа сайгүй оршино. Танд муу юм тохиолдлоо гэхэд Багш андахгүй мэднэ. Багш байсан ч, байгаагүй ч та дотоодын самади хүчнээсээ хамааралтай болно (51).

Манай бясалгагчдыг ертөнцөөс ангижрахын өмнө Багш чинь ирж мэдэгдэнэ. Амь тавих үед Багш чинь ирж угтан авна. Бурхан бодисад ч бас хамт ирнэ. Багш нь эгшиг хөгжимтэй, лянхуа цэцэгтэй ирнэ (3, х 204).

Манай бясалгагчид асурын ертөнцөд очсон ч яваандаа дээд зэргийн газарт хүрнэ. Тэнд бас өдөр бүр сургуульд явж, Багш нь дахин зааж сургах болно (3, х 205).

Бясалгадаггүй гадны хүн багшийн нэрийг хэлж санавал, Багшийн чинь цог чанар тэр талд уламжлагдан очиж, түүний үйл түйтгэртэй солио хийх юм /6, х 15/

## **МАХАН ХООЛ**

*Үзэх: Веган*

Мах идэх нь хүн төрөлхтний эсрэг, зэрэгцэн орших оршнолуудын эсрэг гэмт хэрэгт тооцогдоно (71).

## **МОНГОЛ / МОНГОЛЧУУД**

Дэлхийд 1326 сүнслиг адислалт шулуун (САШ) бий. САШ нь дэлхийг тогтоон барьж байдаг ба хүн төрөлхтний ач буянаас хамааралтай. Монголд 10 САШ байснаа 8 болсон. САШ нь дэлхийн төрхийг өөрчилдөг. Эх дэлхийдээ билиг ухаанаар хандахгүй бол тэдгээр шулуунууд устаж алга болдог. Сүнслиг адислалт гарц (САГ) дэлхийд ойролцоогоор 1570 бий. САГ доод тал нь 2, дээд тал нэг дор цугтаа 5 байдаг. САГ-ууд САШ-аас хүчтэй. САГ Атлантын далайд 100, Номхон далайд 100, Газрын дундад тэнгист 200, Антрактидэд 100, Арктик /Хойд туйл/-д 150, Гимлайд 12, Энэтхэгийн далайд 200, Хойд тэнгист 120, Хар тэнгист 20, дэлхий дотор 110, дэлхийн хөндийд 110 байдаг (*Монголд САГ байдаг тухай хэлээгүй*). САГ нь дэлхий болон дэлхий дээрх оршихуйнуудыг адислах гэж байдаг. Тэднийг зөвхөн Диваажингийн ивээл тэтгэдэг. САГ нь САШ шиг хүний ач буян, билиг ухаанаас хамаардаггүй. Төгс, эв зетэй дэлхийг бүтээхийн тулд там ба доод ертөнцийн гарцуудыг хааж устгахын тулд илүү олон САШ, САГ хэрэгтэй (18).

Монгол улсын төрийн ордны хавьд тамын гарцтай учир ордныг зүүн зүгт 40 км нүүлгэх хэрэгтэй. Ингэвэл улс тань хүчирхэгжихийг, хөгжихийг харах болно (43).

Ордондоо юмуу ордны ойролцоо тамын гарцтай улс орнууд ордноо нүүлгэвэл муу бүхнээс зайлж чадна. Диваажин ч баярлах болно. Өөртөө 1 % юмуу 10 % муу чанартай хүмүүс ийм газар ажиллавал 100%, 150 %, бүр 200 % болж муу чанар нь ихэснэ. Ийм байрыг засаж сайжруулах ара үгүй, зөвхөн нүүх. Ийм газар нь байнга муу хүчний нөлөөнд байгаад байх тул сайн сайхан гэж үгүй. Ямар сайн хүн байсан ч дотооддоо муу хүчтэй тэмцэлдэх болно. Заавал муу нөлөөнд автана. Хажуугийнхаа хүмүүсийн муу нөлөөнд ч автана. Муу хүчинд заавал уруу татагдаж эцэст нь тэд дийлдэг. Хүмүүс өдөр бүр мал, амьтны аллага хийж байна. Хамгийн хүнд ийм үйлийн үр улс оронд хуримтлагдсаар байна. Нүүх нь энх амгаланг тогтоох сайн арга. Нүүхгүй бол улс орноо ч, бүх дэлхийг ч сүйрэлд хүргэнэ. Муу хүч удирдагчийнх нь сүнсийг золигт гаргаж өөртөө зүтгүүлдэг. Ихэнх орны ойр хавьд диваажингийн гарц, зам, холбоос байхгүй байна. Тухайн орны дийлэнх хүн юу хийж байна, тэр хамтын үйлийн үр л улсаа тодорхойлно. Бүрэн өөрчлөхийн тулд хүн амын 2/3 нь оролцох ёстой. Тамын гарцууд нь зөвхөн үйлийн үрийн шалтгаанаар л байгаа юм. Хэрэв хүн бүр оюунлиг сайн болвол тэдгээр гарцууд аяндаа үгүй болох юмуу эсвэл хаагдаж, өөр тийш нүүх болно (18).

Улс орон нь бүхэлдээ хүнд үйлийн үрд живсэн байхад төр, засаг нь олигтой юу ч хийж чадахгүй. Бүү шүүмжил. Үйл үр өөрчлөгдөхийг хүлээ */дэлхийн нийт улс орнуудыг ийн айлдав/*. Бүхнийг хайраар хийвэл болчихно (8).

Хүний ба диваажингийн хуулийг зөрчигсдөд зориулагдсан тамын үүд дэлхийд 20 бий. Монголын говьд 4 бий. Эдгээр нь анхнаасаа л ингэж бүтээгдсэн. Хүмүүс диваажингийн ёсоор амьдрах хүртэл энэ газрууд байх болно. Тэднийг засах, сайжруулах гэж үгүй. Засвал нь муу хүмүүсийн хүртэх ёстойг үл ойшоосон болно. Вермудийн төрлийн газрууд шинээр бүтээгдэхгүй. Физик биеүд бус сүнс зовох газар. Сүнс яг л физик бие шиг зовно. Эдгээр нь доод астрал ертөнц ч биш, физик ертөнц ч биш. Айдас, зовлон, өвчин гм бусдад учруулсан зовлонгоо өөрөө амсах газар. Ийм газрын ойр байхад таагүй байж болох ч сүнслиг буян хорогдохгүй.

Дэлхийд диваажингийн 916 гарц бий. 1 гарц нь 1,5 м<sup>2</sup> талбайтай. Аль ч гарц нь 8000 %-ийн сүнслиг адислалтай (*Монголд диваажингийн гарц байгаа тухай хэлээгүй*). Доод төвшний гарцууд нь 2-р ертөнц рүү, дээд гарцууд нь 5-р ертөнц рүү хөтөлнө, хүргэнэ. Энэ нь Гуань Инь бясалгалынханд хамааралгүй, учир нь тэднийг Багш нь авч явна (18).

Монголын говьд тамын гарц үүд бийг хэлсэн билүү? Монголын говь жил бүр тэлсээр л байна. Цөл танай орныг эзэлж байна. Үүнийг монголчуудаас бусад нь л мэдэж байна. Ийм зүйл их аюултай. Бясалгалын хүчээ зузаатгах хэрэгтэй. Мал үржүүлэхгүй байж хүмүүсээ авар. Мал

өссөөр буй нь тун таагүй. Миний хэлснийг тэдэнд хэлээрэй (*Дэлхийн насыг 67 жилээр сунгасан бичлэг*).

Мах идэхээ багасга. Ингэвэл би танайд зочилно. Бэлчээрийн мал аж ахуй нь бусдыгаа бодвол дээр л дээ. Гэвч хэмжээ байх ёстой. Говийн тамын үүд, гарцыг зогсоох нь та нарын үүрэг. Үүнийг тэнгэрээс зарлигласан. Эргэн тойронд тань уруу таталт, занга байхад, өөрийгээ ба гэр бүлээ ч гэжээж чадахгүй байхад ямар ирээдүй байх юм бэ. Энэ ертөнцөд хүн нүгэл тарихаасаа ч өмнө ирээдүйгээ алдсан байдаг. Байдал чинь дордоод л байна уу гэхээс сайжрах нь үгүй. Эргэн тойрон занга байхад яах ч билээ. Маяагийн тогтолцоо ийм юм. Мах идвэл өвдөнө, зовно, хоосорно, ядуурна гэж хэлж өгдөг хүн, байгууллага байдаг билүү? Зүдэхдээ хулгай хийж, сүүлдээ гэмт хэрэгтэн болох жишээтэй. Там руу нэг л алхсан бол цааш яваад л байна. Бүх донтуулагч зүйлийг дэлхийгээрээ хэрэглэж байна. Донтсон нэгэнд би юу зааж, юу сургаж чадах билээ дээ. Энэ дэлхийн гасланд төгсгөл гэж үгүй. Дэлхийн нас уртсах нь сэрүүсч хөрсөн гэсэн үг биш. Хүмүүс бид буруу үйлдсээр л байвал дэлхийг сөнөөх хүч хэвээр байсаар л байна.

Бурхан минь, очиж үзээгүй газар ямар их байна вэ. Монгол, Африк гээд л.

Би монголчуудад тун их хайртай. Би тэднийг тун цэвэр гэж боддог. Та нарыг Европт байсансан бол өдөр бүр очиж уулзах байлаа (67).

### **МӨН ЧАНАР**

*Үзэх: Бурхан чанар*

### **МӨР**

Биднийг хайрладаг тэр хүчнийг Мөр, Хан Хурмаст, Бурхан чанар, Эзэн Бурхан, Аллах ч гэдэг (5, х 381).

### **НИНЖИН СЭТГЭЛ**

Хамгийн дээд билиг ухаан бол нинжин сэтгэл юм (42).

*Хүн, зарим амьтан, шувууны нинжин чанар  
(Их Багш Чин Хай, 2013)*

Хүн, амьтан	Гэгээлиг чанар	Нинжин чанар	Сайн чанар	Муу чанар
<b>Хүн</b>				
Хүн (дундаж)	0-20	0-20	3-40	10-30
<b>Амьтан</b>				
Тагтаа	47	47	26	0
Үнээ	40	50	38	0
Гахай	42	50	33	0
Молтогчин туулай	40	46	25	0
Заан	38	47	39	0
Галуу	32	47	27	0

Адуу	30	35	28	0
Нохой	12	6	28	0
Яст мэлхий	12	20	37	0,001
Чоно	10	18	32	0,03
Цахлай	6	6	18	1
Нугас	3	5	12	0
Тахиа	3	2	11	0,005
Имж	2	1	16	0,01
Халим (махчин бус)	2	40	30	0
Тогъны төрөл	2	2	19	0,06
Зөгий	0	0	2	0,001
Мэлхий	0	0	9	0,05
Бар	0	2	1,5	6
Аварга загас	0	1	1,2	8
Арслан	0	0	2	0,07

### ***НИРВААН***

*Үзэх: Хоосон чанар*

### ***НЭГ ҮЗҮҮРТ СЭТГЭЛ***

*Үзэх: Үнэнч сэтгэл*

### ***ОГООРОЛ***

*Үзэх: Золиос*

Өөрийн гэх санаа, би хэмээх ойлголт, хувь хүний хувьд хэдийн төлөвшсөн үзэл бодлоос чөлөөлөгдсөн бол та бүхнийг огоорогчийн төлөвт хүрчээ гэсэн үг (1, х 26). Цорын ганц нууц бол бүхнийг огоорч орхих юм шүү дээ (1, х 45). Юу ч үгүй байна гэдэг нь юм бүхэнтэй байна гэсэн үг (1, х 78). Хамаг юмаа хая. Бүхнийг хая (1, х 44). Аливаа бүхнийг, аз жаргалыг ч огоорох хэрэгтэй. Тэгээд л болоод явчихна (1, х 54). Ганц л хүн дээр төвлөр. Бурханы оронд байгаа Ханьдаа үнэнч бай (1, х 49).

Бүхнийг огоорох гэдэг нь бүхнийг хүлээн зөвшөөрөх явдал юм.

### ***ОРШИХУЙ***

*Үзэх: Ухамсар, Ухамсрын төвшин, Туулан тонилох*

Оршихуйн олон төвшин байдаг бөгөөд эхнийх нь материаллаг, биет төвшин. Хүмүүсийн ихэнх нь идэх, унтах, бие махбодын бүх төрлийн таашаалд дурлах зэрэг мэдрэхүйн цэнгэл жаргал хөөцөлдөхийг гол зорилгоо болгож, залхуурал назгайралд автах хандлагатай энэ төвшинд амьдралаа өнгөрүүлдэг. Тэд амьдралынхаа хэрэгцээг хангахын тулд л тэд ажил хийдэг бөгөөд эрхэм эрмэлзэл, сэтгэл зүрхээ ажилдаа зориулдаггүй. Амьдралаа боломжтой байлгахын тухайд л биш бол тэд ер нь ажил хийх дургүй, бүх хүн төрөлтний төлөө ажиллах гэдэг тэдний хувьд хэцүү хэрэг байдаг.

Хоёр дахь нь сэтгэл хөдлөлийн гэж нэрлэгддэг төвшин. Энэ түвшиний хүмүүсийн үзэл бодлын байр суурь их хүчтэй, эзэрхэг эсвэл дарангуйлагч зантай гэж хэлж болно. Үргэлж л тэдний зөв байх бөгөөд тэд аливаа зүйлийг бусад хүмүүс тэдний жишээгээр хийхийг хүсч байдаг. Олон ч дарангуйлагч хэт даврагч хөдөлгөөний их удирдагч гэгдэгсэд энэ түвшинд хамаарна. Сайн санаатай хэдий ч алдаа хийчихээд түүнийгээ хүлээн зөвшөөрдөггүй, тухайн байдлаа засхыг хичээдэггүй хүмүүс ч энэ түвшинд багтана. Уян хатан чанар дутвал ийм аюултай байдаг юм.

Гурав дахь төвшинд бол бүгдийг бичиж авч чаддаг ч түүнийгээ тунгаан бодолгүйгээр сэлгэн гүйлгэж байдаг компьютер төдий махбод болох тархи (ингэж хэлэхэд харамсалтай байна), оюун ухаан дотор бид амьдардаг. Гэтэл уг нь сүнсний билгүүн ухаанаас ангид тархи бол ердөө автомат машин юм шүү дээ. Энэ түвшиний хүмүүс ерөнхийдөө өөрөө өөртөө явцуурч, ямарч хамаагүй нэг үзэл санаанд бүрэн автсан байна. Тэд энэ дэлхийд болж байгаа зүйлийн тухайд санаа зовдоггүй, түүнийг сайжруулах юм уу өөрсдийгөө өөрчлөх үнэн хүсэл төрдөггүй, нэг талаар гагцхисан улс. Тэд өөрсдийгөө тэр байгаа хэвээрээ л төгс төгөлдөр гэж тооцогддог бөгөөд олон хүн үүнийгээ гэгээрэл хэмээн эндүүрэх нь бий.

Дөрөвдүгээр төвшин болох оюун санааны буюу өөрийгээ төгөлдөржүүлэх төвшинд бид өөрсдийгээ сүнстэйгээ адилтгаж үздэг. Бид бол аз жаргал, урам зоригийн маань эх булаг болсон сүнстэйгээ угтаа адил, нэгдмэл цогц юм, бид энэ бие махбод биш гэдгээ ойлгоно. Гэхдээ энэ нь хамгийн дээд төвшин биш, учир нь 'би' гэх үзэл байсаар байдаг.

Үүний дараа Оройн Дээд Их Бурханы төвшин, бурханлиг ухамсар хийгээд ухаарлын тав дахь төвшин байдаг. Оройн Дээд Их Бурхан гэдэг бид болохоос бус өөр хэн ч биш, бид Түүнтэй нэг юм. Өмнөх төвшинд Оройн Дээд Их Бурхан биднээс тусгаар оршдог гэж бодож байсан. Тайлбарлахад хэдий амаргүй ч энэ төвшинд бид анх удаа юу ч бодолгүй, тэр байтугай хийж байна гэдгээ ч мэдэлгүй юмыг хийдэг. Үйлийн үр хураалгүй бүхнийг бүтээгч болдог” (2, х 16).

## **ӨГЛӨГ**

*Үзэх: Хуваалцах*

Өглөг өгч байгаа хүн өгөх хүсэлтэй, сэтгэл нь цэвэр, санаа зорилго нь ариун байх хэрэгтэй. Өглөгийг хүлээн авч буй нь ч мөн цэвэр ариун санаа сэтгэлтэй байх ёстой. Ийм нөхцөлд тэр хоёр хоёулаа адислалын хүчийг хүлээн авна.

## **САЙН БА МУУ**

*Үзэх: Будда*

## **САМАДИ**

*Үзэх: Даатгал*

Юу ч хийж байсан түүндээ бүрэн дүүрэн орших нь нэг үзүүрт самади. Зургаадугар төрлийн дээд мандалт сударт: “Гаднах дүрсээс салвал (*хуран мэдэл эс үүсэх аваас*) дияан хэмээмүй. Дотоод бодол самуурахгүй бол самади хэмээмүй” (6, х 60).

Самади нь өнгөц, гүн 2 янз бий. Гэрэл харж, аялгуу сонсож байгаа нь мөн самади. Энэ нь өнгөц самади. Заримдаа зөвхөн дотоодоо мэдэрч, эргэн тойронд юу ч мэдрэхгүй (52).

Самадид ормогц бүх дэлхий алга болно. Бид зөвхөн гэрэл, эрх чөлөө л болж хувирна. Бие махбодь ч, хөрш чинь ч, бүр орчлон хорвоо ч оршихоо болино. Бурхан гэдгээ, эрх чөлөө гэдгээ мэдэх үнэхээр гайхалтай (53). Самади агуулаад удвал явах суух, унтах хэвтэх нь бүгд дияан болно (6, х 28). Самадийн утга санаа нь дотоодын маш гүн баяр баясал, номын баяслаар бялхахыг хэлнэ. Жинхэнэ самади танд билиг ухаан болон төгс баясгаланг өгөх болно. Самади агуулах үеийн энэхүү билиг ухаан болон төгс баясгалангаа ертөнцтэй хуваалцах буюу таныг гэсэн хэн нэгэн болон ойр дотныхондоо өгч хуваалцах хэрэгтэй. Зарим багш гүн самадид оршоод, гарч ирж ертөнцийг сэхээрүүлдэггүй. Маш гүн, маш дээд дэсийн самади агуулах үед заримдаа бие цогцоо мэдрэхгүй болж, энэ ертөнц дээр хэрхэн ажиллахаа мэдэхгүй болдог. Хүн зодвол нь өвдөхөө мэдрэхгүй. Хүн зэмлэвэл нь түүнийг тэвэрч үнсэх жишээтэй. Учир нь энэ ерөөнцийн сайн муу, сайхан муухайг ялгаварлах сэтгэл үгүй болсон байдаг. Цаашилбал хэдэн өдөр, сар юм идэхгүй байж чадна. Бусдад туслах юм үгүй, хүн бүрийг өөртэйгээ адил баяр баясгалантай, сэтгэл ханамжтай байгаа гэж боддог. Та өөрөө номын баяслаар бялхаж байх тул бүх ертөнцийг бас төгс баясгалантай байна гэж бодох болно. Бид ийм төгс баясгалант хүслэнт ахуйд байх боловч зовлон амсаж буй хүмүүс бас бий.

Энэ самади сайн хэдий ч өөр нэг зүйл самадид хүрэхгүй юм. Үнэндээ самади олон ч энд 2 төрлийн нийтлэг самадийн тухай ярьж байна. Төгс гэгээрсэн багш болох буюу энэ дээд ойртоход эдгээрийг мэдэж авах хэрэгтэй. Бурхан Багш ном тавихаасаа өмнө бодь модны дор бясалгаад эхний самадийн ойлголттой болжээ. 49 хоног хуруун чинээ ч хөдөлсөнгүй, юу ч идсэнгүй, уусангүй. Исус цөлд 40 хоног хөдөлсөнгүй, юу ч идэж уусангүй. Мухаммед ертөнцийг гэгээрүүлэхээсээ өмнө бас ийм самади агуулжээ. Гэвч ийм самадигаас эрхбиш салах хэрэгтэй. Үүнээс хойш тэд өдөр бүр бясалгах болсон нь өөр нэг зүйлийн нэлээд энгийн самади болно.

Та 24 цаг самадид байна, гэвч бас 24 цаг самадид байхгүй байна. Та төгс баясгалан дотор байхын хамт бас энэ ертөнцөд байх юм. Ингэхгүй бол энэ ертөнцөд туслах аргагүй. Энэ бол нэлээд дээд дэсийн самади юм. Ийм хүслэнт ахуйд хүрэх нэлээд бэрх. Эхний самадийг олох их бэрх байхад удаахийг олохын бэрхийг хэлээд яах вэ. Төгс гэгээрсэн багш болж хамаг амьтныг гэтэлгэхийн тулд самадийн хүслэнт ахуйг тархитайгаа хамжих хэрэгтэй болно.

Самади танд дотоод хүч өгнө. Иймд та барилдлагат хүнээ адислаж чадна. Самади үгүй бол хэнийг ч адислаж чадахгүй. Тэднийг аварч, тусалж чадахгүй. Та хаа ч оршиж чадахгүй, өөрөөр хэлвэл нэг цагт олон газар илэрч чадахгүй. Эрүүл саруул ухаан (тархи)-гүй зовлонтой амьтантай нэвтрэлцэж чадахгүй, тэднийг ойлгох аргагүй. Тиймээс энэ 2 зүйл хүч (самади, тархи) бүрэн байх хэрэгтэй. Гэвч үүнийг олох нэн бэрх тул эртнээс нааш төгс гэгээрсэн олон байдаггүй. Тоост хорвоод байх боловч басхүү ертөнцөд байгаагүй, самадид байх боловч басхүү самадид байгаагүй. Иймээс төгс гэгээрсэн багшийг олох гэдэг нэн бэрх. Учир нь тэд самади агуулснаа бусдад мэдэгдчихдэг нэг дэх зүйл багш биш. Эдгээр төгс гэгээрсэн багш бол богд, ариун сүнс. Тэд дотооддоо нам жим байхын хамт гаднах ажлаа шийдвэрлэж байдаг (6, х 367-373).

## **САХИЛ**

*Үзэх: Авишиг авах болзол, Веган хоол хүнс, Шид*

Таван Сахил:

1\* Амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ;

2\*\* Үнэн бус зүйл хэлэхийг цээрлэнэ;  
3\*\*\* Өөрийн бус юмыг авахыг цээрлэнэ;  
4\*\*\*\* Садар самуун явдлыг цээрлэнэ;  
5\*\*\*\*\* Хорт бодис хэрэглэхийг цээрлэнэ;  
Эдгээр сахилыг сахихад бүрэн веган ногоо/ хоолтон байх ёстой.

1\* Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн,загас, тахиа, өндөг (үр тогтсон болон үр тогтооргүй өндөг, өндөгтэй боов, бялуу жигнэмэг, зайрмаг гэх мэт) мөн амьтны гаралтай бүх төрлийн хүнсийг хэрэглэж болохгүй.

Гуань Инь Бясалгалын (Quan Yin Metod) авшиг хүртэхийн тулд насан турш бүрэн веган хоолтон байх шаардлагатай. Ургамлын гаралтай зүйлийг хүнсэнд хэрэглэхийг зөвшөөрөх боловч өндөг болон амьтны гаралтай ямарваа хоол хүнсийг идэж болохгүй. Үүнд олон шалтгаан байдаг ч хамгийн чухал нь амьтны амь хороож болохгүй гэсэн Нэгдүгээр Сахил буюу Амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ, амь хөнөөхийг хориглоно гэдгээс үүдэлтэй юм.

Амь хороохгүй байх буюу өөрөөр хэлбэл бусад амьд биест хор хүргэхгүй байх нь Үйл үрийн хуулиас болоод тэр. Юу тарина, түүнийгээ л хурааж авна. Мах идэх гэсэн шунал хүслээ хангахын тулд та амьтны амь хөнөөх эсвэл бусад хүнээр амьтны амь хороолгох үед та үйл үрийн өрөнд унаж, эрт орой нэгэн цагт тэр өрөө заавал төлөх ёстой болдог юм. Тэгэхээр веган хоолтон байх нь бүр жинхэнэ утгаараа бидний өөрөө өөртөө барьж буй бэлэг юм. Веган хоол идсэнээр бидний үйл түйтгэр, өр ширийн хүнд ачаа дарамт багасан хөнгөрч, тэр хэмжээгээр өөрсдийгөө улам сайн сайхнаар мэдэрч, амьдрал ахуй маань дэвжин сайжирч, өмнө маань цоо шинэ, тансаг нандин, дотоодын тэнгэрлиг ертөнцөд нэвтрэн орох үүд нээгдэх болно. Энэ бүхэн таны багахан зүйл хийснийхээ төлөө олж авч буй ихээхэн завшаан юм. Энэ нь мөн нь хүний эрүүл мэнд, экологи ба байгаль орчин, ёс суртахуун ба амьтдын зовлон, дэлхий дээрх хоол хүнсний хомсдол, өлсгөлөн зэрэг асуудалтай хамаатай юм (23).

Өндөг идэж болохгүй. Учир нь өндөг үр тогтоогүй ч гэсэн хагас амь хороосон идээнд ордог. Үүнээс гадна түүний нэг чанар нь сөрөг энергийг татах хандлагатай байдаг. Та бүхний мэдэж байгаагаар чухам ийм учраас хар, цагаан дом хийдэг хүмүүс эсвэл вүүдүү /илбэч, увдисч/ гэж нэрлэгддэг хүмүүс ад дон шүглэж, ганирч галзуурсан хүнээс адыг нь соруулж авахад өндөг хэрэглэдэг (23).

2\*\* Энэ сахил нь худал хэлэхийг цээрлэх юм.

3\*\*\* Энэ сахил нь хулгай хийхийг цээрлэх юм.Өөрийн бус юмыг авах нь хулгай мөн. 4\*\*\*\* Энэ сахил нь садар самуун явдлыг цээрлэх юм. Садар самуун - бэлгийн харилцааны дур зоргоороо байдал гэдэг нь хэрэв танд нөхөр байгаа бол хоёр дахь нөхрийн тухай битгий бодоорой гэсэн үг. Амьдралаа бэрхшээл зовлонгүй эгэл жирийн болго. Хэрүүл маргаан, сэтгэлийн түгшүүр үүсгэх шалтаг бүү эр. Бид бусдад хор хөнөөл тарих учиргүй, сэтгэл санаанд нь ч хүртэл хор хөнөөл учруулах ёсгүй. Үүнийг хэлж байгаа юм (23).

5\*\*\*\*\* Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал архи, тамхи, хар тамхи, мөн мөрийтэй тоглох, садар самуун, хүчирхийлэл зэргийг сурталчисан зураг, кино, уран зохиол, компьютерийн тоглоом гм гэх мэт зүйл орно.

Нэг үгээр хэлвэл, хүн ба амьтанд гай учруулах, амь хороох, хулгай хийх, садарлан самуурах, мансууруулах бодистой зүйл хэрэглэх, бүх төрлийн мөрийтэй тоглоом, дэнчин тавих гэх мэт оюун санааг маань бие махбодын цэнгэлд татаж, оюунлагийг эрэлхийлэх сүнсний аяллаа мартуулахад хүргэдэг зүйлийг хориглоно гэсэн үг (23).

## **САХИУЛСАН ТЭНГЭР**

Хамгаалагч-сахиулсан тэнгэрүүдийн зэрэг хоёрдугаар ертөнц хүртэл байна. Сахиулсан тэнгэрүүдийн зэрэг дэс хүнийхээс доогуур байдаг, доогуур зиндааных. Тэд бидэнд үйлчлэхийн тулд байдаг юм. Хүний төрөл олж төрөхийг нь эс тооцвол тэд тэгээд хэзээ ч дээш гарч

чадахгүй. Оройн Дээд Их Бурхан хүмүүсийн дотоодод оршдог учраас тэд хүмүүст их атаархдаг. Оройн Дээд Их Бурхантай нэг адил зиндаанд байх бүхий л боломж нөхцөл хүмүүс бидэнд байдаг, харин сахиулсан тэнгэрт байхгүй. Сахиулсан тэнгэрүүд бидэнд үйлчлэхийн тулд бүтээгдсэн. Сахиулсан тэнгэр өөр өөр. Жишээлбэл, хэрэв Бурхан түүнийг бүтээсэн бол тэр нь бидний төлөө л бүтээгдсэн хэрэг. Харин тэд дээшээ гарах ёсгүй, хэрэг ч үгүй. Жишээлбэл, та энд сууж байхдаа цэцэрлэг юм уу гэрийнхээ бүх гэрлийг асааж унтрааж, зориулалтын хэрэгслээр зурагтаа асааж унтрааж чадна. Хичнээн гайхалтай зүйл байлаа ч гэсэн тэр хэрэгсэл бол зөвхөн таны хэрэгцээг гүйцэлдүүлэх л зориулалтай. Тиймээс хэдийгээр тэр зүйл нь зарим нэг шинж чанараараа танаас илүү, бүр хамаг юмыг хянаж жолооддог, хүний хийж чадахгүйг чаддаг байлаа ч танаас илүү дээр гэсэн хэрэг биш. Тэр бол танд үйлчлэх цорын ганц зорилгоор л бүтээгдсэн. Тэр танаас илүү төгөлдөр сайн байлаа ч тийм биш юм (23).

### ***СУРГААЛЬ / НОМЛОЛ***

Багшийнх нь сургаал номлол “Агшин зуур билиг нээгдэх, энэ төрөлдөө туулан тонилох” гэдэг болохоос “Энэ насандаа төгс гэгээрсэн багш болно” гэдгүй /6, х 376/. Бид багшийг бус харин сургааль номлолыг л дагадаг. Тийм учраас бид хэзээ ч буруудна гэж байдаггүй. Ном зүй ёсондоо байхад бид номлолыг дагадаг. Та нарт зааж сургаж буй бүхэн материаллаг зүйлийн занганаас мултрах, бие сэтгэлийг хянагч тэр хүчнээс дээш гарах, өөрийгөө уураг тархи хэмээх компьютер болон энэ бие цогцоос илүү агуу зүйл гэдгээ ухаарахыг эрмэлзэгч бясалгагчдын эрин дамжсан билиг ухааны охь шим юм. Энэ бол оюун ухааны зам мөрийг хурдасгах нууц арга, нууц томъёо шиг зүйл юм (2, х 137).

Миний та нарт зааж сургаж байгаа бүхэн цөм судар номд бичээстэй байдаг. Эрт цагаас аваад ёс суртахуунт байдал өөрчлөгдөөгүй. Оройн Дээд Их Бурхан, Буддагийн сахил гэрээслэл өөрчлөгдөөгүй (2, х 115). Жинхэнэ багш бүхэн нэг юм. Тэд бүгдээрээ нэг эх сурвалжаас ирсэн бөгөөд хамгийн дээд багш бол та бүгдийн дотоодод оршин байгаа хамгийг чадагч, төгс дээд багш юм (2, х 105). Багш гэдэг бол та өөрөө юм.

Багш гэдэг бол таны “Жинхэнэ Мөн Чанар”. Багшийн тухай бодлоор дамжин Багшийн хамаг цог чанар танд аажим аажим, алхам алхамаар шилжинэ. Тэгээд хожим нь та “Өө багш гэдэг чинь би юм байна. Багш гэдэг чинь үргэлж би өөрөө байсийм байна гэдгээ ухаарч ойлгоно” /2, х 111-112/.

### ***СУУТ ХҮМҮҮС***

Авьяас төгөлдөр хүмүүс болон агуу суутан мэт гарамгай сод хүмүүс бол чанагуухи ертөнцийн мэргэжилтнүүд, тэд Асурийн Ертөнц, Хоёрдугаар Ертөнц, хэрэв эргэж ирэхээр шийдсэн бол зарим үед Гуравдугаар Ертөнцөөс ч ирдэг. Тэд бол онцгой. Тэд бол – суут хүмүүс (23).

### ***СҮНС***

*Үзэх: Бурхан, Бурхан чанар, Түүнчилэн ирсэн, Чинагуух ертөнц*

Сүнс бол өөрөө Дээд Мэдрэхүй, Дээд Үнэн юм. Юм харахын тулд сүнсэнд нүд хэрэггүй, сонсохын тулд чих хэрэггүй, ойлгохын тулд мэрэхүйн эрхтэн хэрэггүй. Энэ бол хаа сайгүй оршиж, бүх юмтай шүтэн барилдсан хамгийг мэдэгч, хамгийг сонсогч дотоодын маань Дээд Багш юм. Чухам үүнийг л эрж олох ёстой. Учир нь хүмүүн бид бүх ертөнцийн хамгийн Дээд багш нар юм. Та өөрийнхээ хичнээн агууг төсөөлөөд үз. Гэтэл амьдрал тань ямаршуухан байна? Та намайг сонсох гэж ирсэн нь тун харамсалтай. Учир нь бид эн тэнцүү, өчүүхэн ч зөрөөгүй (1, х 137).



Хэрэв давхарлан өмсөж байгаа билэгт цогцын хувцсаа бүгдийг нь тайлж хаявал сүнс маань нүцгэрнэ. Тэр үед сүнс маань нэг хэсэг гэрэл болон хувираад, нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэл гэж үгүй болно. Энэ нь тун өндөр зэрэгт хүрснийг харуулж байгаа юм. Ийм сүнс хааяагүй оршино. Диваажинд байна, эрлэг тамд байна, Замбуулингийн оронд ч, Буддагийн оронд ч байна. Тэр үед “хотол зохилдогч” болж хувирна. Арьяабал болж хувирна (76).

Билгийн мэлмий, үнэндээ тийм нүд байхгүй. Юм харахын тулд сүнсэнд нүд хэрэггүй, сонсохын тулд чих хэрэггүй, ойлгохын тулд мэдрэхүй хэрэггүй. Сүнс өөрөө дээд мэдрэхүй, Дээд үнэн юм. Энэ бол хаа сайгүй орших, бүх юмтай шүтэн барилдсан хамгийг мэдэгч, хамгийг сонсогч, дотоодын маань Дээд багш юм (2, х.152). Чухам үүнийг л эрж олох ёстой, учир нь бид бүх ертөнцийн хамгийн дээд багш нар юм. Та намайг сонсох гэж ирсэн нь харамсалтай. Учир нь бид энд тэнцүү, өчүүхэн ч зөрөөгүй.

Сүнс гарах гэж ярьдаг нь асури биеэс гарч явахыг хэлж байна. Энэ бол хамгийн гаднах нэгэн бие цогцыг тайлж хаяхыг хэлнэ. Цаана нь тийм хаявал зохих олон бие бас байна. Тиймээс сүнс гаргах нь түүнчлэн ирсэн үрийн хутаг биш, дээд билигт цогцыг жуулчлал ч биш (3, х 184). Дээд билигт цогцын, жуулчлал бол түүнчлэн ирсэн зэрэг юм, энэ тохиолд тэр бээр хаа сайгүй байж байна. Дэлхийд ч, Бурханы оронд ч нэг зэрэг байна, тэр үед “хотол зохилдогч” болж хувирна. Арьяабал болж хувирна, ямар ч газраас цөм сонсогдно, бас ямар ч газар цөм хүрч чадна. Харин сүнсээ гаргаад дэлхийгээр, ойр зуур яваад сурчихвал биенийхээ бусад олон давхар хувцсыг тайлж байж нэн өндөр түвшинд очихоо мартана, нэн өндөр үрийн хутгийг олохоо мартана (3, х 183). Олон давхар бие цогц Бурхан чанарыг маань хүлж байдаг (6, х 264). Арьяабалын номын цогц нь сүнс гаргах төдий зүйл биш, үнэнхүү туулан тонилох цогц юм (5, х.197).

Гэрэлгүй бол байж болно. Харин аялгуу үгүй бол сүнс маань амьдрахад амаргүй болно (3, х 186). Асури бие махан биетэй бараг адил, нэг л газар хоригдоод, зөвхөн нэг л бие төдий юм. Бидний жинхэнэ дүр маань бие дотроо хоригдож байдаг болохоор хаа сайгүй явж чаддаггүй (3, х 198). Хэрэв бүхий л орчлонг үзье гэвэл хамгийн өндөр газарт гарах хэрэгтэй. Олон давхар биед агуулагдаж боогдсон сүнс буюу бидний жинхэнэ эзэн бол орчлонгийн дайтай том юм. Асури бие нь эсэрваа дотор хоригдож, түүнээс дээхнүүр бидний биеийн сансартай холбогдсон мөнгөн утастай нэвтрэлцэж мэдэх төдий болохоор бас л чөлөөтэй биш юм. Бид үнэхээр түүнчлэн ирсэн болох үед бид хаа сайгүй бий болно. Энэ нь жинхэнэ дүр томорсон болохоос биш махан бие, асури биеэрээ дээш гарах аргагүй юм (3, х 199).

Бид III ертөнц дотор буюу IV, V ертөнцөд байх үед бас ч туйлдаа хүрч чадаагүй тул цааш дээш гарахын тулд сүнс маань томорсоор орчлонгийн дайтай болоод хаа сайгүй байх тэр үед түүнчлэн ирсэн болох юм. Арьяабалын номын цогцыг түүнчлэн ирсэн байдалд хүрхийн төлөө бясалгалаас биш махан биеээ үлдээж билигт цогцоороо гарах төдийхөн биш юм. Сүүлийн тохиолд сүнс гаргаснаа, юу үзсэнээ тухайн хүн бүгдийг нь мэднэ. Гэвч энэ нь ганц л асури бие хэрэглэсэн тул газар болгонд байж чадахгүй, зуу, мянга, дүнчүүр хувилгаан биетэй болж чадахгүй юм (III, 200).

Туулан тонилох гэдэг нь бид бүх билигт цогцын хувцсаа тайлж хаяаад, билигт цогцоо (сүнс) бүх орчлонд тултал томруулж түүнчилэн ирсэн болно (3, х 202). Ингэвэл биднийг бодсон хүн бүрийн дэргэд тэр дороо илэрнэ. Мянган газраас даатган хүсэхэд 1000 газар илэрнэ гэдэг энэ билээ. Энэ бол бидний эцсийн зорилт болно (3, х 204). Махан бие - хувилгаан бие I ертөнц, Тахилын бие - үйл үрийн бие II ертөнц, оюун санааны бие III ертөнц, V ертөнцөд хүрвэл биеийн хувцас гэмээр юм үгүй болно 3, х 235).

## **СҮСЭГ БАРИЛДЛАГА**

*Үзэх: Даатгал*

## **СЭТГЭЛ**

*Үзэх: Бодол*

Бясалгалын эрдэм бол гайхамшигтай их юм. Сэтгэлийн хүч маш их болохоор Диваажинь орныг бүтээж, Эрлэг тамын орныг эвдэж чадна. Аливаа бүхэн цөм энэхүү сэтгэлд л байгаа юм (61).

Сэтгэл нь санамжийн хүч буюу энергийн хүч тээж байдаг. Бидний юу хийсэн бүхэн энергийн хэлбэрийг бий болгодог. Энэ энерги нь хүний өөдлөх, доройтох гэх мэт энэ ертөнцөд сүнсний эдэлж өнгөрүүлэх амьдралын хэв маягийг бий болгодог (2, х 55).

Хэрэв бид сайхан сэтгэлтэй бол бүх юмстай нэгдмэл байхад хялбархан бөгөөд Эзэн Бурхантай холбогдоход ч амархан болно. Сэтгэл маань хөндий байвал бид өөрсдийгөө тойруулж хана өрсөнтэй адил болдог. Бид зөвхөн Багшийн дэргэд байснаар л зүрх сэтгэл маань түүнд илүү ойр байдаг юм биш. Хэрэв сэтгэл тань ойрхон байхыг хүсвэл түмэн бээрийн зай ч хол санагдахгүй. Бид Түүний хажууд нь байлаа ч Түүнтэй хамт биш байвал бид үнэхээр хол байх болно.

Хамгийн сайхан бөгөөд ариун сэтгэл нь орчлонгийн бүх сайн сайхан зүйлийг, хамгийн цэвэр ариун болгоныг, бүр бидний хүссэнээс ч илүү ихийг өөртөө татдаг. Та нар сэтгэлээ сургах ёстой. Сэтгэлдээ өөрсдийгөө эзэн чинь байна гэж хэл. Юу бодохыг нь, юу хийхийг нь, юу мэдрэхийг нь, ямар дэсэд харъяалагдах ёстойг нь ч хэл. Үүнийг хийж чадвал та нар өөрсдийнхөө эзэн, Багш болжээ гэж ойлго. Өөртөө итгүүлэхэд л хэцүү байгаа болохоос биш та нар хэдийнээ багш юм шүү дээ. Өөртэйгөө ажиллацгаа.

## **ТАЛАРХАЛ**

*Үзэх: Даатгал*

Бүх юмыг талархсан сэтгэлээр эдлэх хэрэгтэй. Талархах сэтгэлгүй бол өөрийн аугаа ихийг мэдэж чадахгүй (6, х 397). Нэгэн аугаа хүчин аливаа бүхнийг анхааран болгоож байдгийг мартаход хүрч машид өнчирч зовох болно (6, х 399).

## **ТӨВ ҮЗЭЛ**

*Үзэх: Дао*

Шагжамуни Бурханд шөнө ч унтдаггүй нэгэн шавь байжээ. Өдөржин бясалгаж, шөнөжин ном шагайсаар бараг сохрох шахжээ. Тэгээд Шагжамуни Бурхан: “Энэ янзаараа бол чи удахгүй Гэгээнтэн биш Маяа болох нь. Ятга тоглоход утас нь хэт чанга юм уу хэт сул байвал ямар нэг дуу гаргаж чадах уу? Дундыг барих л хамгийн сайн” гэжээ. Тиймээс тэнцвэртэй амьдрал бол Үнэн, энгийн бодол санаа бол Үнэн. Бид юуг ч хүсч юунд ч шунаж болохгүй. Гэгээнтэн болох гэж яаран хүсэх нь бол нэг төрлийн шунал. Юуг ч хийсэн дундыг барих хэрэгтэй. Хамгийн шилдэг зам бол төв үзэл (2, х 190).

## **ТӨГС ГЭГЭЭРЭЛ**

*Үзэх: Туулан тонилох, Түүнчилэн ирсэн*

## **ТӨЛБӨР**

### *Үзэх: Үйлийн үр*

Энэ дэлхийд юу хүссэнээ хийж болдог ч заавал төлдөг. Мөнгө яриагүй юм шүү. Үйлийн үр гэсэн үг. Төлбөрийн байдал нь энэ дэлхийд Бурханы хийж бүтээсэн эд баялгаас хичнээнийг авсан гэдгээс шалтгаална. Хичнээн ихийг авна, төчнөөнийг буцааж төлнө. Хэдий хир бага авна, төдийчинээ бага төлнө. Цагаан хоолтой амьдарснаар нүгэл бага үйлдэж, үйлийн үр хөнгөрөх юм. Хэрвээ та эргээн төлж чадахгүй бол Бүхнийг Чадагч Бурханд хүрч чадахгүй. Энд л асуудал байгаа юм даа. Амьтны амь хороовол хэдэн үедээ төлөх болно. Амьтныг зовоосон л бол хобби юу, амин зуулга уу адил, төлбөр төлөх л болно. Архи, тамхи, хар тамхи гэх мэт нь хүн, гэр бүл, нийгмийн энх амгаланг бусниулдаг тул үйл үр нь их. Амьтан, хүн хороовол там руу очих учиртай. Амьтанд зовлон учруулсан үйлийн үрийг 2-3 дахин нугалж төлнө. Үр хүүхэд, эцэг эх бүгдэд нь нөлөөлнө. Бүх буянаа барна. Ингээд доод оршихууд төрөл олно (15).

### **ТӨРӨЛ АВАХ**

Төрөл арилжих гэдэг нь эргэн ирэх орчил юм. Хэрэв Бурханы оронд хүрэх гарцыг олоогүй бол эргэж ирэх хэрэгтэй болно. Төрөл арилжихуйн онолыг зааж сургах хэрэггүй, учир нь бидэнд угтаа төрөл авдаг оршнол байхгүй. Төрөл авдаг зүйл маань хураасан сайн муу мэдээлэлдээ хоргодон татагдах хандлага маань л байх /2, х 52/. Мэдээллийн араас дагаж Билгүүн ухаан буюу Бурханлиг чанар маань бие хэмээх энэ сүмийг орхиод өөр сүмд шилжин очдог. Үнэндээ бол ертөнцөд оршин байдаг зүйл гэж нэгээхэн ч үгүй. Энергийн бөөгнөрөл болон хайрын орон зай л гэж бий, тэр нь заримдаа янз бүрийн хэсэгт хуваагддаг. Энэ нь цахилгаан гүйдэл чийдэнд, дамжуулах утас, микрофон гэх мэт өөр өөр зүйлд оршдогтой адил юм. Цахилгаан өөр өөр зүйлд оршивч гүйдэл нь яг адилхан (2, х 53). Зарим хүн өдөрт 4-5 цаг бясалгасан ч сэтгэл нь дэлхий ертөнцөд татагдсан хэвээр, нэр хүнд эд хөрөнгө хүссээр л байдаг. Тэд энэ дэлхийд байхыг хүссээр байгаа учраас дахин нэг удаа төрөл авах хэрэгтэй болж магад (1, х 86).

### **ТУУЛАН ТОНИЛОХ**

Эцсийн зорилго бол туулан тонилох юм (3, х 202).

Туулан тонилох гэдэг нь бүх билигт цогцын хувцсаа тайлж хаяад, билигт цогц буюу сүнсээ бүх орчлонд тултал томруулж Түүнчилэн ирсэн болно (3, х 202). Түүнчилэн ирсэн болох үед бид хаа сайгүй бий болно Ингэвэл биднийг бодсон хүн бүрийн дэргэд тэр дороо илэрнэ. Мянган газраас даатган хүсэхэд мянган газар илэрнэ гэдэг энэ билээ. Энэ бол бидний эцсийн зорилт болно (3, х205).

Дээд зэргийн билэгт цогцын жуучлал бол түүнчилэн ажирсан зэрэг дэс болох тул хааяагүй оршиж байдаг юм. Диваажинд байна, эрлэг тамд байна, Замбуулингийн оронд ч, Буддагийн оронд ч байна. Тэр үед “хотол зохилдогч” болж хувирна. Арьяабал болж хувирна. Тэр үед сүнс нэг хэсэг гэрэл болон хувираад, улмаар бие, хэл, сэтгэл гэдэг юм үгүй болж, нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэл гэж үгүй болно.

Үнэхээр жинхэнэ түүнчилэн ажирсан болох үед бид хаа сайгүй буй болж, жинхэнэ дүр маань томорсон болохоос бид махан биеэрээ дээш гарах бус, асури биеэрээ дээш гарах ч биш юм.

Бид гуравдугаар ертөнцийн дотор байх буюу дөрөв, тавдугаар ертөнц дээр оршихын үед, нэгэнт туйлдаа хүрч чадаагүй тул цааш нь үргэлжлэн дээш гарах гэхийн хэрэггүй, харин томорсоор байгаад орчлонтой адил болоод хаа сайгүй байж болох тэр үед л түүнчилэн ирсэн болох юм.

Түүнчилэн ирсэн болох нь бидний жинхэнэ дүр томорсон хэрэг юм. Бид 3-р ертөнцийн дотор байх буюу 4, 5-р ертөнцөд байх үед бас ч туйлдаа хүрч чадаагүй тул цааш дээш гарахын тулд сүнс маань томорсоор байгаад орчлонгийн дайтай болоод хаа сайгүй байх үед Түүнчилэн ирсэн болох юм. Арьяабалын бясалгалыг Түүнчилэн ирсэн байдалд хүрэхийн тулд бясалгахаас бус

махан биеэ үлдээж билигт цогцоороо гарах төдийхэн биш юм. Сүнс гаргаснаа, юу үзсэнээ тэр хүн бүгдийг мэднэ. Гэвч энэ нь ганц л бие хэрэглэсэн тул газар болгонд байж чадахгүй, зуун мянган дүнчүүр хувилгаан биетэй болж чадахгүй юм. Туулан тонилох гэдэг нь бүх билигт цогцын хувцсаа тайлж хаяад, билигт цогцоо (сүнс) бүх орчлонд тултал томруулж Түүнчилэн ирсэн болно (3, х 204).

Гэгээрэх үедээ бид Оршихуйн дээд төвшинд хүрч, амьдралыг огт өөрөөр харах бөгөөд энэ бүхэн ямар ч хүч чармайлт, догдлол хямралгүй болж өнгөрдөг” (1, х 14).

Бидний хийх ёстой зүйл бол өдөр бүр инээн баясаж чөлөөтэй байх шүү дээ. Үнэхээр гайхалтай. Нүүрэнд тань ямагт инээмсэглэл тодрон, зүрх сэтгэл тань үргэлж хайрыг мэдрэхэд та хамгийн дээд бүрэн Даог олсноо мэдэх болно. Энэ маш амархан, хамгийн хялбар зүйл. Та нарт хийгээд байх юм үнэндээ байхгүй (7, 3-р хэсэг).

Дао буюу гэгээрэлд хүрэхийн цагт та хэдийчинээ их гэгээрсэн байна, төдийчинээ амгалан, энэрэнгүй болно (2, х 26).

Гэгээрсний дараа л бид:

- Оройн Дээд Их Бурханы төлөвлөгөөг мэдэх болж, түүнд зохицуулан хийнэ.
- Гэгээрэхээс өмнө бол Бурханы төлөвлөгөөнд өөрийн хүсэл зоригийг тулгах гэж оролдоод юмыг эмх цэгцгүй байдалд оруулж байдаг.
- Үүнээс хойш та бие даан шийдвэр гаргахгүй.
- Хөндлөнгөөс харахад бусадтай адил хийж байх мэт боловч угтаа үйлдэл бүрийг тань Оройн Дээд Их Бурхан хэлж өгөх болно.
- Цаашид танд хариуцлага гэж байхгүй болж, та хэзээ ямагт чадлаараа хийдэг болно (2, х 95).

### ***ТҮҮНЧИЛЭН ИРСЭН***

Бурхан болчихвол “Би түүнчилэн ирсэн боллоо” гэж хэлж болно (6, х 144). Түүнчилэн ирсэн гэдэг нь ирэх ч үгүй, очих ч үгүйг хэлнэ (6, х 208). Түүнчилэн ирсэн болох үед бид хаа сайгүй бий болно. Туулан тонилох гэдэг нь бүх билэгт цогц (сүнс)-ын хувцсаа тайлж хаяад, сүнсээ бүх орчлонд тултал томруулж Түүнчилэн ирсэн болно (5, х 202). Арьяабалын номын цогцыг Түүнчилэн ирсэн байдалд хүрэх гэж бясалгахаас биш махан биеэ үлдээж сүнсээ гаргах төдийхэн биш. Сүнс гаргаснаа, юу үзсэнээ тэр хүн бүгдийг мэднэ. Гэвч энэ нь ганц л бие хэрэглэсэн тул газар болгонд байж чадахгүй, зуу, мянга, дүнчүүр хувилгаан биетэй байж чадахгүй (5, х 200).

### ***ТЭВЧЭЭР***

*Үзэх: Хүсэл, Шид*

### ***УДИРДАГЧ***

*Үзэх: Энх тайван, Дайн*

Сайн удирдагчтай байх нь ард иргэдийн ёс суртахуунтай холбоотой. Бид өөрсдөө сайн удирдагчтай байх гавьяагүй бол сайн удирдагч яаж олдох билээ. Хүмүүс бид өөрсдөө сайжрах ёстой. Заримдаа сайн удирдагч байсан ч ус орны муу үйлийн үр муу юм хийхэд хүргэдэг. Нийт ардын ухамсар сайн бол удирдагч мөн сайн байна (71).

### ***УХАМСАР***

*Үзэх: Сүнс, Ухамсрын төвшин, Оршихуйн төвшин*

Диваажингийн захиасыг илгээх болон сургахад цорын ганц дээд зам байдаг ба үүнийг дотоодоос билиг ухаанаар тэнгэрлиг хэл ашиглан дамжуулж байдаг. Энд Багш ирэх, ярих шаардлагагүй. Жинхэнэ мөн чанарыг таниулахад ингэх шаардлага байхгүй (10).

Хоёр ухамсар холбогдох нь цаг хугацаа, орон зайнаас огт хамаагүй. Энэ нь квант механикийн онол зүйд нийцнэ. Цаг хугацаа, орон зай бол ердөө дэлхийд л хамаатай зүйл, оюун санааны ертөнцөд хамаагүй (25).

Холбогдсон л бол та өөрийгээ намайг юм шиг санана. Ядаж л миний нэг хэсэг юм шиг санана. Энэ бол хэвийн зүйл. Багш үнэндээ өөрийгээ үй май хувилж, бүх л ертөнцийг бий болгож чадна. Зөвхөн үүгээр зогсохгүй (10).

Зөвхөн Арьяабалын бясалгалаар л бид ухамсрын бүх түвшинд хүрч чадна. Гэрэл, аялгуу бол бидний мөн чанар юм. Та өөр руугаа орно гэсэн үг. Таныг өөрөөс тань илүү юу сайхан болгож чадах билээ. Загас усанд байхаас илүү юу загасыг сайхан болгох билээ. Та өөрийн гэрлийг харж байгаа юм биш, та өөрөө гэрэл юм. Та өөрийн аялгууг ажиж байгаа юм биш, та өөрөө аялгуу юм. Та бол бүх орчлонг бүтээж буй тэр чичиргээ юм. Орчлонгийн дарга, удирдлага нь та өөрөө юм. Бурхан чанар амьсгалд, зүрхний цохилтонд, ходоодны халуунд байхгүй. Тийм болохоор зүрхний зохилт, биеийн дулааныг өөрчлөх нь утгагүй зүйл. Гэгээрэлтэй ямар ч хамааралгүй. Харин бид Бурхан чанарыг бүхэл бүтнээр нь олж авах хэрэгтэй (55).

Элдэв маяг чимэг, өмсгөл баггүй байгаагаараа л бай. Яг нар, сар, тэнгэр шиг агуу, хариу нэхэлгүй ухаалиг бай. Агуу, уужим, хязгааргүй бай. Энэ л чухамхүү та мөн.

Цаг ямагт би үзэлгүй, болзол нөхцөлгүй бай. Хэзээ ч ашиг бүү горил. Тэгвэл хүссэнээсээ ч илүүг хүртэх болно. Үргэлж аминч бус, нөхцөл болзолгүй бай. Энэ нь диваажингийн ажлын арга зам юм. Нар ивээснийхээ төлөө эргээж танаас юу ч нэхдэггүй шиг, сар, од эрхэс, мод, агаарын аль нь ч юу ч хүсэхгүй адисладаг шиг бай. Энэ бол ухамсрыг дэвшүүлэх арга зам ба хариу нэхэлгүй, болзол нөхцөлгүй байж гэмээ нь бусдыг адислаж чадна гэсэн үг. Өгсөн ч, авсан ч тэнд “би” байхгүй байг. Хэрэв хүссээр л байвал миний адислалыг ч хүртэж чадахгүй. Энэ бол доод түвшин. Юуг ч бүү хүс, зүгээр л бай. Тэр юм таных болох ёстой бол хүрээд л ирнэ, тэгэхээр нь хадгалчих. Ямарваа юмыг хүсэх нь танд маш муу. Хүссэн зоргоор олддог ч юм биш, үүнд оюун санааны адислал, хүч, төвшин ч мөн адил хамаарна (64).

*Ухамсар* - энэ бол билгүүн ухааны нэг төрөл, та ямар нэг зүйлийг урьд өмнө хэзээ нэгтээ мэдэж байснаасаа илүү мэдэж байгаа юм шиг. Та энэ ертөнцийн зааг хязгаарын гаднах ямар нэг зүйлийг мэддэг, бас урьд өмнө мэддэггүй байсан энэ ертөнцийн ямар нэг зүйлийг мэддэг. Мөн урьд өмнө нь ойлгодоггүй байсан эсвэл ойлгож чаддаггүй байсан олон зүйлийг ойлгож мэддэг. Энэ бол ухамсар. Тэгээд энэ ухамсар эсвэл билгүүн ухаан гэж нэрлэдэг зүйлээ нээнгүүт та хэн юм бэ, яагаад энд байгаа юм, энэ ертөнцийн чанадад өөр юу байдаг юм, газар дэлхийн хүний зэрэгцээ өөр хэн оршин байдаг юм гэдгийг үнэхээр ойлгох болно. Олон зүйл байдаг. Тэгэхлээр ухамсрын төвшин нь яг л коллеж төгсөхтэй адил, ойлголтын янз бүрийн дэсийн нэг нь юм. Төгсөх хүртлээ хичнээн их юм сурна төчнөөн их юм мэднэ. Ийм хийсвэр ойлголтыг тайлбарлах амаргүй.

Ухамсар бол сэхээрэл гэж хэлж болох юм. Сэхээрэл гэж юу болохыг тайлбарлах хэцүү. Та ухамсрын өөр, илүү өндөр түвшинд хүрэхэд таны сэхээрэл өөрчлөгдөнө. Та юмсыг өөр янзаар ойлгож, өөр байдлаар мэдрэх болно. Та туйлын амгаланг мэдэрч, нэн амар амарлингуй, аз жаргалтай болно. Таны санааг зовоох юм үгүй болж, өдөр тутмын амьдралын тань юм бүхэн тов тодорхой болно. Аливаа зүйлсийг хэрхэн эмхлэн төвхнүүлэх, төвөг бэрхшээлийг яаж амар хялбар зохицуулахаа мэддэг болно. Энэ нь тэр байтугай материаллаг төвшинд ч хэдийнээ ач тусаа өгнө. Харин та дотоод талдаа юу мэдэрч буйг зөвхөн та өөрөө л мэдэж байх болно (23).

## **УХАМСРЫН ТӨВШИН**

*Үзэх: Ухамсар, Оршихуйн төвшин, Чинагуух ертөнц*

## **ҮЙЛДЭХГҮЙГЭЭР ҮЙЛДЭХ**

Үзэх: *Хийхгүйгээр хийх*

### **ҮЙЛИЙН ҮР**

Үзэх: *Буян ба нүгэл, Веган хоол, Гэтлэгдэх*

Үйлийн үр гэдэг нь “Юу тарина, түүнийгээ л хурааж авах” хууль юм. Бид жүржийн үр тарьсан бол жүрж хурааж авдаг, алимын үр суулгасан бол алим л хурааж авдагтай адил, үүнийг л үйл үр гээд байгаа юм. Самгарьд хэлний энэ нэр томъёо нь шалтгаан ба түүний үр дагаврыг илэрхийлдэг (23). Бурханы шашинд үздэгээр: “Үйл үрийн биелэл өчүүхэн ч зөрүүгүй” (6, тал 408).

Бурхан Багш: “Хэрэв энэ дэлхийн хүмүүсийн нүгэлт үйлийн үр нь хэлбэр дүрстэй байдаг бол түүнийг нь бүхий л сансар огторгуй агуулж үл чадна” хэмээн айлджээ (6, тал 40).

Ертөнц бүхэнд үйлийн үр байдаг бус, зөвхөн Хоёрдугаар Ертөнцөд хүртэл л байдаг. Учир нь бидний ухаан бодол, уураг тархи болох энэ компьютер нь Хоёрдугаар Ертөнцийн “бүтээл” юм (23).

Та Хоёрдугаар Ертөнцийн төгсгөлд цаашид ахихын өмнө үйлийн үрээ цөмийг ардаа орхих, өөрөөр хэлбэл хамаг үйл түйтгэрээ төлж арилгах ёстой. Одоогийн энэ төрлийг олох үед бидэнтэй хамт ирсэн урьд төрлүүдийн бүх үйл түйтгэр үүнд бас хамаарна. Учир нь Хоёрдугаар Ертөнцөөс цааш бидэнд энэ “компьютер - тархи” гээч юм бүхнийг тогтоон санах хэрэгсэл хэрэггүй болно.

Биет ертөнцийн амьдралын дадал туршлага бүхнийг маань бүртгэн санаж, тогтоох зориулалтай уураг тархи, ой ухаан, энэ компьютер байгаа болохоор л бидэнд үйл үр, үйл түйтгэр байгаа юм. Сайн, муу ямар ч мэдээллийг бид тархиндаа бүртгэчихдэг. Үүнийг л бид үйлийн үр гээд байгаа юм.

Үйлийн үр гэж юу юм бэ? Бидний төрөл төрөлдөө хуримтлуулсан сайн, муу туршлага мэдлэг, хариу үйлдэл, сурах дадал төдий л юм шүү дээ. Бидэнд ухамсар гэгч юм байдаг болохоор бид сайн хүн байх ёстой гэдгээ мэддэг, бас заримдаа муу юм ч хийчихдэг. Тэгээд түүнийгээ үйлийн үр гэдэг. Харин муу муухай үйлдэл маань хүнд ачаа, хэрэггүй хог мэт дарамт болж, газрын татах хүчний хуулиар биднийг доош татан, уул өөдөө авирья гэвч нэн хэцүү байдаг. Энэ ертөнцөд байх ёс суртахууны нэн олон хэв журам, янз янзын үндэстэн угсаатны өчнөөн их дэг жаяг, зан заншил, дадал зуршил нь биднийг сайн муу, гэмтэй гэмгүйн үзэл бодлын хүлээсэнд оруулдаг. Тиймээс бид энэ ертөнцөд хүмүүстэй харилцахдаа тухайн үндэстний зан заншил, өв уламжлал, хууль дүрмийн дагуу сайн муу, нүгэл буяны тухай ойлголт туршлага олж авдаг. Тэгээд л тэр маягаар бодож тунгаах нь бидний зуршил болж, би үүнийг хийсэн, би гэм буруутай, би тэгсэн, би муу хүн гэж боддог дадал тогтчихдог. Энэ бүхэн энд л бичигдэж тэмдэглэгддэг. Биднийг биет болон түүнээс арай дээхнүүр орших, өндөр биш төвшний ертөнцөд хүлж уяад, янз бүрийн төрөл авахуулаад байдаг зүйл бол энэ. Энэ бүх үзэл бодол, урьдаас тогтчихсон итгэл үнэмшлийнхээ улмаас бид эрх чөлөөтэй биш, өөдөө дээш хөөрөн гарчихаар хөнгөн биш байдаг юм (23).

Дэлхийн нас уртассан нь дэлхий сэрүүсч хөрсөн, дулаарал зогссон гэсэн үг биш. Хүмүүн бид буруу үйлдсээр л бол дэлхийг сөнөөх хүч хэвээр байсаар л байна (67).

Хүн төрөлхтний 1/4, 1/3 нь веган /ногоо хоолтон/ боллоо ч муу үйлийн үрийг бүрэн зогсоож чадахгүй. Атлант, Лимур, Му гэхчилэн их хөгжсөн төрөлтнүүд ч үйл үрээс зайлж чадаагүй (68).

Буруу зүйл хийсэн хоёр хүний нэг нь болохоор нөгөөгөөсөө боллоо гэж бодох, хорлогдсон гэгдэх тал нь бас нөгөө талын хийсэн хэрэг гэж бодно. Ийм хоёр талцсан үзэл нийлэхэд нэгэн

зүйлийн занал хорсолт үйл явдал бүрэлдэнэ. Тэгээд завшаан хайж хариугаа авна. Ингэж л үйл үрийн хүрдэнд эргэлдэнэ.

Будда бодисад өөрөө юу ч хийсэн огт ялгүй, үйл үргүй. Учир нь тэр барилдлагыг нэгэнт нэвт шувт харж, тодорхой мэдсэн болохоор энэ мэт зүйл хийхгүй. Тэрээр юу хийхийгээ мэднэ, бүр тов тодорхой мэднэ. Ийм учраас үйл үрийн хүрээнд явж орохгүй.

Түүнийг тархи толгойдоо шингээж авдаггүй юм. Энэ нь түүний хийсэн юм биш гэдгийг сайн мэднэ. Тэгэхээр энэ нь түүнд ямар ч асуудал болохгүй. Гэвч хамаг амьтан үүнийг мэдэхгүй, тэд өөрөө хийсэн гэж боддог учраас үйл түйтгэр буй болно. Иймээс энэхүү үзлийг аялгууны урсгалаар өдөр болгон угааж цэвэрлэж байх хэрэгтэй. Үүнээс өөр ямар ч арга байхгүй. Ингэж нэг хэсэг хугацаагаар угаасны дараа угаах юм үлдэхгүй болно. Угааж заншсаны дараа зөвхөн аялгуу ажихуй л үлдэх болно. Тэрхүү гэмт муу зүйл сэтгэлд чинь орж ирэхээс өмнө нэгэнтээ угааж хаясан болохоор тэрхүү гэмт мууг санах сэтгэл аяндаа алга болсон байдаг. Ганцхүү аялгууны урсгалтай хамт байж гэмээнэ ямар ч гэмт муу гэх зүйлийг санах сэтгэл орж ирэхгүй болно. Орж ирэхээс нь өмнө угаагаад хаячихсан юм чинь.

Бидний бясалгал бүрэн гүйцэд болоогүй болохоор урьдаас үйлдэж ирсэн гэм зэмийг санах сэтгэл байнга байна.

Хэдийгээр аялгууны урсгалд оршиж байгаа боловч түүнийг бүрэн угааж амжаагүй байна. Бид ахиухан угаасны дараа аялгууны урсгал нь гэмт муу зүйлийг санах сэтгэлээс давж, тэрхүү сэтгэл орж ирмэгц цэвэрлэн арилгаж, яг л их өлссөн хүн жаахан идэхэд идээгүй юм шиг санагддагтай адил болно. Эсхүл нэл их далайд бага сага хог шороо орсон ч үгүйтэй адил, жаахан бохир ус хийсэн ч мэдэгдэхгүйтэй адил байдаг юм (4).

Энэ дэлхийд үнэгүй зүйл гэж огт үгүй. Тиймээс ч та нар надаас яагаад буян хураах ёстойг асууж байгаа. Амьд явахын тулд ингэх ёстой юм (40).

Бид хэрхэвч амь хөнөөх ёсгүй, яагаад гэвэл энэ нь амьдралын хууль зарчимд харшилна. Бусдын амь насыг хохироохгүй бол бидний амь нас ч аюулд өртөхгүй. Энэ бол Учир шалтгаан, Үр дагавар буюу Үйлийн үрийн хууль юм (2, тал 138).

Нэгэнт энэ дэлхийд байхад хамтын үйлийн үр, бусдыг хайрлах зүрх байгаа хойно үйлийн үр, холбоог тасардаггүй (34). Үйлийн үрд хол ойр гэж үгүй. Иймд авшиг авуут хамгийн багадаа бүр 5 үе бүр 9, 10 үе нь чөлөөлөгддөг (77). Ертөнцийг 1000 будда, сая Иус байгаад ч өөрчилж чадахгүй. Учир нь үйлийн үр байгаа газарт ид шид ингэж тохиодоггүй юм (78).

Нүгэлтэн гэж байхгүй. Харанхуй мунхаг л гэж байна. Идэх уух, өмсөх зүүх, энэ тэрийг л заалгасан болохоос ариун замыг та нар заалгаагүй. Сургууль ном нь яаж ажилтай болохыг л заадаг. Ийм болохоор мунхаг, үйлийн үр бидний үйлдлээс гардаг. Бидний хийсэн бүхний үр юм (38).

Амьтан бие биеэ барьсаар байхад үйлийн үрийг арилгана гэж байхгүй, хэзээ ч үгүй. Үүнийг ямар аргаар ч бай төлж барагдуулна (77).

Сэтгэл нь ой санамжийн хүч буюу энергийн хүч тээж байдаг. Бидний юу хийсэн бүхэн энергийн хэлбэрийг бий болгодог. Энэ энерги нь өөдлөх, доройтох гэх мэт энэ ертөнцөд сүнсний эдлэн өнгөрүүлэх амьд маягийг бий болгодог. Үйлийн үрийн хуулийг эвдлэн зайлж чадваас үхэх үгүй, төрөх нь үгүй, амьдрал үгүй, үйлийн үр үгүй, гагцхүү аз жаргал амар амгалан ноёрхох оршихуйн тэр хэмжээст хүрнэ (2, х 59). “Юу тарьснаа хураах” үйлийн үрийн хуулийг давбал цаана нь хайрын хууль бий. Тэнд зөвхөн нигүүсэл ба амгалан бий. Бид орчныхоо хүмүүсийг харж, тэдний тухай бодож, идэх хоол, унших номоо хуваалцах зэргээр тэдний үйлийн үрээс авч байдаг. Ингэж хүмүүсийг адислан, үйлийн үрийг нь багасгаж байдаг юм. Харанхуйг хөөж, гэрэл гэгээ дэлгэрүүлэн бясалгал хийдгийн маань учир энэ билээ.

Бидэнд үйлийн үрээсээ өгч байгаа хүмүүс бол азтай адислагдсан улс. Иймээс бидний хөгжил дэвшил удаан байдаг. Түүнээс биш тэр даруйдаа Бурханы орон руу явчихвал хэн энэ ертөнцийг адислах юм бэ. Тиймээс бид өр, төлөөсөө дуусгаж, мөн ертөнцийг адислахын тулд энд байх ёстой. (2, х 126).

Үг хэл, үйл хөдлөл, үзэл бодлоо үргэлж цэвэр ариун байлга, ингэх нь ирээдүйд учрах зовлон бэрхшээл, саад тотгороос таныг холдуулж чаддаг. Урьдын үйл үр тань нэгэнт шийдэгдсэнээс хойш ирээдүйд улам зовоох муу үйл үрийг хийхгүй байх хэрэгтэй.

### **ҮНЭН**

Тэнцвэртэй амьдрал бол Үнэн, энгийн бодол санаа бол Үнэн мөн (1, х 110). Үнэн дэргэд маань байдаг (6, х 139). Хүн аз жаргалтай үедээ Нирваанд байдаг. Аз жаргалгүй үедээ урам зориггүй болсон байдаг. Тийм учраас “Үнэний зам мөр ертөнцийн хэрэг явдалд оршдог” гэсэн үг бий (1, х 135). Хүүхэд шиг ариун сэтгэлтэй байж ямар ч зүйлийг цэвэр ариун, эгэл даруу сэтгэлээр үйлдвэл Үнэнд мөдхөн хүрнэ (1, х 30).

Зүрх сэтгэл нь цэвэр ариун, даруу, ааш зан нь эвдрээгүй, ямар нэг зүйлд хүлэгдэх найдах юмгүй хүн орчлон ертөнцтэй бараг нэгдмэл (1, х 78). Омог бардам байхын хирээр Үнэн ёсноос төчнөөн холдоно (1, х 76). Инагуух ертөнцөөс хэдийчинээ хамаарна, чинагуух ертөнцөөс төдийчинээ холдоно (1, х 76). Үнэнд хүрье гэвэл хүүхэд шиг ариун сэтгэлтэй байх ёстой, ямар ч зүйлийг цэвэр ариун, эгэл даруу сэтгэлээр үйлдвэл Үнэнд мөдхөн хүрнэ. Хэрэв та өөрөө ярвигтай хүн бол, зарга маргаан тун их хийдэг, зөв буруугийн тухайд хэтэрхий их боддог, хожил болоод ялагдлыг хэт ноцтой хүлээж авдаг бол Үнэнд хүрэх замаа удаан байна гэж намайг бүү буруутгаарай. Та өөрөө л өөрийгөө цөхрөөж байгаа шүү.

### **ҮНЭНЧ СЭТГЭЛ**

Үнэнийг үтэр түргэн онооё гэвэл Үнэнд чин сэтгэлээсээ тэмүүлэх хэрэгтэй (2, х 21). Энэ дэлхийн хувьд үхсэн мэт биш бол Эзэн Бурханы хувьд амьд байх аргагүй. Бурхан чөтгөр хоёрт зэрэг үйлчлэх боломжгүй. Иймд нэг үзүүрт сэтгэлийг барих нь зүйтэй (1, х 43).

Ганц л хүн дээр төвлөр. Бурханы оронд байгаа Ханьдаа үнэнч бай. Үүнийг л үнэнч сэтгэл гэдэг юм (1, х 49). Миний нууц гэвэл Багшдаа бүрэн итгэсэн итгэл (1, х 40).

### **ҮХЭЛ**

Үхсэний дараа авшигтан дээр Багш нь ирнэ. Авшиг аваагүй бол Кал /хар хүч/ ирнэ. Авшиг авснаас хойш сүнс Калд харьяалагдахгүй болохоор тэр таныг хянаж чадахаа больж зайлна. Гэвч тэр таныг айлгах гэж оролдох нь мэдээж. Тэр саад учруулахаар байнга оролдоно. Энэ нь түүний ажил юм. Таны ажил бол өөрийнхээ л замаар явах. Тэрний юу хэлэх нь хамаагүй.

Энэ аймшигтай сонсогдож байна гэсэн шавийн асуултад Их Багш: Зүгээр дээ. Амьдрал угаасаа л аймшигтай шүү дээ. Төгсгөл нь үргэлж үхлээр төгсөнө. Та авшигтан юм чинь Багшаар үргэлж хамгаалуулна. (Танхимаас асууж байна: “Энэ нь бидний хайрладаг болон ойр дотны хүмүүст ч гэсэн хамаарах уу”).

Их Багш: Мэдээж хэрэг. Багш бүгдийг нь анхааралдаа авах болно. Энэ нь Авшиг хүртсэн байхын ач гавьяа юм. Үүнийг мэдсэн та талархалтай үхэх бөгөөд энэ Авшиг гээч зүйл ямар аугаа шагнал вэ гэж мэдэхдээ балмагдах болно. Энэ бол үнэхээрийн гайхамшиг. Ямар гайхамшигтай гэдгийг би үгээр тодорхойлон илэрхийлж чадахгүй байна. Би зөвхөн таны төлөө



л баяртай байж чадна. Та үнэхээр азтай, тийм ээ, их азтай. оюунлиг оршинолууд буюу сахиусан тэнгэрүүд, эс бөгөөс сүйтгэгчид (Орчлонгийн янз бүрийн хязгаар оронд амьдрагсад) байдаг. Тэд нэг л өдөр үхдэг бол та үхэхгүй. Тэд доошилно, харин та тэгэхгүй. Та бүх цагийн туж тэдний хажуугаар өнгөрч, улам алдаршиж, улам гоо сайхан болж, тэднээс хавигүй өндөрт дээш явж байх болно. Тэднийг гурван ертөнц дотор аргаа олж ядан байхад та харин Бурханы дэргэд байна.

## **ХАЙР**

*Үзэх: Хайрлиг чанар*

Хайр бол орчлонгийн хамгийн аугаа хууль. Хайрлаж сурахгүй бол маш олон зүйлээр гачигдах болно. Хайраар ажиллаж хийж байхад бүх юм танд аяндаа хүрч ирнэ.

Багшийг хайрлах хайр бол хувиршгүй, зөвхөн өөрчлөгдөн хөгжиж байдаг. Эхэндээ Багшийнхаа биеийг хайрлана, харин хожим биеэрээ байх үгүй нь хамаагүй бүхнийг хайрлах болно. Улам хүлцэнгүй болж, алагчлал үгүй хайрыг улам илүү мэдэрнэ. Хайрлаж байна гэдгээ мэдэлгүйгээр хайрлах болно. Бүр аяндаа ийм таатай сайхан байх болно. Та юуг ч хайрласан намайг л хайрлаж байгаа хэрэг. Багшийн дэргэд байхдаа өөрийгээ өөрийгөө нэн чөлөөтэй, илүү хөгжингүй, улам итгэлтэй болж, үнэ цэнээ бүр сайн ойлгоно. Та энэ хүнийг өөрт тань хэзээ ч хор хүргэхгүй, зөвхөн хүч чадлаа хөгжүүлэхэд тань л тусална, харин хэзээ ч хариу нэхэхгүй гэдгийг мэднэ.

Хэний ч зүрх сэтгэлийг уярааж чадах хайр гэвэл энэ байна. Энэ хайр хэзээ ч үгүй болохгүй, төрөл арилжин нэг амьдралаас нөгөөд шилжих үед алга болдоггүй юм. Та авшиг хүртмэгц үүрд хамт байна. Хаа ч явсан энэ хайр тантай хамт байгааг мэдэрнэ.

Багшийн үл үзэгдэх тэр аугаа гэрэл цангаж ундаассан сүнсэнд маань хэрэгтэй бүхнийг нь, энэ ертөнцийн өгч чадахгүй байгаа бүхнийг өгч чаддаг. Багшийг хэдийчинээ их хайрлана, төдийчинээ их эрх чөлөөтэй болж, урьд өмнө нь мэддэг ч үгүй байсан тал бүрийн эрх чөлөөг олж авна. Урьд нь та нийгэм, үзэл баримтлал, уламжлал заншил, гэр бүлийн уяагаар хүлээтэй байсан хэрэг. Одоо бол ямар ч хүсэл, дадал, ямар ч доорд хүсэл тачаал таныг уяж хүлж чадахгүй. Үйлийн үртэй хутгалдуулдаг доорд хүсэл болох ертөнцийн хайр дурлал ба эрхэм дээд хайрын ялгаа үүнд оршино (ГТХӨБИ, х 116-117).

Төгс бүрэн хайрыг Багш биедээ тээж байдаг. Хайр юм бүхнийг угаан ариусгаж, муу бүхнийг эвдэн нурааж, хил хязгаар бүхнийг уусган сарниулдаг. Хүссэнийхээ хирээр хэрэглэж болох агуу их дотоод хүчийг хайр гэдэг. Гайхамшиг ингэж бүтдэг юм. Учир нь Хайрын хууль нь бусад бүх хууль, түүний дотор Үйлийн үрийн хуулийг ч даван туулж чаддаг. Тийм болохоор Багш хүн өөрт нь итгэдэг хүн бүрийг чөлөөлж, Бурхадын орныг бүхэлд нь нээж, тамын орныг эвдэж чаддаг (2, х 32-33).

Гэгээрэл бол зөвхөн эхлэл юм. Цаашаа болзол нөхцөлгүй, хязгааргүй хайрыг олж авахын төлөө л явах хэрэгтэй (43).

Бурханы төлөө л бясалгах ёстой. Бурханы хайрыг олж авах нь амьдралын маань зорилго (24). Хамгийн дээд хайр бол болзол нөхцөлгүй хязгааргүй хайр юм. Энэ бол жинхэнэ хайр. Хэн нэгний төлөө амиа, өөрийгээ золиход бэлэн тэр үед энэ хайрыг олж авдаг. Хэний ч төлөө амиа өгөхөд бэлэн байдлыг хэлж байна (68).

Бусдыг өөр шигээ хайрладаг бол Будда юмуу Бодисадва болж буй нь тэр. Энэ бол маш өндөр ухамсрын төвшин юм. Бусдыг өөрөөсөө илүүтэй хайрлах гэдэг агуу нууц юм. Энэ нь та хүнийг үү, мал амьтныг хайрлаж байна уу хамаагүй. Бусдын төлөө өөрийгээ золих нь Бодисадва нарын төвшин мөн. Хамгийн чухал юм бол хайр, учир нь Бурхан бол хайр юм. Та хайрлаж л байгаа бол Бурхан мөн (63). Хэн нэгнийг хайрлахдаа түүнд аз жаргал өгч, халамжилж хамгаал.

Энэ бол жинхэнэ аугаа хайр. Хэрэв түүнээс өөртөө хайр халамж хүсэж, оюун санааг нь самууруулан зовоож байвал хайр биш харин үзэн ядалт юм.

## **ХАЙРЛИГ ЧАНАР**

Үзэх: *Хайр*

*Хүн, зарим амьтан, шувууны хайрлиг чанар  
(Их Багш Чин Хай, 2007)*

<b>Хүн, амьтан, шувуу</b>	<b>Хайрлиг чанар, %</b>
<b>Хүн</b>	
Байх ёстой	100
Үүнээс:	
Хүн төрөлхтний дээд хэмжээ	90
<b>Хүн төрөлхтний дундаж</b>	<b>20</b>
<b>Хүн төрөлхтний хамгийн бага хэмжээ</b>	<b>5</b>
<b>Гэрийн тэжээвэр амьтан 80-300%</b>	
Үнээ	300
Адуу	180
Гахай	120
Нохой	110
Тахиа	90
<b>Махчин амьтан</b>	
Халим	300
Дельфин	110
Баавгай	110
Заан	100
<b>Арслан</b>	<b>20</b>
<b>Бар</b>	<b>20</b>

## **ХИЙХГҮЙГЭЭР ХИЙХ**

Үзэх: *Анагаахгүйгээр анагаах*

Хийхгүйгээр хийх гэдэг нь амьдрахгүй, сэтгэхгүй, сэтгэлгүй байх гэсэн үг биш. Харин аливааг аяндаа хийнэ гэсэн үг. Үүнээс хойш та шийдвэр гаргахгүй болно гэдэг нь үнэн. Та гагцхүү Бурханы хүсэл зоригт зохицуулан хийж, яах ёстойгоо яг таг мэднэ. Хөндлөнгөөс харахад бусадтай адил хийж байх мэт боловч угтаа үйлдэл бүрийг тань Бурхан хэлж өгөх болно. Цаашид танд хариуцлага гэж байхгүй болж, та хэзээ ямагт чадлаараа л хийдэг болно.

Гэхдээ энэ нь аливааг бодож сэтгэхгүйгээр хийж буй хүн бүр Бурханы хүсэл зоригийг биелүүлж байна гэсэн үг биш. Яагаад гэвэл тэд Бурханы хүсэл зорилгыг мэдэхгүй. Гэгээрсний дараа л бид Бурханы уг төлөвлөгөөг мэдэх болж түүнд зохицуулан хийнэ. Гэгээрэхээс өмнө бол Бурханы төлөвлөгөөнд өөрийнхээ хүсэл зоригийг тулгах гэж оролдоод юмыг эмх цэгцгүй байдалд оруулж байдаг” (2, х 95).

Би тусгайлан юу ч хийдэггүй. Бурханы таалсан, сонгосон хэн хүнд Бурхан тийн үйлдэхэд нь би саад болдоггүй. Намайг хараад эмчлэгдсэн гэж гэж боддог хүмүүст би: “Энэ чинь Бурхан таныг таалсан хэрэг шүү дээ. Би бол зөвхөн хэрэгсэл. Бурхан эмчлэхээр сонгосон хүндээ адислалаа надаар дамжуулж хүртээдэг юм” гэж хэлдэг (11, х 174).

Бурхан бодьсад юу ч хийсэн ялгүй. Учир нь тэр барилдлагыг нэвт шувт үзэж, тодорхой мэдсэн болохоор үйл үрийн хүрээнд орохгүй.

Гэвч хамаг амьтан үүнийг мэдэхгүй, тэд өөрөө хийсэн гэж боддог тул үйл түйтгэр бий болдог (3, х 155).

Хэрэв бусдын төлөө юу хийснээ өөрөө өөртөө дахин сануулсаар байх юм бол та жинхэнэ хувиа бодолгүй өгч үйлчилсэн биш, харин энэ дэлхийн нэг наймаачны адил ердөө бизнес эрхэлж байгаа гэсэн хэрэг.

### **ХООСОН ЧАНАР**

Хоосон чанар бол Нирваан. Бүх хүсэл, эрэл, идэвхийллээс хоосорч чөлөөлөгдсөн гэсэн үг. Нирвааны эрэл хүсэл ч замхран арилсан төлөв (Хоосон чанар, БНСУ, WOW 757).

Хүмүүн бид чинь:

- энэ бие цогцос ч биш, сэтгэл ч биш.
- Хийж буй зүйл, сурч буй зүйл маань ч бид биш.
- Толгойгоо эргүүлүүлж өөрсдийгээ гээд итгэчихсэн зүйл ч бид биш.
- Хэрэв өөрсдийгээ ийм маягаар ойлгох юм бол бидэнд угтаа оршихуй байхгүй юм (2, х 145).

Гагцхүү дотоодод маань юу ч үгүй хов хоосон болох үед Эзэн Бурхан бидэнд билиг ухаан болон хайрыг цутгаж өгөх юм. Бидэнд юм бүхэн байна, гэвч бид юу ч үгүй болно. Яг хоосон сав шиг хирнээ дотор нь Бурханы билиг ухаан дүүрэн агуулагдах болно (6, х 379).

Гэгээрснийхээ дараа би ертөнцийн хамаг амьтан бие биетэйгээ шүтэн барилдсаныг олж харсан билээ. Бидний мөн чанар нэгэн ижил, бид бүгдээрээ нэгдмэл юм. Би үүнийг ном судраас уншсан юм биш, Би үүнийг олж үзсэн юм (2, тал 154).

Үнэндээ бол ертөнцөд оршин байдаг зүйл гэж нэгээхэн ч үгүй. Энергийн бөөгнөрөл болон хайрын орон зай л гэж байдаг, тэр нь заримдаа янз бүрийн хэсэгт хуваагддаг. Энэ нь цахилгаан гүйдэл нь чийдэн, дамжуулагч утас, микрофон гэх мэт өөр өөр зүйлд оршдогтой адил юм (2, тал 53).

Арьяабалын номын цогцыг бясалгахад аливаа бодис хоосон чанартай, чих, нүд, бодол биеийг хэрэглэхгүй, төрөхгүй устахгүй, хиртэхгүй, ариутахгүй юм (6, х 60).

### **ХУВААЛЦАХ**

Үзэх: Өглөг

Хуваалцах-энэ бол илүү их үр тарьж буйтай адил. Үр улам ихээр ургах болно. Заримыг нь эргүүлэн авна, тарьснаасаа ихийг хураана. Дахин, дахин тарих гэж дараагийн ургацандаа зориулж үлдээнэ. Та хэзээ ч алдахгүй. Бүх юмаа алдлаа ч гэсэн ердөө ч харамсах хэрэггүй. Учир нь та энэ дэлхийд юу ч үгүй ирсэн. Та юу ч алдаагүй. Энэ

дэлхийд ирснээсээ хойш та маш ихийг олсон. Энд юу ч авчраагүй атлаа юм бүхнийг олоод хожоод л байна. Том хүн болтлоо өсөж бойжоод энэ дэлхийгээс хожиж, олон зүйлийг авч байна. Тэгэхээр бүх юмаа алдсан байлаа ч тэр чинь энэ дэлхийн юм, угаасаа таных биш.

### **ХҮЛЦЭНГҮЙ БАЙХ**

Хүлцэлгүй байх нь өөрөө ном болж хувирахыг хэлнэ (Гүрү Амар Дас Жигийн тухай ярьсан 2013 оны бичлэг).

### **ХҮН**

Үзэх: Амьдрал, Зовлон, Хоосон чанар, Гэтлэгдэх, Нинжин, Хайрлиг, Эрхэм ариун чанарууд

Бид бол Бурхад юм. Бүх төрөлтний ээж, аав нь бид юм. Иймд өөрийн бурханлиг амьдралын сонголтоо хүндэтгэх хэрэгтэй. “Бусдыг шүүмжлэх хэрэггүй” гэж Иус сургасан. Яагаад гэвэл бид бусдын сонголтыг мэдэхгүй. Яагаад гэвэл тэд зан авир муутай юмуу үгээгүй ядуу, муу хүн шиг төсөөлөгдөхөөр сонголт хийсэн байж болно. Бид гэрэл, аялгууны Арьяабалын бясалгалаар бясалгах гэж хүн болж төрсөн. Бид аугаа их билэг ухаан, гэгээнтний дэсэд хүрэх л гэж хүн болж төрсөн. Бидний эцсийн бөгөөд хамгийн үнэтэй, зөвхөн ганц тохиох боломж бол энэ юм. Арьяабалынхаас бусад бясалгал нь биднийг 3 ертөнцийн дотор л барьж байдаг юм. Арьяабалын бясалгал нь биднийг 3 ертөнцийг давуулах цорын ганц арга юм (54). Ертөнцийг шүүмжилж, хүмүүсийг засах гэж оролдсоор бүр залхаж ядарсныхаа эцэст миний засаж залруулах хүн нь би өөрөө юм байна гэдгийг ойлгосон (2, тал 39).

Бурхан гэдэг бид болохоос өөр юу ч биш юм (2, х 16). Мөнх амьдрал гэдэг хүмүүс бид өөрсдөө юм, билгүүн ухаан гэдэг бидэнд буй юм, хайр бол бидний уг чанар юм (2, х 18). Хүмүүсийн олонх нь гэгээрэхгүй, чөлөөлөгдөхгүй байгаагаас дэлхийн хүн ам өсч байна. Мөн тамын амьтад энд хүн төрөл авахын тулд дээш мацаж байна. Мөн амьтны ертөнцөд амьтныхаа хувьд өр төлөөсөө гүйцээхээд эргэж хүн болж буй амьтад байна. Үүнээс гадна хэдэн мянга, зуун жилийн дараа хүн болж төрдөг сахиусан тэнгэр, диваажингийн төрөлтнүүд байна. Ийм учраас хорвоо үргэлж хүн ихтэй байгаа юм (2, х 53).

Гагцхүү бурханлигийг ойлгож ухаараг л гэж бид бүхэнд хүмүүний амьдрал заяагдсан юм (2, х 53).

Хүн бол энэ орчлон ертөнцийн хамгийн аугаа бүтээл, тэнгэр элчсээс ч илүү. Тийм болохоор биднийг уужуу сайхан, гэгээрсэн үед тэнгэр элчүүд биднийг хүрээлж, хамгаалж, бидэнд үйлчилж байдаг юм.

### **Хүний амьдралын үнэ цэн (73)**

Хүний амьдрал үнэ цэнтэй гэж бид бүгд сонссон. Будда айлдсан нь: “Яст мэлхий далайн ёроолоос гадаргууд гарч ирэх бүх замыг туулаад хартал нэг модны хэлтэрхий таарсаны нь дундаа нүхтэй байжээ. Чухамхүү энэ нүх бол хүн буюу хүн болж төрөх хувь заяа юм”. Үүнийг сонсдог хэдий ч ямархан үнэ цэнтэйг нь төдийлэн сайн ойлгодоггүй. Энэ үнэ цэнийг би математикаар дүрсэлье. Диваажинд хэн нь хэн бэ гэдгийг тогтоох онооны ангилал байдаг юм.

Хүмүүс бид маш үнэ цэнтэй юм шүү (73).

<b>Хүний төрлийг олж авахад: 9,2 зиллион зиллион оюун санааны оноо шаардлагатай*</b>	
100 наслахад	нэмж 20 зиллион зиллион
Орчлонгийн ухамсрын 3-р төвшинд хүрэхэд	400 зиллион зиллион
Тэрбумтан бус ердөө саятан болоход	тухайлж 300 000 зиллион
Амьдралынхаа турш эрүүл байхад	нэмж 350 000 зиллион
Оюун санааны ялагдашгүй чанарт хүрэхэд	нэмж 60 000 зиллион
Хаан юмуу хатан болоход	нэмж 70 0 000 зиллион

Ерөнхийлөгч болоход	нэмж 530 000 зиллион
Хан хүү юмуу гүнж болоход	нэмж 460 000 зиллион
Эйнштейн шиг 150 IQ оюуны итгэлцүүртэй болоход	нэмж 220 000 зиллион
Сайхан төрөхөд	нэмж 200 000 зиллион
Сайхан дуу хоолойтой төрөхөд	нэмж 183 000 зиллион
Дэлхий, эргэн тойрныхоо хүмүүстэй сайн харилцаатай байхад	нэмж 270 000 зиллион
Энх амгалан улс оронд төрөхөд	нэмж 240 000 зиллион
Сайн ханьтай учрахад	нэмж 230 000 зиллион
Сайн үр хүүхэдтэй болоход	нэмж 350 000 зиллион
Нэрд гарах, алдар цуутай болоход	нэмж 170 000 зиллион

*\*Их Багшийн тодотгол: сая саяар яригдах тооны цаана тооны ямар нэгж байдгийг сайн мэдэхгүйн учир Би бээр “сая сая” буюу “зиллион зиллион” гэж нэрлэсэн болно.*

### **ХҮСЭЛ**

Энэ дэлхий дээр бид хэт тэвчээргүй байж болохгүй. Ямар нэг зүйлийг хүсвэл түүнийгээ хүсэхгүй байхыг хичээх хэрэгтэй. Тэгвэл тэр зүйл биднийх болно. Энэ их хачин. Юмыг хэдий их хүснэ, тэр юм төдий чинээ холдох болно. Гэгээрэл болоод Үнэний хутгийг олоход ч мөн адил. Ямар ч тохиолдолд адгаж сандран, өөрсдийгөө Гэгээнтэн болгоодох гэж Бурханд тулгах хэрэггүй (1, х 418).

### **ХҮСЛЭНГҮЙ БАЙХ**

Хүслэнгүй байх гэдэг нь амьдралын хамаг бүхнийг үзэн ядахын нэр биш, харин тэдгээрт сэтгэлийн хүлээсгүй байхыг хэлнэ. Энэ бол хүсэл шуналгүй байдал юм. Гэхдээ энэ нь таныг амьдралд оролцож мөнгө төгрөг олохгүй бай гэсэн үг биш. Бидэнд таалагддаг юм гэж бий, хайрладаг, гамнадаг, арчилдаг юм гэж бий, гэхдээ тэдгээрт сэтгэлийн хүлээсгүй байх юм (2, х 151).

### **ХҮЧ ЧАДАЛ**

Хэрвээ бид бясалгах үедээ бүх анхаарлаа нэгэн цэг дээр төвлөрүүлээд, түүнийхээ өмнө хамаг асуудал бэрхшээлээ тавьж чадвал тэр бүхнийг агшин зуур шийдэж чадна. Бидний хүч чадал агуу их. Харин үүнийгээ хэзээ ч ашигладаггүй. Хэрвээ өөрсдийнхөө хүч чадал дээр төвлөрч, түүнийгээ ашиглахгүй юм бол, ерөөсөө ямар ч хүч чадал байхгүй мэт санагдах болно.

### **ЧӨЛӨӨЛӨГДӨХ**

Үзэх: Гэтлэгдэх

### **ЧИНАГУУХ ЕРТӨНЦ**

Шашны янз бүрийн бичиг зохиол хийгээд Ариун судруудад тэнгэрийн долоон орон, ухамсрын өөр өөр түвшин, бидний дотоодод байх Бурханы орон, Бурхан чанар... зэрэг нь оршин байдаг тухай дурдсан байдгийг бид цөм сонсож байсан билээ. Эд бүхэн бол энэ ертөнцийн чанадад л байдаг хэмээх зүйлс юм. Гэвч эдгээр Ариун сударт амласан зүйлст тийм ч олон хүн хүрч чаддаггүй юм. Олон биш шүү. Ер хэн ч чаддаггүй гэж хэлж болохгүй боловч тийм ч олон хүн хүрдэггүй юм. Дэлхийн хүн амын тоотой харьцуулбал дотоодынхоо Бурханы оронд буюу “Чанагуухи ертөнц” гэгддэг зүйлд хүрсэн хүн үнэндээ маш цөөхөн юм.

За, тэгэхээр, Бурханы оронд юу байдаг хэрэг вэ? Бидэнд энэ ертөнцөд өчнөөн хэрэг явдал, ажил төрөл, тав тухтай гэр орон, элгэмсэг дотно хүмүүс байсаар байтал юунд Бурханы орны тухай санаагаа зовоох ёстой вэ? Чухамдаа гэвэл бидэнд энэ бүхэн аль хэдийнээ байгаа учраас л бид Бурханы орны тухай бодох хэрэгтэй байгаа юм. Бурханы орон гэж ярихаар – энэ үг дэндүү шашин суртахууны шинжтэй сонсогддог. Гэтэл энэ бол үнэн хэрэгтээ дээд ухамсрын нэг түвшин төдий юм. Эрт цагт хүмүүс үүнийг диваажин гэдэг байв. Шинжлэх ухааны нэр томъёогоор бол үүнийг өөрөөр-мэдлэгийн үлэмж дээд түвшин, билиг ухааны өндөр дээд шат гэж тодорхойлж болно. Тийм болохоор арга замыг нь мэдчих юм бол бид ч гэсэн үүнд хүрч чадах юм.

Жинхэнэ үнэн зүйлс нь хэдийгээр энэ ертөнцийн чанадад байдаг ч хэрэв түүнтэй холбогдохыг хүсвэл хэн ч хүрч болохуйц зүйл юм. Энэ бол дотоодын тэнгэрлиг Хөгжим, дотоодын тэнгэрлиг Аялгуу юм. Энэ Эгшиг хөгжим..., дотоодын Гэрэл гэгээ болон дотоодын Дуу Аялгууны хүчний түвшнөөс хамааран бид өөрийгөө энэ ертөнцийн зааг хязгаараас түлхэн гаргаж, үлэмжийн гүн гүнзгий ухамсрын түвшинд хүрч чадна. Гэхдээ ямар ч дуу чимээ гаргалгүй, нэг их түвэг удалгүй, тохь тух алдуулалгүй, зардал мөнгө ч шаардалгүй “үүнийгээ” хийдэг юм. Энэ бол чанагуухи ертөнцөд хүрэх арга мөн.

Чинагуух ертөнцийн юу нь манай ертөнцийнхөөс илүү байдаг вэ? Бидний төсөөлж чадах болон эс чадах юм бүхэн нь илүү.

Манай ертөнцийн чанадад өөр олон ертөнц бий. Манай ертөнцөөс арай дээгүүр оршдог нэг ертөнцөөр жишээлье. Барууны нэр томъёогоор түүнийг “Одот ертөнц” (Astral world) гэдэг. Одот ертөнц нь зуу гаруй ялгаатай түвшинтэй бөгөөд түвшин бүр нь дангаараа нэгэн ертөнц болно. Энэ ертөнц бүр нь бидний ойлголтын түвшинг харуулж байдаг. Асурийн ертөнцөд бид увдис шид гэж нэрлэдэг олон гайхалтай зүйлийг үзнэ. Биднийг мөн ид шидээрээ гайхуулан татаж ч мэднэ, бид ч өөрсдөө бас ид шид үйлдэж чадах магадлалтай. Бид өвчтэй хүнийг эмчилж, бусад хүний нүдэнд харагдахгүй зүйлийг олж үзэж чадна. Наад зах нь зургаан төрлийн ид шидийн хүчтэй болж, ердийн саад хоригийг даван далдыг харж, орон зайнаас үл хамааран юмсыг сонсож чадна. Бидний хувьд хол ойрын ялгаа үгүй болох бөгөөд үүнийг бид тэнгэрлиг үзэхүй, тэнгэрлиг сонсохуйгаар онох хэмээн нэрлэдэг юм. Тэр цагт бид хүний бодлыг нэвт харж, заримдаа хүний санаа сэтгэлд юу байгааг үзэж чадна.

Бурханы орны Нэгдүгээр Төвшинд хүрэхэд бидэнд дээрх боломж чадвар нээгдэж болдог. Нэгдүгээр Төвшний цаад талд өөр олон түвшин байх бөгөөд тэдгээр нь үг хэлний дүрслэн өгүүлэх бололцоо чадамжаас хэтийдсэн байдаг. Авшиг хүртсэний дараа үргэлжлэн бясалгасаар бидний зэрэг дэс нэгдүгээр түвшинд хүрвэл бид илүү олон чадвартай болно. Тэгэхэд урьд нь бидэнд огт байгаагүй уран зохиолын авьяас билиг хүртэл бий болно. Түүнчлэн бид бусад хүний мэддэггүй өдий төдий юмсыг мэддэг болж, Оройн Дээд Их Бурхан тэнгэрээс заяаж уу гэмээр олон зүйл бидэнд олдох болно. Тэр нь зарим үед санхүүгийн амжилт, зарим үед албан тушаал ч байх юм уу өөр бусад зүйл байж болдог. Мөн бид шүлэг найраг бичих чадвартай болох юм уу уран зураг зурж, урьд өмнө хийх нь байтугай хийж чадна хэмээн төсөөлж ч чадахгүй байсан олон зүйлийг хийж чаддаг болно.

Энэ бол Нэгдүгээр Төвшин. Бид гайхалтай найруулга сайтай ном бичиж, шүлэг зохиож болох юм. Урьд өмнө нь мэргэжлийн түвшинд зохиол бичиж чадахгүй байсан бол одоо харин чадах жишээтэй. Эдгээр зүйл бол ухамсрын Нэгдүгээр Төвшинд хүрэхэд бидэнд олддог материаллаг ач тус нь юм. Үнэн хэрэгтээ бол эдгээр нь Оройн Дээд Их Бурханы бэлэг биш. Энэ бүхэн нь бидний доторх тэнгэрлиг ертөнцөд оршиж байдаг бөгөөд бид тэднийг урин дуудсаны улмаас тэдгээр нь сэрж сэргэчхээд байгаа хэрэг. Тэгээд бид тэр бүгдийн ашиг тусыг хүртэх боломжтой болно.

“Хоёрдугаар Ертөнц” гэж нэрлэсэн Хоёрдугаар Төвшинд бид нэгдүгээр ертөнцийнхөөс ч илүү нэн их авьяас чадвар, түүний дотор ид шидийн хүчинтэй болж болох юм. Гэхдээ Хоёрдугаар Ертөнцөд хүрээд олж авдаг авьяас чадваруудын дотроос хамгийн гайхамшигтай нь – уран илтгэх урлаг болон маргах чадвар юм. Хоёрдугаар Ертөнцөд хүрсэн хүний оюун ухааны хүч чадал оргилдоо хүрч, гайхалтай уран илтгэх чадалтай болсон байдаг тул хэн ч түүнийг давж дийлэхийн аргагүй мэт санагдана. Энэ нь зөвхөн бие махбодын уураг тархи илүү хөгжсөнд биш, бидний дотоодод угаас байдаг нууцлагдмал Хүч, төрөлхийн билгүүн ухаан, тэнгэрлиг Хүч чадалд оршиж байгаа юм. Одоо тэр нь нээгдэж эхэлсэн хэрэг. Энэтхэгт энэ түвшинг “Буддхи” гэж нэрлэх бөгөөд энэ нь “оюун ухаанлиг түвшин”-г илтгэдэг. “Буддхи”-д хүрвэл та Будда болно. “Будда” гэдэг үг нь эндээс гаралтай юм. Тэгэхээр Будда гэдэг нь чухамдаа үүнийг илэрхийлдэг байх нь. Ихэнх хүмүүс гэгээрсэн хүнийг Будда гэдэг. Хэрвээ тэр хүн хоёрдугаар ертөнцөөс дээш оршихуйг мэддэггүй бол үүгээрээ их бахархана. Өөрийгөө үнэнээсээ амьд Бурхан гэж бодно. Хоёрдугаар Ертөнцөд хүрч аль дуртай хүнийхээ өнгөрсөн, одоо, ирээдүйг нэвт үзэж, дээд зэргийн уран илтгэх чадвартай болсон нь Бурханы оронд хүрэх зам мөрийн эцэс төгсгөл биш. Хэн нэгэн хүн өнгөрсөн, одоо, ирээдүйг үзэж мэдэх чадвартай бол түүндээ онгирч бардамнах ёсгүй, учир нь энэ бол Барууныхны ярьдаг Акашийн мэдээллийн сан (Akashic record) юм. Та нарын дотроос йог юм уу аль нэгэн бясалгал хийдэг хэн нь ч гэсэн Акашийн тэмдэглэл гэдэг нь бүх төрлийн хэлтэй номын сан маягийн зүйл гэдгийг ойлгоно. Хоёрдугаар Төвшинд хүрсэн хүн бол өөрийнхөө намтрыг мэддэгийн адилаар бусад хүний төрх төлвийг ойлгож, тов тодорхой тайлж чадна.

Ухамсрын Хоёрдугаар Төвшингөөс олж авах зүйл үүнээс хавьгүй их юм. Гэхдээ “Буддхи” буюу оюун ухаанаа нээчихсэн учраас хэн нэгэн хүн Хоёрдугаар Ертөнцөд хүрэх нь хэдийнээ гайхамшигтай явдал, амьд Бурхан болсон хэрэг мөн билээ. Энэ үед бид нэрлэж ч чадахгүй олон зүйлийг мэддэг юм. Оюун ухаан маань нээгдэж, амьдралаа амар амгалан, илүү сайн сайхан болгохын тулд эмчлэн анагаах, эвсэн зохицохуйн дээд эх сурвалжтай яаж холбогдохоо бид мэдчихсэн байдаг тул хүссэн ч, хүсээгүй ч ид шид хэмээгч тэр бүхэн бидэнд тохиолддог юм. Бидний урьд өмнө буруу хийсэн зарим зүйлийг засч залруулж, дахин гаргуулахгүй байхад зайлшгүй хэрэгтэй өнгөрсөн үеийн хийгээд одоогийн мэдээлэл рүү нэвтрэх гэж бидний оюун ухаан буюу “Буддхи” нээгддэг юм.

Хоёрдугаар Төвшин мөн олон дэд төвшинтэй. Та бүхэн энэ зам мөрийг нэгэнт туулчихсан Багштай хамт аялавал та нарыг дагуулж яваад гэрт тань хүргэж өгснөөр л зогсдог юм. Заримдаа үүнд бүх амьдрал шаардагдана. Гэхдээ гэгээрэл бол агшин зуур ирдэг. Тийм боловч энэ бол зөвхөн эхлэл юм. Хөрш гариг маань ямар болохыг, түүн дээр хүмүүс хэрхэн аж төрдөгийг үзэхийн тулд энэ ертөнцөөс цаанах өөр өөр ертөнц рүү явж яагаад болохгүй байх билээ. Энэ нь ердөө л арай алсхан аялах, энэ биеэрээ аялахын оронд сүнсээрээ, оюун санаагаараа аялах төдий л юм. Гэвч эндхийн орон зай нь пуужингаар, нисдэг таваг- нисдэг үл мэдэгдэх биет /НҮМБ/- ээр нисээд ч туулан гарах аргагүй тийм аварга том ертөнцүүд ч байдаг. Бидэнд аль нэг НҮМБ-ээс ч хурдан нисэж чадах чадвар байдаг. Энэ чадвар бол бидний дотоод сэтгэл. Бид үүнийгээ бас сүнс гэдэг.

Сүнсээ түшиглэж нисвэл шатахуун хэрэглэхгүй, замд саад тотгор тохиохгүй, цагдаа ч тааралдахгүй. Сүнс хэрэгцээгээ өөрөө хангадаг тул өөр юуны ч хэрэг үгүй. Бид өөрсдөө л ертөнцийн хуулийг зөрчиж, тэнгэр газрын зохицлыг эвдэх тохиолдлуудыг эс тооцвол сүнс маань хэзээ ч гэмтдэггүй юм. Энэ ертөнцийн гадна, биет ертөнцийн чанадад бол ямар ч хууль байдаггүй. Бид чөлөөтэй, эрх чөлөөт иргэд, гэвч энэ эрх чөлөөг олж авахын тулд чинагуух ертөнцөд хүрэх ёстой. Гэхдээ бид энэ дэлхийд ертөнцийн хуулийн хүрээнд орших хэрэгтэй. Ингэж чадвал бид нисэх төхөөрөмжөө гэмтээлгүй нэн түргэнээр, нэн өндөрт саадгүй хүрч чадах юм. Эдгээр нь маш энгийн бөгөөд бид хүмүүст “гай учруулж болохгүй, амь хороож болохгүй, садар самуун байж болохгүй, хулгай хийж болохгүй, мансууруулах бодистой зүйл хэрэглэж болохгүй, бүх төрлийн мөрийтэй тоглоом, дэнчин тавих гэх мэт оюун санааг маань

бие махбодын цэнгэлд татаж, оюунлагийг эрэлхийлэх сүнсний аяллаа мартуулахад хүргэдэг зүйл хэрэглэж болохгүй”. Ердөө л энэ. Бид их хол, пуужингаас ч хол, НҮМБ-ээс ч хурдан нисэхийг хүсч байгаа болохоор хичнээн их анхаарал болгоомжтой байх ёстой билээ. Бие цогцос маань бид эндээс шинжлэх ухаанлаг билиг билгүүний нэн өндөр түвшин болох мөнхийн ертөнцөд нисэн хүрэхдээ хэрэглэх унаа хөсөг юм.

Бидний бие цогцос дотроо бидний Багш- (дотоодын эзэн)-ийг агуулж байдаг тул асар их үнэ цэнтэй зүйл юм. Бидний дотоод талд илүү гоо сайхан, илүү эрх чөлөө, илүү эрдэм мэдлэг оршиж байдаг билээ. Бид түүнтэй нэвтрэлцэх үнэн зөв арга замыг мэдэж чадвал энэ бүхэн дотоодод маань оршиж байдаг болохоор тэр бүхэн цөм биднийх юм. Бид харин түлхүүр нь хаана байгааг мэддэггүй, “байшингаа” удаан хугацааны турш цоожлоод орхичихсон болохоор дотор нь бидний үнэлж баршгүй эрдэнэс буйг мартчихсан хэрэг. Ердөө л энэ. Харин төгс гэгээрсэн Багш гэдэг бол тэрхүү хаалгыг нээхэд бидэнд тусалж, угаасаа биднийх байсан тэр бүхнийг харуулж өгдөг нэгэн билээ. Бид харин цаг зав гарган, тийшээгээ орж, өөртөө байгаа юмсыг нэг бүрчлэн шалгаж үзэх хэрэгтэй.

Гуравдугаар Ертөнц гэдэг бол ахисан дээд шат мөн. Гуравдугаар Ертөнцөд хүрье гэсэн хүн наад зах нь энэ ертөнцийнхөө өр төлөөсөөс бүрэн салсан байх ёстой болдог. Хэрэв бид энэхүү материаллаг ертөнцийн эзэнд ямар нэг өр төлөөстэй бол дээш дэвшихийн аргагүй. Хэрэв та аль нэг улсын хууль ёсыг зөрчсөн, нэр төр цэвэр биш бол өөр улс орны хилийг давж чадахгүйтэй адилхан. Энэ ертөнцийн өр төлөөс нь бид бие махбодын амьдралын өнгөрсөн ба одоогийн төрөлдөө хийсэн үйлээс бүрддэг бөгөөд мөн ирээдүйд хийх үйлийг ч багтааж мэднэ. Гаалиар байцаагдан нэвтэрдгийн адил чанагуухи ертөнцөд очихын өмнө тэр бүхнийг төлж барагдуулах хэрэгтэй болно. Хоёрдугаар Ертөнцөд байх үеэсээ л урьд төрлийнхөө болон энэ төрлийнхөө үйлийн үрийг төлж эхлэх хэрэгтэй. Урьдын амьдралын үйлийн үр гэж үгүй байсансан бол бид энэ төрөлдөө амьдрах ёсгүй билээ. Ингэхлээр, хэрвээ бид гуравдугаар ертөнцөд дэвшье гэвэл байгаа бүх үйл түйтгэрээ ул мөргүй арилгах хэрэгтэй. Үйлийн үр гэдэг нь “Юу тарина, түүнийгээ л хурааж авах” хууль юм. Та Хоёр, Гурав, Дөрөвдүгээр ертөнцийн тухай ярих юм. Та үүнийгээ яаж нотлох юм бэ гэж та нар асууж болох юм. Би үүнийг нотолж чадна. Хэрэв та нар надтай хамт чухам яг тэр замаар явбал миний үзсэн тэр зүйлийг олж үзнэ. Дэлхий даяарх зуу зуун мянган шавь нар маань үүний нотолгоо билээ. Тиймээс бид мэдэж байгаа зүйлсээ ярьж чадаж байгаа юм.

Дөрөвдүгээр Ертөнц бол нь ер бусын гайхамшигтай гэдгээр ч хязгаарлагдахгүй. Энэ ертөнцийн тухай энгийн хүмүүст эгэл жирийн үг хэлээр өгүүлэх нь тэр ертөнцийн эзнийг гомдоох байх гэж зүрхшээж байна. Учир нь энэхүү ертөнц нь маш үзэсгэлэнтэй, харин зарим газраа харанхуй байдаг. Нью-Йорк хотын цахилгаан тасарсан шөнөөс ч илүүтэй харанхуй. Тэнд түүнээс ч илүү харанхуй. Гэрэл гэгээнд хүрэхийн өмнө түүнээс ч их харанхуй байдаг. Ямар нэг хориотой хот мэт. Оройн Дээд Их Бурханыг таньж хүрэхээс өмнө биднийг тэнд зогсооно. Гэвч Багштай, туршлагатай Багштай хамт яваа бол бид түүнийг нэвтрэн гарч чадна. Эс бөгөөс бид тиймэрхүү ертөнцөд төөрөх болно. Оршихуйн янз бүрийн давхарга, төвшинг туулан гарах үедээ зөвхөн оюун санаа маань өөрчлөгддөг төдийгүй бие махбод, оюун ухаан, амьдрал дахь бүх зүйл хувирч өөрчлөгддөг юм. Бид ертөнцийг өөрөөр харж, өөрөөр алхаж, өөрөөр ажиллаж эхэлдэг. Амьдралынхаа учир зорилгыг ойлгож мэдээд цаашдаа хий дэмий бухимдаж шаналахаа болино. Харин амьдарч байх хугацаандаа бид дараа нь хаа очихоо хэзээд мэдэж байх тул Газар Дэлхий дээр ирсэн томилолтоо дуусахыг тэвчээртэй, эв найртай хүлээх болно. Үүнийг “Амьдрах зуураа үхэх” гэдэг.

Дөрөвдүгээр Ертөнцийн дараа илүү өндөр түвшин болох Тавдугаар Ертөнц буюу гэгээрсэн Багш нарын оршдог нутагт очно. Гэгээрсэн Багш бүхэн тэндээс ирдэг. Тэдний зэрэг дэс нь Тавдугаар Ертөнцөөс өндөр байсан ч тэд тэндээ л суудаг. Энэ нь гэгээрсэн Багш нарын гэр юм. Түүнээс гадна тэнд ухаж ойлгоход хэцүү маш олон талын чанар илэрнэ. Тавд очсоны дараа та



дуртай тийшээ явж болно. Дээшээ тун олон төвшин бий. Гагцхүү тэнд байхад илүү тохиромжтой, илүү ая тухтай байдаг юм. Түүнээс цааш дээшээ бол хэт хүчирхэг төвшин байдаг гэж хэлмээр юм уу даа. Та түр хугацаагаар очиж болох ч танд тэнд үлдэж амрах хүсэл төрөхгүй байх. Бид үргэлж л хэдий чинээ дээш гарна, төдий их хайр энэрэл байдаг гэж боддог. Гэвч хайр олон янз байдаг. Маш хүч түрэмгий, хатуу хайр ч бий, эелдэг зөөлөн хайр ч бий, алагчлал үгүй хайр ч байдаг. Бидний хүлээн авах савны хэмжээнээс л хамаарна. Оройн Дээд Их Бурхан бидэнд янз бүрийн хэмжээний хайр өгдөг. Ертөнц бүр Оройн Дээд Их Бурхны хайрыг янз бүрийн хэмжээгээр агуулж байдаг юм. Гэвч заримдаа тэр нь дэндүү хүчтэй, биднийг хэсэг хэсэг болгон цуулан тасчиж байх шиг санагддаг (23).

## **ЦАГААН ХООЛ**

*Үзэх: Веган хоол хүнс*

Цагаан, ногоон хоолтон болох нь Дотоодын Бурхан үүнийг хүсч байгаа учраас тэр юм (2, х 30). Цагаан хоолны дэглэмийг бид зам мөрийнхөө саад барцадыг багасгах болон амины өр төлөөсөнд үл орохын тулд сахиж байгаа юм (1, х 21). Бие, хэл, сэтгэлээ ариун байлгахын тулд цагаан хоолтон байх ёстой. Аврал өршөөлдөө багтаахын тулд биднийг үхэтлээ өлсөж зовохыг шаарддаг тийм Бурхан гэж хаа байдаг юм. Бидний аргаар бясалгах нь маш амархан. Нэгэнт зөв замд орсон болохоор бид хүссэн хирээр элбэг дэлбэг хоол ундтай амьдарч болно (1, х 23). Гэрэл аялгууны бясалгал хийдэггүй хүмүүс аль болох мацаг баривал 3 муу заяанаас зайлж чадна (6, х 271).

Сүнснийхээ төлөө махан хоолыг зольж чадаагүй бол та мөнхийн амьдралаа эхлүүлээгүй гэсэн үг (10). Мацаг хоол дангаараа гэгээрэлд хүргэж, Будда болоход тань тусалж чадахгүй. Гэхдээ мацаг хоолтны ёс нь бүрэн төгс гэгээрэлд хүрэхэд агуу зам мөр болдог юм (2, х 141).

## **ЦЭВЭР АРИУН БАЙДАЛ (maturity)**

Цэвэр ариун байдал бол юу ч хүсэхгүй болохыг хэлнэ (82). Та ядаж ганц секунд үзэл бодол, үг хэл, үйл ажлаараа цэвэр ариун байх юм бол тэр цагт хамаг л сахиус, бурхад, сахиусан тэнгэрс таныг дэмжиж туслах болно. Тэр агшинд ертөнц бүхлээрээ таных болж, орчлон ертөнцийг хаанчлаг хэмээн танд хаан ширээ хүрч ирнэ.

## **ШАВЬ**

*Үзэх: Дэс, Авишигтан*

- Гагцхүү бидний дотор юу ч үгүй хов хоосон болох үед Хан хурмаст бидэнд билиг ухаан ба хайрыг дүүртэл цутгаж өгөх юм. Бид “Би” хэвээрээ байж, хоосорч чадахгүй бол Хан Хурмастын соёрхох хүчийг бүрэн хүлээн авах аргагүй. Энэ бол Төгс Гэгээрсэн багш болох нөхцөл болно (6, х 379).
- Бид эхлээд “Би”байхгүй болж хувираад, үнэ цэнгүй, нэр алдаргүй “зарц” болж хувирах ёстой (6, х 379).  
Исус “Хүүхэд шиг цайлган биш бол Диваажинд хүрч чадахгүй”  
Лууз: “бид эргээд хүүхэд шиг болох хэрэгтэй” гэсэн (6, х 379).
- Нам жим суугаад тархиа 5 минут хоосолж чадвал та нар миний багш боллоо гэсэн үг (6, х 394).
- Би өөрийгөө тэр чигт нь, үзэл бодол, үг хэл, үйл хөдлөлөө, бүх амьдралаа өнгөрсөн, одоо ирээдүйтэй нь Багшдаа даатгасан. Багш минь бүхнийг мэдэж байгаа, тэр учрыг нь олно биз гэж боддогсон. Тиймээс ч би дураараа юу ч хийхгүй, нялх хүүхэд шиг амар амгалан байв (1, х 38).
- Миний нууц гэвэл багшдаа бүрэн итгэсэн итгэл (1, х 40).
- Надад байгаагаас дан ганц чин сэтгэл л байлаа (1, х 20).

- Оюун санааны зам мөрд зориг шулуудсан миний сэтгэлд бодогдох юм, шаардах зүйл, санагдах хүн огт байгаагүй (1, х 20).
- Энэ дэлхийн юунд ч үл хүлэгдэх намайг тэр үед үнэний төлөө амиа өг гэсэн бол өгөхөөр л байлаа (1, х 20).
- Миний нууц гэвэл гэнэн зан минь л байх (1, х 36).
- Багшийгаа санаад хүйтний улиралд ч ууланд гарч, ус гаталж үз л дээ. Өндөр зорилготой байсан надад ая тав тух юу ч биш байсан. Хичнээн хүнд бэрх зам туулсныг минь төсөөлөөд үз дээ. Би Бурханы гэрлийг эрсэн сэтгэлээсээ болоод өөр юуг ч олж үзэхгүйгээр сохорсон байсан (1, х 32-33).
- Ухаарч сэхээрэх хүсэл тэмүүлэл үгүй бол 100 жил бясалгасан ч байдгаараа л байж байна (1, х 32-33).
- Нэгэн үзүүрт сэтгэлийг барих нь зүйтэй. Хэрэв энэ дэлхийн хувьд үхсэн мэт биш бол Оройн Дээд Их Бурханы хувьд амьд байх аргагүй. Бурхан чөтгөр хоёрт зэрэг үйлчлэх боломжгүй (1, х 43).
- Багшийн зааварчилгааг хүндэтгэн дагаж, бие, хэл, сэтгэлээ Багшдаа бүрэн өргөвөл зохино (1, х 41).
- Өөрийгөө хагас зориулчхаад үр дүнд хүрсэнгүй гэж Багшийг буруутгах хэрэггүй. Хагас хугасыг хүсвэл Багш хагас хугасыг л хүртээнэ. Бүгдийг хүсвэл бүгдийг өгнө (1, х 41).
- Энэ дэлхийг бурханы оронд санаж, эргэн тойрныхоо хүмүүсийг Бурхад, гэгээнтэнүүд гэж хандаж, хатуу ч уучлангүй, хайрлавч сэтгэлийн хүлээсгүйгээр харьцах ёстой (1, х 32).
- Багшийнхаа тухай бодсоноор багштайгаа нэг болж, Багш бол та өөрөө юм гэдгийг ойлгоно (1, х 42).
- Багш гэдэг бол таны жинхэнэ мөн чанар юм Хүүхэд шиг ариун сэтгэлтэй байж ямар ч зүйлийг цэвэр ариун, эгэл даруу сэтгэлээр үйлдвэл үнэнд мөдхөн хүрнэ (1, х 30).
- Ганц л хүн дээр төвлөр. Бурханы оронд байгаа ханьдаа үнэнч бай. Үүнийг л үнэнч сэтгэл гэдэг юм (1, х 49).
- Миний явсан замаар замна. Намайг л дуурай.
- Үтэр түргэн дэвшье гэвэл өөрийгөө умартаж, даруу төлөв байж, бусдын хийх дургүй хамгийн бохир гэгдэх ажлыг цөмийг нь хийх хэрэгтэй (1, х 224).
- Бусдын тухай бодохдоо өөрийгөө огт хайхардаггүй бол Бурхан боллоо гэсэн үг (1, х 256).
- Цорын ганц нууц бол бүхнийг огоорч орхих явдал юм (1, х 45).
- Аливаа бүхнийг, аз жаргалыг ч огоорох хэрэгтэй (1, х 54). Юу ч гуйж хүсэмжлэхгүй байвал зохино. Амар амгалан, эрүүл мэнд, амжилт, нэр хүнд, эд хөрөнгө, гэр бүлийн алиныг ч горилж хүсэмжлэх хэрэггүй (1, х 256).
- Өөрийгөө золиослох сэтгэлгүй бол өсч дэвшиж чадахгүй (1, х 256).
- Гэгээнтэн болохын тулд та өөрийгээ, дуртай зүйлээ, илүүд үздэг зүйлээ, дургүйцлээ бүгдийг нь золиослох ёстой (1, х 46).
- Бид олон түмэнд үйлчилж байхад Оройн Дээд Их Бурхан бидэнд бас үйлчилж байдаг. Орчлон хорвоо ийм хууль дээр оршин тогтнодог юм (1, х 281).
- Бие, хэл, сэтгэл тэнцвэртэй, харилцан уялдаатай хөгжих хэрэгтэй (1, х 267).
- Бусдын тусыг бүтээснээр өөрсөддөө тус болж байдаг. Энэ бол сүнсээ ариусган дэвшүүлж, өсч хөгжин гэгээнтэн болох зам юм (1, х 286).
- Бясалгалын минут бүр нь нэг насны амьдралтай тэнцэнэ (1, х 214).

- Оюунлагийг дагуулахад хамгийн гол нь: - зөв үзлийг барих (хамгийн шилдэг зам бол төв үзэл - Дао), - зөв аргаар бясалгах (1, х 110).
- Үнэнийг оноход хамгийн чухал нь
  - Цэвэр ариун сэтгэл
  - Алагчлал үгүй сэтгэл
  - Аз жаргал, зовлон шаналалд ялгаваргүй хандах сэтгэл (1, х 91).
- Энгийн даруу бай, бусдыг бүү шүүмжил (1, х 82).
- Өдөр бүр, боломж гарах бүр бясалгах хэрэгтэй (1, х 245).
- Анхаарал болгоомжгүй байх, бясалгалаараа бардамнах, оюун санааны ертөнцөд түргэн байр суурь эзлэхийг хүсэх нь байж болшгүй зүйл (1, х 72).
- Зүрх сэтгэл нь цэвэр ариун, даруу, ааш зан нь эвдрээгүй, ямар нэг зүйлд хүлэгдэх найдах юмгүй хүн орчлон ертөнцтэй бараг нэгдмэл (1, х 78).
- Хүүхэд шиг үргэлж гэнэн цайлган бай (1, х 89).
- Омог бардам байхын хирээр үнэн ёсноос төчнөөн холдоно (1, х 76).
- Бүхнийг эгэл даруу, цэвэр ариун сэтгэлээр үйлд (1, х 30).
- Инагуух ертөнцөөс хэдийчинээ хамаарна, чинагуух ертөнцөөс төдийчинээ холдоно (1, х 76).
- Сэтгэлээ яг л нохой сургаж байгаа юм шиг сургаж дадуул (1, х 241).
- Зөв аргаар бясалгавал хатуу чанга дэглэм бага зэрэг барьж байна уу, эсвэл тансаг сайханд санаагаараа умбаж байна уу хамаагүй (1, х 252).
- Ажил бүхэн бидний суралцах дэвших арга хэрэгсэл юм (1, х 261).
- Үнэнхүү амгалан, үнэхээр гэтэлсэн гэдгээ онох. Ононо гэдэг оюун ухаанаар ойлгож мэдэхээс өөр хэрэг (1, х 300).
- Минут секунд бүр Бурхан орш. Энэ бол бурханаас таньд тавьж буй цорын ганц шаардлага. Энэ л таны хийх ёстой ганц зүйл (7).
- Юунаас ч зуурах хэрэггүй. Зүгээр л өөрөөрөө, үргэлж болзол нөхцөлгүй, яг нар, сар, тэнгэр шиг агуу бай (7).
- Өөрийн гэх санаа, би хэмээх ойлголт, хувь хүний хувьд хэдийн төлөвшсөн үзэл болон бодлоос чөлөөлөгдсөн бол та бүхнийг огоорогчийн төвшинд хүрчээ гэсэн үг (1, х 26).
- Талархах сэтгэлгүй бол өөрийн аугаа ихийг мэдэж чадахгүй (боть 6, х 379, 393).
- Багштай хамтарч ажилла. Хэдий нэг хувийн ч гэлээ хичээл зүтгэлээс чинь бүх зүйл хамаарна (44).
- Дэс өөрөөс чинь хамаарна. Хэт жижиг, өчүүхэн байх аваас танд ямар ч том зүйл, ямар ч диваажинг өгөөд хэрэглэж чадахгүй. Тиймээс Бурхад Будда нар өөртөө найд, өөрийнхээ чин зоригт түшиглэ гэдэг. Багштай хамтарч ажилла. Өөрсдийн энэ хавчиг явцуу зангаа, мөн бардам зангаа даван туулахгүй л бол хүрэх газраа хүрч чадахгүй. Энэ ганц өөрөөс чинь шалтгаална. Өөрийгээ хянаж, өөртөө ямагт сануулж, сэргэж сэхээрэхгүй л бол туйлын хүнд, бас хамгийн амархан энэ замаар замнах боломжгүй. Энэ зам бол бие даасан хүний явах зам юм (30).
- Багштай хамтарч ажилла. Хэдий нэг хувийн ч гэлээ хичээл зүтгэлээс чинь бүх зүйл хамаарна (44).
- Дадал зуршил, амьдралын хэв маяг, эрэлт хэрэгцээгээ хараад өөрсдийн дэсийг тодорхойлж болно (44).
- Юмсыг хэрхэн ойгож хүлээн авч байгаагаар дэс чинь тодорхойлогддог (1, х 32-33).

- Агуу мөн чанар чинь аливаад хэрхэн зохирч байгаагаас дэс чинь харагддаг. Жижигхэн цонхоор багахан зүйлийг олж харахаас бус бүх ертөнцийг харж чадахгүй. Үүнтэй ижил юмсыг харах ухаарал, хараагаа л тэлэхгүй бол агуу чанар чинь үүрд өчүүхнээрээ үлдэх болно (1, х 32-33).
- Гагцхүү таны хүрэх төвшин нь Үнэнийг хайсан эрэлдээ та хир их итгэл, чин сэтгэлтэй хандаж буйгаас шалтгаалах болно. Хурдан удаан, зөв буруу явах нь таны л сонголт (1, х 32-33).
- Өөрийн агуу сүр жавхлангаа ухаарч мэдэхийн тулд найдах ёстой хүн нь та өөрөө юм. Би зам мөрийг зааж өгнө (1, х 252). Хурдан эсвэл удаан өсч дэвших эрх өөрт тань байгаа (44).
- Бурсан хувраг гэдэг нь Бурхан бодьсад, Архад, Гэлэн, Гэлэнмаа. Багшийгаа даган бясалгаж буй та нар бол Бодьсад мөн (3, х 70).
- Бурхан бодьсад гэдэг нь дотоод хувиралт, далд ухамсрын хувиралт, сүнсний хувиралт, зэрэг дэсийн хувиралт, билэг нэгэнт нээгдсэнд байх болно (3, х 70).
- Бясалгал хийж буй хүний сэтгэл хоосон, ярьснаа мартаж орхино. Ярьж дуусаад юу ярьснаа мэдэхгүй. Учир нь түүнд Би байхгүй, зорилго байхгүй, орчлон угаас амгалан учир юу ч хийх хэрэггүйг тэр мэднэ (3, х 219).
- Эзэн Бурханы ивээл адислалд болзоо үгүй тул байнга бясалга. Туйлбартай хичээж, дотоодын Бурхандаа залбиран, залж дэмжиж адислахыг Төгс Дээд Хүчнээс гуй (1, 245).
- Хамаг амьтанд үйлчилж буй маань өөрөө хүндтэй хэрэг, хамгийн дээд шан харамж, гавъяа мөн (1, х 260).
- Миний шавь нар янз бүр байдаг. Олонхи нь ном доройтуулагчид. Багшийгаа сайн ойлгохгүй, сэтгэлд нь итгэл гэж үгүй, тийм явцуу (6, х 336).
- Өөрт байгаа бүхэнд сэтгэл хангалуун бай.
- Гэгээнтэн шиг аягла.

## ***ШАШИН***

Нэг л шашин бий. Энэ нь Бурхантай холбогдох явдал юм (31). Шашин нь Үнэн гэж юу болохыг зөвхөн зааж өгдөг, харин хүмүүн бид эдүгээ амьд буй Багшийн тус дэмээр Үнэнийг эрж олох ёстой. Жинхэнэ багшгүй бол шашныг ч ухаарч ойлгож чадахгүй (2, х 66).

## ***ШИД***

Энэ ертөнцийг эмх замбараагүй байдалд оруулахгүйн тулд бид түүний эрч хурдтай тохируулж ажиллах ёстой учраас тэвчээртэй байдаг юм. Жишээ нь хүүхэд гүйж сураагүй байхад та хичнээн яарч, гүймээр байлаа гээд хүүхдийг бүдэрч унагаахгүй шүү дээ. Тийм учраас бид тэсвэр тэвчээртэй байх ёстой. Бидэнд гүйх чадал байсан ч хүүхэдтэйгээ алхах хэрэгтэй болно. Ийм байдаг болохоор би заримдаа цөхөрч, тэсвэр тэвчээргүй байдаг ч гэсэн өөрөө тэвчээртэй байхыг сурах хэрэгтэй болдог. Бид санхүүгийн бүрэн дэмжлэгээр нэмэр болох гэж байгаа атлаа би дүрвэгсдийн тусын тулд нэг ерөнхийлөгчөөс нөгөөд очин бөхөлзөж явдгийн учир нь энэ. Бид өөртөө байгаа бүхнээ, долларыг саяар нь, тэр байтугай тэрбумаар нь өгмөөр байдаг. Гэлээ ч гэсэн бүхий л хүнд суртлын тогтолцоог туулан гарах хэрэгтэй болно. Ёс ёмбогор, Төр төмбөгөр гэдэг. Хэрэв бид шид увдис, бодит материаллаг хүчийг хэрэглэх юм бол энэ ертөнцөд сүйрэл гамшиг авчрах болно. Бүх юм жамаараа л явах ёстой. Гэхдээ бид оюун санааны эмчилгээ, билиг билгүүн, мэдлэг ойлголтоороо хүмүүсийн ухамсрыг дээшлүүлж чадна. Үүнийг

сайн дураараа хийж, хамтран ажиллахыг хүсэх мэдлэг ухааныг бид тэдэнд өгч чадна. Ид шидийн хүчийг ашиглах биш, ингэх нь хамгийн сайн арга зам юм.

Би аж амьдралын ямар ч нөхцөлд зориудаар хэзээ ч шид уддисын хүч хэрэглэж байгаагүй. Гэхдээ бясалгагчдын эргэн тойронд ер бусын гайхамшиг зүгээр л болж байдаг юм. Энэ бол санаатайгаар бус аяндаа болдог эд. Хэрэг явдлыг яаруулж, түлхэхийг оролдох явдал биш. Тийм ээ, ингэх нь сайн зүйл биш. Хүүхэд гүйж сураагүй байна (23). Бид хүмүүст эхлээд сахилуудыг зааж сургадаг юм.

Сахил бол маш чухал. Бид хаашаа явж байгаагаа, мөн Хүч Чадлаа хааш нь чиглүүлэхээ мэддэг байх ёстой. Хайр энэрэлгүй, нигүүлсэнгүй сэтгэлгүй, ёс суртахууны үнэт чанарын зохих ойлголтгүй Хүч Чадал бол ашиг тусгүй юм. Тэр нь хар дом, муу муухай зүйл болж хувирна. Хар уддис шид эндээс гардаг юм. Тэгэхээр гэгээрэлд хүрэх нь амархан, харин түүнийг хадгалж хямгадах л хэцүү. Та манай энэ зам мөрөөр явах тэр цагтаа жинхэнэ ёсоор сахилга журамтай, ёс суртахуунтай байж чадахгүй бол таныг Хүчээ муугаар ашиглаж, нийгэмд хор хөнөөл учруулахгүйн тулд Багш энергийн чинь зарим хэсгийг буцаагаад авчихна. Ялгаа нь үүнд байгаа юм. Багш хянаж харгалзаж чадна. Энэ бол Багшийн хүч. Хүмүүс хангалттай ухаалаг биш учраас газар дэлхийг буруу ашиглах мэт зүйлс хийдэг, эсвэл зарим зүйлийг мэргэн ухаан дутсанаас болж үйлддэг юм. Тэгэхлээр үндэс суурь нь билиг ухаан, бясалгал дасгал юм (23).

### **ЭЗЭН БУРХАН**

Дотоод амар амарлингуйгаа олж авснаар бид бусад бүх зүйлийг олж авна. Сэтгэлийн бүрэн ханамж, тэнгэрлэг диваажин болоод газар дэлхийн хүсэл бүхэн биелэх нь бидний мөнхийн нийцэл зохирол, мөнхийн билгүүн ухаан, хамгийг чадагч хүчний дотоод ухаарахуй болох Эзэн Бурханы орноос ирдэг юм. Энэ бүхнээ эс олвоос бид хичнээн их мөнгө хөрөнгө, эрх мэдэлтэй, нийгэмд хичнээн өндөр байр суурьтай байлаа ч гэсэн хэзээ ч сэтгэл хангалуун болж чадахгүй.

Сургааль маань та энэ дэлхий дээр юу л хийх ёстой байна, түүнийгээ хий, хамаг зүрх сэтгэлийнхээ угаас хий. Хариуцлагатай байж, үүнийхээ зэрэгцээ өдөр бүр бясалгал хий гэдэгт оршино. Та өөртөө болон дэлхий ертөнцөд үйлчлэхийн тулд улам их эрдэм мэдлэг, улам их билгүүн ухаан, улам их амар амарлингуйг олж авах болно. Таны дотор өөрийн тань сайн сайхан чанар оршин буйг бүү март. Бие цогцост тань Эзэн Бурхан оршин буйг бүү март. Зүрх сэтгэлд тань Будда оршин буйг бүү март (23).

Эзэн Бурханыг ойлгохын тулд бид өөрсдөө Эзэн Бурхан болох ёстой юм. Би та бүгдийг эргээд Эзэн Бурхан адил оршиж, хэн шиг ч биш, өөрөөрөө бай гэж урин дуудаж байна. Эзэн Бурханыг бясалгахуй нь Эзэн Бурханд сүсэглэх гэсэн үг биш, энэ нь та өөрөө Эзэн Бурхан болно гэсэн үг. Та болон Эзэн Бурхан гэдэг бол нэг нэгдмэл зүйл гэдгийг ойлгоно (23).

### **ЭНХ ТАЙВАН**

*Үзэх: Дайн*

Энх тайван их үнээр олддог. Бүх дэлхийн ухамсрыг дээшлүүлсэн цагт энх тайван бий болно. Иймд хэн нэгэн удирдагчийг юмуу эсвэл холбоог хуруугаараа бүү чичил. Аз жаргалыг ч, зовлон гунигийг ч бүх дэлхийгээрээ л хамт хуваалцана. Бид бүгдээрээ буруутай, бүгд л хариуцлага хүлээх учиртай, эс бөгөөс бүгд хүндлүүлж, хайрлуулах ёстой. Бид бүгд буруугаа хүлээх ёстой (70).

### **ЭРХЭМ АРИУН ЧАНАР**

*Хүн, амьтан, шувууны эрхэм ариун чанар  
(Их Багш Чин Хай, 2008)*

**Хүн, амьтан, шувуу**

**Эрхэм ариун чанар, %**

<b>Хүн</b>	
Хүн төрөлхтний багахан хэсэг	90
<b>Хүн төрөлхтний дийлэнх хэсэг</b>	<b>3</b>
Хүн төрөлхтний дундаж	10
<b>Амьтан, шувуу</b>	
Үнээ	40
Нохой, заан, зэрлэг гахай, зарим шувуу	30
Хун, буга, орангутан, галуу	20
Нугас	8
Бар	4
<b>Арслан, бүргэд</b>	<b>3</b>

#### **Ашигласан эх сурвалж**

1. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд
2. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ
3. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр, боть 3
4. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Амьдрал гээч хуурмаг тоглоом, Флорида, 2002.5.11-13
5. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр, боть 1
6. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр, боть 6
7. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Парисын дияан, 2010
8. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Love is only solution for all, April 03, 2012
9. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Хоосон чанар, БНСУ, WOW 757
10. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Эхлээд Эзэн Бурханы Вант улсыг эрж ол, Сидней, 1993.3.17
11. Supreme Master Ching Hai Realization of Health, Collected Expects from Lectures
12. Ошо Гайхамшигт хүмүүстэй хийсэн уулзалтууд, УБ, 2014
13. Ошо Чинадын чинадад (Дилова хутагтын дуулал), Агнистын гэгээ цуврал, УБ, 2008
14. Ошо Очир Огтлогч судар, Агнистын гэгээ цуврал 9, УБ, 2013
15. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Коста Рикад айлдсан айлдвар, 1989.11.22
16. Ошо Зэн буюу Гэгээрэхүйн бясалгал, УБ, 2012
17. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Зэн Баг Жаожу, Олон улсын дияан, 2008.9.7
18. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Сүнслиг адислалт үүд, гарцууд болон диваажин ба тамын үүд, SM MV-ийн ажиллагсадтай хийсэн теле ярилцлага, 2011.7.2, Лос Анжелес, Калифорни
19. Зонхов Богд Бодь мөрийн зэрэг, “Гэгээрлийн зам сан”, УБ 2006
20. Supreme Master Ching Hai From the Original Universe to Our World: True Love Never Change, May 29,2014, Los Angeles, USA, California
21. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Агаараар хооллолт, бурханлиг чанар, Их Багшийн хүн төрөлхтөнд тусалдаг арга замууд, DVD 924, 2011.2.9, Лос Анжелес
22. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Бясалгал өдөр дутмын амьдрад нөлөөлөх нь, Тайланд, Патая, 2006, DVD 774
23. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр, Үлгэр дэвтэр
24. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Бурханы хайрыг олох нь бүхий л аз жаргалын эх сурвалжийг олсонтой агаар нэг, ХБНГУ, 1995.8.18, видео 566

25. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Талархлын өдрөөр SM TV-ийн ажилагсадтай хийсэн теле ярилцлага, 2009
26. Ошо Эзотерикийн сэтгэл зүй, УБ, 2012
27. Хүрэлсүх С. Шашны физик, УБ, 2007
28. Буянбат Л. Зэн бясалгалын үндэс, веб хуудас: [www.Lkhagvaa.mn](http://www.Lkhagvaa.mn)
29. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Билгийн мэлмий (The Wisdom Eye) № 721, Флорида, 2001
30. Чин Хай Багшийн айлдвараас, Агнистын гэгээ цуврал 12, УБ, 2014
31. Supreme Master Ching Hai To Be True Disciples of Master, Madrid, 2008
32. Прамахамса Йогананда Йогчийн намтар, УБ, 2011
33. Supreme Master Ching Hai The Tailor and Two Zen Masters, September 09, 2008
34. Supreme Master Ching Hai Rainbow Lady, December 26, 2008, France
35. Ошо Зам мөр-жам ёс, П.Бадралын орчуулга, Агнистын гэгээ цуврал 12, УБ, 2014
36. Нирваан, П.Бадралын орчуулга, Агнистын гэгээ цуврал 13, Төгс гэгээрсэн их багш Чин Хайн сургаалаас, УБ, 2014
37. Supreme Master Ching Hai Let God Serve Through Us, April 20, 1993, Geneva
38. Supreme Master Ching Hai The Suffering of This World Comes from Our Ignorance, Singapore, 1995, video 467
39. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Агаар хооллолт, Бурханлиг чанар, Их Багшийн хүн төрөлхтөнд тусалдаг арга замууд, 2011.2.9, Лос Анжелес, SM TV бага хурал, DVD 924
40. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Буяны тухай үнэн – түүнийг олох ба алдах нь, 2010.7.7
41. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон улсын дияан, Франц, 2012 оны 3-4 –р сар
42. Supreme Master Ching Hai Humanity's Leap To The Golden Era, Climate Change Conference, Washington DC, USA, 2011
43. Supreme Master Ching Hai Honoring All Life, Second Anniversary of SM TV
44. Supreme Master Ching Hai BMD 726
45. Supreme Master Ching Hai Saving The World Together, March 4-9, 2012, France
46. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Дэлхий дээр Диваажинг цогцлоо, Парис, 2009 DVD 876
47. Supreme Master Ching Hai Our Thinking Can Change the Universe, February 19, 2009
48. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Гэгээрэл ба мунхрал, Непал, 2000.5.1
49. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Их Багшийн жинхэнэ шавь байхуй, Испани, Мадрид, 2008
50. Supreme Master Ching Hai Love Is Important, February 14, 2009, France
51. Supreme Master Ching Hai Enlightenment is the Key to Everything, April 10, 1993, Colorado, USA, Denver
52. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон улсын дияан, New York, Aug.9, 1999
53. Supreme Master Ching Hai The Realization of Health, 2006, s 141
54. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Яагаад бид энд байна вэ, Аукланд, Шинэ Зеланд, 2002.4.27
55. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Аялгууны бясалгалын хүч, Хонолулу, Хавай, АНУ, 1993.10.22
56. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Бурханыг таних нь хүний амьдралын зорилго, Брисбейн, Австрали, 1993.3.22
57. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Авшиг хүртэх бол орчлонгийн хамгийн үнэт бэлэг мөн, Флорида, 2001.6.11
58. Бясалгалаар өөрсдийгээ адисла, Флорида, АНУ, 2002.12.25
59. Бясалгалын үр шим, Яангдон төв, БНСУ, 1998.5.9
60. Бясалгалын зорилго бол өөрийгээ таньж дотоодын амар амгаланд хүрэх явдал, Шихү төв, Формоса, 1995.6.19
61. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Гимлайн нуруунд бясалгасан нь, 4-р боть
62. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Моломын үүсвэр, 4-р боть
63. Supreme Master Ching Hai We Cannot Become a Saint Without a Loving Heart, International Gathering in Europe, December 17, 2008

64. Supreme Master Ching Hai Be Selfless and Unconditional All the Time, Cancún, Mexico, December 9, 2010 (DVD#923)
65. Supreme Master Ching Hai Motive Behind Our Action, December 06, 2008, France
66. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай SM ажиллагсадтай хийсэн ярилцлага, 2010.07.07, Франц
67. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Дэлхийг дэвшүүлэхүй, 2012.4.7, Франц
68. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Францын даяан, 2009.02.17
69. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Авшиг бол сая жилд ганц тохиох боломж юм ХБНГУ, Гамбург, 1995.8.25-27
70. Supreme Master Ching Hai New videoconference with Supreme Master Ching Hai reveals hidden truths about war, July 16,
71. Supreme Master Ching Hai How to govern the country, September 08, 2008
72. Supreme Master Ching Hai The Blessing of heartfelt gratitude, Cancún, Mexico, December 16, 2010, (DVD #923)
73. Supreme Master Ching Hai How to Get the Most Blessings, <http://www.suprememastertv.com/tw/blessings/>
74. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай "Биднээр дамжуулан үйлдэхийг Бурханд зөвшөөрчих, 1993, Женев
75. Supreme Master Ching Hai Be One with God and Heaven at All Times, A Special Gathering with Supreme Master Ching Hai, Compiled by USA News Group, <http://www.godsdirectcontact.org.tw/>
76. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Будда хэрхэн эгэл хүн болох вэ, 1988 он, 4-р боть
77. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Орчлонгийн дээд бүсүүдэд хийсэн айлчлал, радио ярилцлага, Лос Анжелес, Калифорни, 2013.06.16
78. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай НҮБ, Бурханы оронд гэгээрлээр дамжиж хүрнэ, видео 157, 1991.03.06
79. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай SM TV ярилцлага, 2010.08.01.
80. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Гэгээрэл бол хүрч болшгүй зүйл биш, 1993.11.27, Сан Франциско
81. Supreme Master Ching Hai We are originaly pure, January 07, 2009
82. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай SM TV ярилцлага, 2012.01.02
83. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Тайландын даяан, 2008